

БҮЛЭГ	АГУУЛГА	Хуудасны дугаар
<b>НЭГ</b>	<b>ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>3</b>
	1.1. ОРШИЛ	3
<b>ХОЁР</b>	<b>АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>3</b>
	2.1. АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫН ХЯНАЛТЫН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 3 ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	
	2.2. АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫН ХЯНАЛТЫН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ 7 АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ЗӨВЛӨМЖ	
	2.3. ДААЦ ХЭТЭРСЭН ТЭЭВЭРЛЭЛТИЙГ БУУРУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ	10
	2.4. АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ, БОЛОВСРУНГУЙ БОЛГОХ ҮЙЛ 12 АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР	
	2.5. ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫГ ХЯНАХ СТРАТЕГИЙН БАЙРШЛУУД	21
	2.6. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫГ ТАЛБАЙ ДЭЭР ХЭМЖИХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЗААВАР	31
<b>ГУРАВ</b>	<b>ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫН ХЭТРЭЛТ АВТО ЗАМД УЧРУУЛАХ ХОХИРЛЫГ ТООЦОХ</b>	<b>52</b>
	3.1. АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛАЛ ХЭТЭРСНЭЭС АВТО ЗАМД УЧРУУЛАХ ХОХИРЛЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ	52
	3.2. АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛАЛ ХЭТЭРСНЭЭС УЛСЫН ЧАНАРТАЙ ЗАРИМ ЗАМУУДАД УЧИРАХ ХОХИРЛЫН ТООЦОО	66
<b>ДӨРӨВ</b>	<b>ДҮГНЭЛТ</b>	<b>74</b>
<b>ТАВ</b>	<b>ХАВСРАЛТУУД</b>	<b>78</b>
Хавсралт 1	ХЭРЭГСЛИЙН БҮХ ЖИН, ТЭНХЛЭГИЙН 80 АЧААЛАЛ ХЭМЖИХ ЗААВАР	
Хавсралт 2	СУРГАЛТЫН МАТЕРИАЛ	94
Хавсралт 3	Хавсралт 5	ЖУРМЫН ТӨСӨЛД ОРУУЛАХ САНАЛ ЗӨВЛӨМЖ
Хавсралт 4	Хавсралт 6	АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН

АЧААЛЛЫН ХЯНАЛТЫН ТАЛААРХ ГАДААД ОРНЫ САЙН ТУРШЛАГААС	105 114
АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МАСС, ТҮҮНИЙ НЭР ТОМЬЁО	141
АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ (АВТОМАШИН)-ИЙН ТӨРӨЛ, ХАМГИЙН ИХ МАССЫН ТУХАЙ ТАЙЛБАР	143

БҮЛЭГ	АГУУЛГА	Хуудасны дугаар
Хавсралт 7	MNS 4598:2020 “АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН БАЙДАЛД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” СТАНДАРТЫН ЗАРИМ ЗААЛТЫН ТАЙЛБАР, ЗӨВЛӨМЖ	148
Хавсралт 8	ХҮНД ЖИНТЭЙ БА (ЭСВЭЛ) ТОМ ОВРЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АВТОЗАМААР ЗОРЧИХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ ЖУРМЫН ТӨСӨЛ	161
Хавсралт 9	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛАЛ ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ	163
Хавсралт 10	РЕДАКЦИЙН АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН САНАЛ ДҮГНЭЛТ АШИГЛАСАН МАТЕРИАЛ АЖЛЫН ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ	

## НЭГ. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 1.1 ОРШИЛ

Зам, тээврийн хөгжлийн төвтэй 2020.09.30-ны өдөр байгуулсан “Автомашин тэнхлэгийн ачаалал авто замд нөлөөлөх нөлөөллийг тооцох судалгаа” (ЗТХТ/202005019) сэдэвт зөвлөх үйлчилгээ үзүүлэх төслийн хүрээнд энэхүү эцсийн тайланг боловсруулсан болно.

Төслийн хүрээнд авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллын хяналтыг сайжруулах, боловсронгуй болгох үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах, улсын чанартай авто замд тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирлыг тооцох заавар боловсруулах зэрэг ажлууд хийгдлээ.

## ХОЁР: АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1 АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫН ХЯНАЛТЫН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улсын эдийн засаг өсөж, үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаа эрчимжихийн хэрээр авто замаар тээвэрлэх ачаа тээврийн эрэлт хэрэгцээ өссөөр байна. Үүнтэй зэрэгцэн ачаа барааг цөөн тооны тээвэрлэлтээр гүйцэтгэх сонирхол бизнес эрхлэгчдэд бий болж, улмаар авто тээврийн тухай хуулинд заасан 44 тонноос илүү жин бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэлт хийх үзэгдэл цөөнгүй гарах болж байна. Энэ нь нийтийн хэрэгцээний зориулалтаар баригдсан авто замын ашиглалтын нөхцөлийг эрс муутгах, замын насжилтыг богиносгох, засвар шинэчлэлтийн зардалыг өсгөх зэрэг сөрөг үр дагавар дагуулж байгаа тул энэхүү үйл ажиллагааг хянан зохицуулах шаардлагыг бий болгож байна.

ЗТХЯ нь зөвлөхийн дэмжлэгтэйгээр "Авто замын талаар баримтлах бодлого, 2019 оны 3-р сард гаргасан үнэлгээний тайлан"-г боловсруулсан боловч, энэхүү баримт бичгийг орон даяар мөрдүүлэх ажил хийгдэж байгаа эсэх нь тодорхой бус байна. Авто замын талаар баримтлах бодлого нь дараах гурван дэд бодлогын талаарх мэдээллийг агуулсан байна. Үүнд: (а) Авто замын аюулгүй байдлын үндэсний стратеги, 2012-2020 он, (б) Авто тээврийн талаар төрөөс баримтлах бодлого 2018- 2026 он; (в) Авто замын талаар төрөөс баримтлах бодлого 2019-2026, харин тэнхлэгийн ачааллыг хянах бодлого, тэнхлэгийн ачааллыг хянах стратегийн талаар энэхүү баримт бичигт тодорхой тусгаагдаагүй байна. Харин “Монгол улсын Дунд хугацааны (2020-2025) тогтвортой Хөгжлийн Бодлогын Тэргүүлэх Чиглэл”<sup>1</sup> бодлогын бичиг баримтад Авто тээврийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүдэд Зорилт 2. Зориулалтын, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр үйлчлэх зорилт тавьсан байна /1-р зураг/.

#### **Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Авто тээврийн үйлчилгээний чанар, стандартын түвшинг дээшлүүлэх**

Зорилт 1. Үнэ, тарифын уян хатан бодлого баримтлах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Зориулалтын, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр үйлчлэх (Хэлэлцүүлгээс болон МУТХҮБ-2030).

Зорилт 3. Тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн санхүү, үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх (Хэлэлцүүлгээс).


1- р зураг. “Монгол улсын Дунд хугацааны (2020-2025) тогтвортой Хөгжлийн Бодлогын Тэргүүлэх Чиглэл”<sup>2</sup> бодлогын бичиг баримтад Авто тээврийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

<sup>1</sup> <http://nda.gov.mn/backend/f/tailan3.pdf> Монгол улсын Дунд хугацааны (2020-2025) тогтвортой Хөгжлийн Бодлогын Тэргүүлэх Чиглэл тайлангийн 45-р хуудас.

<sup>2</sup> <http://nda.gov.mn/backend/f/tailan3.pdf> Монгол улсын Дунд хугацааны (2020-2025) тогтвортой Хөгжлийн Бодлогын Тэргүүлэх Чиглэл тайлангийн 45-р хуудас.

2013 онд даац хэмжих 34 цэгийг 2014-2015 онуудад шинээр байгуулахаар төлөвлөж улмаар Засгийн газраар хэлэлцүүлэн 2014 оны 10 дугаар сарын 4-ний 51 дүгээр хуралдааны тэмдэглэлд "... авто тээврийн хэрэгслийн жин, овор хэмжээнд тавих хяналтыг эрчимжүүлэн боловсронгуй болгох, шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах замаар шийдвэрлэх..." гэж тусгагдсан боловч хэрэгжилт нь хангалтгүй байгаа болно.

Авто замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллын хяналт, удирдлагын үйл ажиллагааг дараах бүтэц зохион байгуулалттайгаар явуулж байна.



2-р зураг. Авто замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллын хяналт, удирдлагын бүтэц, зохион байгуулалтын схем

Өнөөдөр авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг хянах удирдлагыг ЗТХЯ-ны Авто замын Бодлогын Хэрэгжилтийг Зохицуулах Газар, Авто тээврийн Бодлогын Хэрэгжилтийг Зохицуулах Газрууд хариуцан, тэдгээрийн удирдлагын дор ЗТХТ хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. ЗТХТ-ийн Зам Ашигласны Төлбөр Хураах цэгүүдэд Авто замын ашиглалтын мэргэжилтэн, Авто тээврийн байцаагч, Тээврийн Цагдаа нарын хамтын ажиллагаагаар тээврийн хэрэгслийн овор хэмжээ, тэнхлэгийн ачаалалд хяналт шалгалт явуулж байна. Тэнхлэгийн ачаалал хэтрүүлсэн зөрчилд арга хэмжээ авах, давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагааны хэрэгжүүлэлт одоогоор хангалттай уялдаа холбоогүй, нэгдсэн хяналт, зохицуулалт сайнгүй байгаа бөгөөд ажлын үр дүн хангалтгүй байгаа болно.

Авто тээврийн тухай хууль, MNS 4598:2011 ... стандартад авто тээврийн хэрэгслийн овор хэмжээ, бүх жин, тэнхлэгийн ачаалалд тавих зөвшөөрөгдөх хэмжээ, хязгаар тусгагдсан бөгөөд энэхүү үзүүлэлтийг бусад улс орныхтой харьцуулахад олон улсын үзүүлэлтүүдтэй тэнцүү, эсвэл ойролцоо байна. Доорх хүснэгтэд манай орны хоёр хөрш улс болон Европын Холбооны улсуудад авто тээврийн овор хэмжээ, бүх жин, тэнхлэгийн ачаалалд тавигддаг зөвшөөрөгдөх хэмжээг үзүүлээ.

1-р хүснэгт: Тээврийн хэрэгслийн бүх жин, тэнхлэгийн ачаалалд тавигддаг зөвшөөрөгдөх хэмжээ

Улсын нэр	Зөвшөөрөгдөх бүх /нийт/ жин, тонноор		Тэнхлэгийн зөвшөөрөгдөх ачаалал, тооноор	
	Дан автомашинк	Угсраа автомашин	Дан автомашин	Угсраа автомашин
БНХАУ	31.00	49.00	24.00	11.5
Монгол улс	-	44.00	-	11.5
ОХУ	35.00	44.00	26.00	11.5
Европын Холбооны улсууд	32.00	44.00	24.00	11.5

Эх сурвалж: <https://www.unescap.org/sites/default/files/Chapter02.pdf>


2-р хүснэгт: Тээврийн хэрэгслийн овор хэмжээнд тавигддаг зөвшөөрөгдөх хэмжээ

Улсын нэр	Зөвшөөрөгдөх өргөн, мм	Зөвшөөрөгдөх өндөр, мм	Зөвшөөрөгдөх урт, мм	
			Rigid truck	Угсраа автомашин
БНХАУ	2 550	4 000	12 000	20 000
Монгол улс	2 550	4 000	12 000	18 750
ОХУ	2 550	4 000	12 000	20 000
Европын Холбооны улсууд	2 550	4 000	12 000	18 750

Эх сурвалж: <https://www.unescap.org/sites/default/files/Chapter02.pdf>

Судалгааны ажлын тайланд Евро-Азийн авто замын сүлжээ дайран өнгөрч буй улс орнуудын авто тээврийн хэрэгслийн бүх жинд тавигдах зөвшөөрөгдөх үзүүлэлтүүдийг харьцуулан дүгнэсэн байна.

Figure 3 Eurasian Transport Corridor (road routes only)



Source: Comprehensive Planning of Eurasian Transport Corridors to Strengthen the Intra- And Inter-Regional Transport Connectivity. Study Report 2017 (ESCAP, 2017)

2-р зураг. Евро-Азийн авто замын сүлжээ.

Figure 4 Route of the case study 1: Eurasian Northern Corridor



Source: Comprehensive Planning of Eurasian Transport Corridors to Strengthen the Intra- And Inter-Regional Transport Connectivity. Study Report 2017 (ESCAP, 2017)

3-р зураг. Евро-азийн авто замын сүлжээний Зүүн чиглэлийн коридорын схем.

Монгол улсад тавигддаг үзүүлэлт нь эдгээр улс орны үзүүлэлттэй ойролцоо байгаагаас үзэхэд манай улсад тавигддаг хэмжээ нь олон улсын шаардлагад нийцэж байгааг нотолж байна.

3-р хүснэгт: Тээврийн хэрэгслийн овор хэмжээнд тавигддаг зөвшөөрөгдөх хэмжээ

Улсын нэр	Зөвшөөрөгдөх бүх /нийт/ жин, тонноор		Тэнхлэгийн зөвшөөрөгдөх ачаалал, тооноор	
	Дан автомашин	Угсраа автомашин	Дан автомашин	Угсраа автомашин
БНХАУ	31.00	49.00	24.00	11.5
Монгол улс	-	44.00	-	11.5
Киргизстан	32.00	44.00	26.00	11.5
Тажикстан	-	40.00	22.50	10.0
Узбекстан	32.00	44.00	24.00	11.5

Туркменстан	-	36.00	22.00	10.0
Азербайжан	32.00	44.00	24.00	10.0
Армен	24.00	44.00	24.00	11.5
Турк	32.00	44.00	24.00	11.5
Европын Холбооны улсууд	32.00	44.00	24.00	11.5

Эх сурвалж: <https://www.unescap.org/sites/default/files/Chapter02.pdf>

Сүүлийн үед автомашины даац хэтрэлээс шалтгаалсан авто замын эвдрэл хурдацтай өсөх тохиолдол нилээд гарч байна. Үүнд нь хууль зөрчигчид оногдуулах торгуулийн хэмжээ бага, байгаа нөлөөлж байна хэмээн үзэж байна. Торгуулийн хэмжээ нь улс орон бүрт харилцан адилгүй байна. 4-р хүснэгтэд улс орнуудын авто тээврийн даац хэтрэлтэнд ногдуулах торгуулийн хэмжээг үзүүлээ.

*4-р хүснэгт: Улс орнуудын авто тээврийн даац хэтрэлтэнд ногдуулах торгуулийн хэмжээ*

Улс орон	Хувь хүнд тавих торгууль (хамгийн их)	Ам.доллар /2016.10.01-ны байдлаар/	Хуулийн этгээдэд тавих торгууль (хамгийн их)	Ам.доллар /2016.10.01-ны байдлаар/
Монгол	182000 <sup>3</sup> MNT	65.9	382000MNT	153.8
БНХАУ	2000 RMB	282.0	2000 RMB	282.0
ОХУ	10 000 <sup>4</sup> RUB	134.5	500 000 RUB	6717.5
АНУ	125 USD	125	208 USD	208
Австрали	7700AUD	5832.08	110000AUD	83315.5
Их Британи	300GBP	372.8	300GBP	372.8
Казакстан				
Өмнөд Солонгос				

Монгол улсад торгуулийн хэмжээ нь ердөө 50 000 төгрөгөөс 150 000 төгрөг хүртэл байдаг. Энэ нь автомашины тэнхлэгийн ачаалал хэтрэлтийг бууруулахаар гаргах хүчин чармайлтанд хангалттай хөшүүрэг болохгүй байна. Торгуулийн хэмжээг нэн даруй зөвшөөрөгдсөн хэмжээнээс (тонн тутамд 0.5 сая төгрөг) нэмэгдүүлэн тонн тутамд 200 ам.долларт хүргэх хэрэгтэй хэмээн бид үзэж байгаа болно.

## 2.2 АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫН ХЯНАЛТЫН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ЗӨВЛӨМЖ

<sup>3</sup> Ачааг 30 хувиар хэтэрсэн гэж тооцвол

<sup>4</sup> Ачаа 10 хувиар хэтэрсэн тохиолдолд,



2019 онд боловсруулсан Авто замын бодлогын үнэлгээний тайлан, 2021 онд гаргасан ТА 9544 – MON: Авто замын засвар арчлалт, Үндсэн хөрөнгийн менежментийн талаар бодлогын зөвлөгөө өгөх ба чадавхийг бэхжүүлэх нь төслийн тайлан <sup>5</sup>зэргийг үндэслэн Авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллын хяналтын удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааны чиглэлээр дараах зөвлөмжийг санал болгож байна.

Бодлогын хүрээнд:

1. “Авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг хянах Зөвлөх хороо” байгуулах;
2. Бодлого, стратеги боловсруулах;
3. Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх журам, тогтоол боловсруулах;
4. Олон нийтийн мэдлэг, хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах;

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

1. ЗТХЯ-нд Тээврийн хэрэгслийн ачааллын хяналтыг хариуцсан мэргэжилтэн ажиллуулах /орон тоо бий болгох/;
2. Дүрэм, журам, тогтоол боловсруулах;
3. Хууль сахиулах, ажиллуулах;
4. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх;

Хяналтын үйл ажиллагааны хүрээнд:

1. Улсын чанартай болон орон нутгийн авто замын сүлжээн дэх Тэнхлэгийн ачаалал хянах цэгүүдийн дэд бүтцийг сайжруулах /цахимжуулах/;
2. Тэнхлэгийн ачаалал хянах цэгүүдийн тоног төхөөрөмжийг автоматжуулах;
3. Хүний нөөцийг чадавхижуулах;

Дээр дурдсан зөвлөмжийн хүрээнд гүйцэтгэх үйл ажиллагааг дэлгэрэнгүй тайлбарлавал:

#### БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

*“Авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг хянах Зөвлөх хороо” байгуулах;*

Олон улсын туршлагаас үзэхэд сонирхолын бүлгүүдийн төлөөллөөс бүрдсэн “Зөвлөх Хороо” байгуулж, тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг хянан зохицуулах бодлого, хууль тогтоомжинд зөвлөмж өгөх, хөтөлбөр, төлөвлөгөөнд санал зөвлөмж өгөх, төр ба хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах асуудлыг эрхүүлдэг байна. Энэ туршлагыг нэвтрүүлэн ЗТХЯ-ны дэргэд “Авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг хянах Зөвлөх Хороо” байгуулах, уг хорооны бүрэлдэхүүнд дараах салбар, яамд, нэгжүүдээс төлөөлөл оруулахыг зөвлөж байна. Үүнд:

- Авто замын ашиглалт хариуцсан мэргэжилтэн;
- Авто тээврийн хяналт хариуцсан мэргэжилтэн;
- Хувийн хэвшлийн тээвэр зуулчлалын компаний төлөөлөл;
- Худалдаа үйлдвэрлэлийн салбарын төлөөлөл;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төлөөлөл;
- Хууль зүйн яамны төлөөлөл;
- Сангийн яамны төлөөлөл;
- Эдийн засаг, Хөгжлийн яамны төлөөлөл;

Энэхүү “Зөвлөх Хороо”-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг доорх бүдүүвчээр үзүүлэв.

<sup>5</sup> ТА9544 – MON: Policy advice and capacity building on road maintenance and asset management



#### 4-р зураг. Зөвлөх хорооны үйл ажилдлагааны чиглэл

Энэхүү Зөвлөх Хороог байгуулан ажиллуулах эрх зүйн үндэс нь Авто замын тухай хуулийн дараах хоёр заалт байж болно. Үүнд:

1. Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйл. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх-д заасан 10.1.9.олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын ашиглалт, засвар, арчлалтын ажлыг нэгдсэн бодлого, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангуулах; гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн тулд Улсын холбогдох салбар, яамдын хөгжлийн бодлого, ачаа тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг уялдуулах бодлого боловсруулах эрх мэдэл бүхий төлөөллөөс бүрдсэн Зөвлөх Хороог байгуулан, хуулинд заасан “... авто замын ашиглалт ажлыг нэгдсэн бодлого, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж” ажиллах;
2. Авто замын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан “Авто замын Зөвлөл”-ийг “тэнхлэгийн ачаалал хэтрэлттэй холбоотой асуудал” шийдвэрлэх тохиолдолд өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй байхаар зохион байгуулж болох юм.

*Бодлого, стратеги боловсруулах;*

Улс орны хөгжлийн чиг хандлага, дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, уул уурхайн болон худалдаа үйлдвэрлэлийн салбаруудын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааг үр ашигтай, аюулгүй, замын сүлжээнд хор хөнөөлгүй явуулах, тээврийн хэрэгслийн овор хэмжээ, тэнхлэгийн ачааллын хяналтыг боловсронгуй болгох, тэнхлэгийн ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслээс авах торгуулийн хэмжээг бодиттойгоор тогтоох, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх зэрэг асуудлыг хамарсан бодлогын бичиг баримт, хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулахыг зөвлөж байна.

*Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх журам, тогтоол боловсруулах;*

Тэнхлэгийн ачаалал нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгслээс авах торгуулийн болон нөхөн төлбөрийн хэмжээг тухайн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөгөөр замд учирсан хохирол, гэмтэлийн нөхөн сэргээлтийн ажлын зардлаар тооцон тогтоож, торгуулийг “Авто замын сан”-д хуримтлуулан, замын засварын ажилд зарцуулах журам боловсруулан хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

#### УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:

*Авто замд тээврийн хэрэгслийн ачаалал хэтрэлтийн үзүүлэх нөлөөг хянах асуудлыг хариуцсан мэргэжилтэнг ЗТХЯ-нд ажиллуулах /орон тоо бий болгох/;*

Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтэрснээс хамгийн ихээр хохирч байгаа нь авто замын байгууламж юм. Одоогоор энэ их хохирч буй авто замын сүлжээг хамгаалах, урьдчилан сэргийлэх, нэгэнт эвдэрсэн бол хариуцлага тооцох асуудлыг Авто замын салбарт эрхэлсэн албан тушаалтан

/мэргэжилтэн/ байхгүй байгаагаас төрийн системтэй, байнгын үйл ажиллагаа тасалдаж байна. Иймд ЗТХЯ-ны АЗБХЗГ-т тээврийн хэрэгслийн ачаалал хэтрэлтийн авто замд үзүүлэх нөлөөг хянах асуудлыг хариуцсан мэргэжилтэнг ажиллуулах шинэ орон тоог бий болгон “Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийг бууруулах” бодлого, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үүнтэй холбоотой үйл ажиллагааг системтэйгээр зохион байгуулах, зохицуулах ажиллагааг хариуцуулахыг зөвлөж байна. Ингэснээр тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн улмаас доройтсон авто замын сүлжээний нөхцөл байдлыг тодорхойлох, шаардагдах хөрөнгө оруулалтыг тогтоох, тээврийн хэрэгслээс авсан торгууль хураамжийн төлөгдөлт, хуулийн хариуцлагын биелэлт, “Авто замын сан”-д бүрдсэн хуримтлал, зарцуулалтыг хянан зохицуулах, холбогдох хууль, журам, тогтоолын хэрэгжилт, тэдгээрийн шинэчлэлтийн асуудал, олон нийтийн сурталчлах асуудал зэргийг байнга тасралтгүй явуулах боломжтой болно.

Бүтцийн схем оруулах

*Дүрэм, журам, тогтоол боловсруулах;*

Авто замын сүлжээг тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор дараах чиглэлээр дүрэм журам боловсруулах, шинэчлэх шаардлагатай байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг хэмжиж тогтоох журам;
- Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн хослол, ачааллын хэтрэлтийн хувь хэмжээ тус бүрд тооцсон торгууль тогтоох журам;
- Үл задрах ачаа бүхий тээврийн хэрэгсэлд хөдөлгөөнд орох тусгай зөвшөөрөх олгох, маршрут тогтоох журам;
- Хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн улирлуудад /хавар, намрын чийг хуримтлагдах цаг үед/ хязгаарлах журмын заалт;

*Хууль сахиулах, ажиллуулах;*

Хуулинд заасан зөвшөөрөгдөх хэмжээг хэтрүүлсэн хуулийн этгээдэд (хувь хүн, байгууллага) тавьсан хуулийн арга хэмжээний хэрэгжилт, торгууль нөхөн төлбөрийн төлөлтийг хуулинд заасан хугацаанд хураах авах, зөрчил дахин давтахаас урьдчилан сэргийлэх, хууль сахиулах арга хэмжээг сонирхогч байгууллага болон олон нийтэд таниулах ажлыг тасралтгүй байнга явуулахын тулд эдгээр үйл ажиллагааг ЗТХЯ-ны АЗБХЗГ-азарт шинээр ажиллах (тээврийн хэрэгслийн ачаалал хэтрэлтийн авто замд үзүүлэх нөлөөг хянах асуудлыг хариуцсан) мэргэжилтэний ажил үүргийн тодорхойлолтод зааж өгөхийг зөвлөж байна.

“Зөвлөх Хороо”-гоор хуулийн заалтын шинэчлэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлж санал авах,

*Төр ба хувийн хэвшилийн түншлэлийг хөгжүүлэх;*

Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийг бууруулах, ачаа тээвэрлэлтийг үр ашигтай, хэмнэлттэйгээр хэрэгжүүлэхийн тулд ЗТХЯ, ЗТХТ, Хууль зүйн яам, Сангийн яам, Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам, Хүнс, Хөдөө аж ахуйн, Хөнгөн үйлдвэрийн яам, тээвэрлэгч, тээвэр зуучлалын байгууллага зэрэг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй юм. Үүний тулд өмнө дурдсан “Зөвлөх Холбоо”-г сонирхогч талуудын төлөөллөөс бүрдүүлэн, бодлогын болон үйл ажиллагааны асуудалд санал зөвлөмж авч ажиллахыг санал болгож байна.

#### ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

*Улсын чанартай болон орон нутгийн авто замын сүлжээн дэх Тэнхлэгийн ачаалал хянах цэгүүдийн дэд бүтцийг сайжруулах /цахимжуулах/;*

Улсын чанартай авто замуудаас гадна орон нутгийн гол замуудад Тэнхлэгийн ачаалал хянах цэгүүдийг шинээр байгуулах хэрэгтэй бөгөөд ийм цэгүүдийн хэмжих үйл ажиллагааг автоматжуулахаас гадна хэмжилтийн мэдээллийг хадгалах, дамжуулах процессыг цахимжуулж, хүний нөлөөлөлд өртөхгүй байх нөхцөлийг хангах хэрэгтэй байна. Ингэснээр Хянах цэгүүдийн ажилчдын ажиллах хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, үнэн бодит мэдээлэл цуглуулах, мэдээлэл олон талын дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх зэрэг ач холбогдолтой болох юм.

*Тэнхлэгийн ачаалал хянах цэгүүдийн тоног төхөөрөмжийг автоматжуулах;*

Авто пүүний төлөвлөлт, дизайныг шинэчлэх шаардлагатай байна:

Зам эвдэрсэн гол шалтгаан нь тээврийн хэрэгслийн нийт жингээс илүү тэнхлэгийн ачаалал юм. Одоо байгаа пүүнүүд нь зөвхөн бүх жинг хэмжих боломжтой бөгөөд тоног төхөөрөмжийн дутагдалаас болж тэнхлэгийн ачааллыг хэмжих боломжгүй тул эдгээр пүүг тэнхлэгийн ачааллыг хэмжихийн тулд шинэчлэх шаардлагатай байна. Энэ нь зураг төсөл, зохион байгуулалтын төлөвлөгөө, нэмэлт төсөв шаардагдах орчин үеийн нэмэлт тоног төхөөрөмжийг өөрчлөх шаардлагатай болно.

*Хүний нөөцийг чадавхижуулах;*

Тэнхлэгийн ачаалал хэтрэлтийг хянах үйл ажиллагааг хэрэгжүүлж буй инженер техникийн ажилчдын мэдлэг чадварыг дараах чиглэлээр дээшлүүлэх сургалт, семинар зохион байгуулах, туршлага солилцох сургалтыг жилд нэгээс цөөнгүй удаа явуулж байхыг санал болгож байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийг хянах хууль эрх зүйн үндэс;
- Жин хэмжүүрийг тохируулах, ашиглалтын хэвийн ажиллагааны арчлалт;
- Бүх төрлийн жин (орчин үеийн тоног төхөөрөмж) ашиглан тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал (тэнхлэгийн бүх төрлийн хослолын ачааллыг үнэн зөв хэмжин тодорхойлох) хэмжих;
- Тоног төхөөрөмжийн болон компьютерын программ хангамж ашиглан хэмжилт хийх, цахим мэдээлэл хадгалах, дамжуулах;
- Мэдээллийн менежмент болон тайлагналт;
- Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн авто замд үзүүлэх нөлөөллийг тооцон үнэлэх;
- Хөдөлмөр хамгаалал ба хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

### 2.3 ДААЦ ХЭТЭРСЭН ТЭЭВЭРЛЭЛТИЙГ БУУРУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн хяналтын үйл ажиллагааг дараах хуулийн заалтуудаар зохицуулж байна.

Авто замын тухайн хуулинд:

- 1) Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгад 23.3.7-д авто замаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү овор, даацтай тээврийн хэрэгсэл зорчихоос урьдчилан сэргийлэх, хяналт тавина гэж заасан байна.
- 2) Уг хуулийн 29.3.5-д авто зам ашиглагч тухайн авто замын үзүүлэлтээс хэтэрсэн овор, хэмжээ, даацтай тээврийн хэрэгсэл зорчуулахыг хориглоно гэж заасан байна.

Авто тээврийн тухайн хуулинд:

- 3) Авто тээврийн тухайн хуулийн 10.2.5-д тээвэрлэгч нь авто зам, замын байгууламжийг техникийн нөхцөл шаардлагын дагуу ашиглах 10.2.6-д авто тээврийн хэрэгслийн хэрэглээний стандартын үзүүлэлт, шаардлагыг хангах гэж заасан байдаг.
- 4) Уг хуулийн 20.1-т авто тээврийн салбарын үйл ажиллагаанд тавих авто тээврийн хяналт, шалгалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гадна тээврийн улсын байцаагч хэрэгжүүлнэ гэж заасан байна.
- 5) Уг хуулийн 23.1-р зүйлд энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухайн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байна.

Зөрчлийн тухайн хуулинд:

- 6) Зөрчлийн тухайн хуулийн 14.4-р зүйлийн 2.4-д “Авто зам, замын байгууламжийг ашиглагч тусгай хамгаалалтгүй, эсхүл зөвшөөрөлгүйгээр гинжит, эсхүл тухайн авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын үзүүлэлтээс хэтэрсэн овор, даацтай тээврийн хэрэгслээр авто замаар зорчсон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан байна.
- 7) Уг хуулийн 14.5-р зүйлийн 20-д “Авто зам, замын байгууламжаар зорчих, тээвэрлэлт хийхдээ стандарт, норм, дүрэм зөрчиж нэг тэнхлэг дээрх, эсхүл нийт жинг хэтрүүлсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан байна.

Эрүүгийн хуулинд:

- 8) Эрүүгийн тухайн хуулийн 7.9-р зүйлийн 1-д “Авто зам, замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, эсхүл хүний амь нас хохирсон, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, 2-д “Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ” гэж заасан байна.

Хуулийн хэрэгжилт, өнөөгийн нөхцөлд гарч буй зөрчил, хүндрэлтэй асуудал, олон улсын туршлага зэрэгт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хуулинд дараах нэмэлт, өөрчлөлт оруулахыг санал болгож байна.

Авто замын тухайн хуулинд доорх заалтуудыг нэмж оруулахыг санал болгож байна:

- Авто замын тухайн хуулийн 23.3.7-д авто замаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү овор, даацтай тээврийн хэрэгсэл зорчихоос урьдчилан сэргийлэх, хяналт тавина гэсэн заалтанд нэмэлт оруулж “Хяналтаар илэрсэн зөрчлийн авто замд үзүүлэх хохирлыг авто замын төрийн байгууллагаас баталсан журмаар тодорхойлж, нөхөн төлбөрийг гаргуулна. Энэхүү хохирлын нөхөн төлбөрийг авто замын санд хуримтлуулан, замын засвар арчлалтын үйл ажиллагаанд зарцуулна.” гэж зааж өгөх;

Авто тээврийн тухай хуулинд доорх заалтуудыг нэмж оруулахыг санал болгож байна.

- Тэнхлэгийн ачааллын хэмжилт, хяналтаас зугтсан, чиглэлээ өөрчилсөн тээврийн хэрэгслийн жолоочид торгууль тавих, шийтгэл оногдуулах;
- Зөрчил гаргасан этгээдэд торгууль, шийтгэл, нөхөн төлбөрийг шүүх хуралдаангүйгээр оногдуулан авах;
- Бүх торгууль, нөхөн төлбөрийг төлж, ачааг хуулинд заасан хязгаарт тохируулан багасгах хүртэл тээврийн хэрэгслийг саатуулах;


Зөрчлийн тухай хуулинд доорх заалтуудыг нэмж оруулахыг санал болгож байна.

- Хэрэв авилга илэрсэн бол жингийн оператор, компаниудад эрүүгийн хэрэг үүсгэж, дор хаяж 18 сар баривчлах ял оноох;
- Зөрчлийн хуулийн дагуу торгуулийн хэмжээ нь ердөө 50 000 төгрөгөөс 150 000 төгрөг хүртэл байдаг. Энэ нь зөрчил үйлдэгч этгээдэд хууль зөрчсөн үйлдлийг ойлгуулахаар үр дүнтэй болж чадахгүй, ач холбогдолгүй байгаа нь тэнхлэгийн ачаалал хэтрэлтийг бууруулах хүчин чармайлт гаргах ямар ч хөшүүрэг болохгүй байна. Торгуулийн хэмжээг хэтэрсэн тонн тутамд тооцдог байхаар өөрчлөх саналтай байна. Олон улсын жишгээс үзэхэд хэтэрсэн тонн тутамд торгууль төлдөг байна.

#### 2.4. АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ, БОЛОВСРУНГУЙ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР


Авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллын хяналтыг сайжруулах, боловсрунгуй болгох үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсрууладаа дараах стратегийг /5-р зураг/ харгалзан, даац хэтрүүлэлтийг хэрхэн хянах асуулыг цогцоор /6-р зураг/ нь авч үзэх ёстой.

5- р зураг: Даац хэтрүүлэлийг бууруулах стратегийн үндсэн элементүүд



Эх сурвалж: Зөвлөх

6-р зураг: Тээврийн хэрэгслийн даац хэтрүүлэлтийг хянах цогц асуудал



5- р хүснэгт: Авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллын хяналтыг сайжруулах, боловсронгуй болгох үйл ажиллагааны хөтөлбөр

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвлөмж	Авах арга хэмжээ буюу үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага
Нэг	Бодлого боловсруулах, эрх зүйн орчинг сайжруулах			2021-2023	ЗТХЯ ЗТХТ
1.1	Даац хэтрэлтийг хянах стратеги, бодлого	ЗТХЯ даац хэтрэлтийг хянах стратегийг боловсруулж, дараах гол асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Үүнд: (i) байгууллагад бүтэц зохион байгуулалт бий болгох; (ii) дүрэм, журам, зохицуулалт; (iii) Дэд бүтэц, тоног төхөөрөмж; (iv) хууль сахиулалт ба үйл ажиллагаа; (v) Боловсон хүчний нөөц, сургалт; (vi) Төр, хувийн хэвшлийн түншлэл; (vii) Олон нийтийн мэдээлэл, хамтын ажиллагаа; ба (viii) Санхүүжилтын эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> <li>i. Даац хэтрэлтийг хянах стратеги боловсруулах баг бүрдүүлэх.</li> <li>ii. Зөвлөмжид заасан гол асуудалтай холбоотой бүх мэдээллийг цуглуулах.</li> <li>iii. Даац хэтрэлтийг хянах стратегийн эцсийн тайлангийн төслийг бэлдэх.</li> <li>iv. Семинар зохион байгуулж, үр дүнг хэлэлцэх.</li> <li>v. Семинар дээр өгсөн зөвлөмжийг тусгасан эцсийн тайлан бэлтгэх.</li> </ul>	2021-2022	ЗТХЯ ЗТХТ
1.2	Хуулийн хэрэгжилт – Бүх төрлийн хүнд даацын тээврийн хэрэгсэлд хэрэглэх боломжтой болгох	Одоо мөрдөж буй журам нь дан эсвэл давхар тэнхлэгтэй цөөн тооны хүнд даацын тээврийн хэрэгслийг л хамаарна. Тиймээс бүх төрлийн тэнхлэг ба дугуйн хослол бүхий бүх төрлийн ачааны машин, чиргүүл болон бусад төрлийн хүнд даацын тээврийн хэрэгсэлд ашиглахаар зохицуулалтыг цаашид боловсронгуй болгохыг зөвлөж байна.	<ul style="list-style-type: none"> <li>i. Одоогийн хуулийн зохицуулалтыг судалж, цоорхойг тодорхойлох;</li> <li>ii. Зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн тонн дутамд тавих торгуулийг тодорхойлох</li> <li>iii. техникийн өгөгдөл цуглуулах; Торгуулийн саналын төслийг бэлтгэх;</li> </ul>	2021-2022	ЗТХЯ ЗТХТ



Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвлөмж	Авах арга хэмжээ буюу үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага
			<ul style="list-style-type: none"> <li>iv. Семинар дээр удирдлагуудад саналын төслөө танилцуулж хэлэлцэх;</li> <li>v. Саналаа эцэслэн, батлуулахаар оруулах;</li> <li>vi. ЗТХЯ шинэчилсэн журам, хууль гаргах;</li> </ul>		
1.2.	Хуулийн хэрэгжилт – Ачаа буулгах	<p>Даац хэтэрэлтийн улмаас автозам тооцоот хугацаанаас өмнө эвдэрч, замын хөрөнгө оруулалтыг эрсдэлд оруулж болзошгүй байгаа тул тэнхлэгийн ачааллын хуулийн зохицуулалтанд зөвшөөрөгдсөнөөс илүү ачааг буулгах заалтыг оруулж өгөхийг зөвлөж байна. ЗТХЯ-ны авто замын салбарын бодлогод заасны дагуу бусад улс орны практикт түгээмэл ашигладаг.</p>	<ul style="list-style-type: none"> <li>i. Одоогийн хуулийн зохицуулалтыг судалж, цоорхойг тодорхойлох;</li> <li>ii. Зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн ачааг буулгах журмыг судлах;</li> <li>iii. Ачаа буулгах болон торгуулийн саналын төслийг бэлтгэх;</li> <li>iv. Семинар дээр удирдлагуудад саналын төслөө танилцуулж хэлэлцэх;</li> <li>v. Саналаа эцэслэн, батлуулахаар оруулах;</li> <li>vi. ЗТХЯ шинэчилсэн журам, хууль гаргах</li> </ul>	2022-2023	ЗТХЯ ЗТХТ

1.3.	Хуулийн хэрэгжилт - Торгууль	Торгууль ногдуулах одоогийн зохицуулалт нь тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс хэтэрсэн бодит ачааны хэмжээтэй нийцэхгүй байна. Зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан жингийн дагуу торгууль ногдуулах заалтыг агуулсан шинэ журам гаргахыг зөвлөж байна.	<ul style="list-style-type: none"> <li>i. Одоогийн хуулийн зохицуулалтыг судалж, цоорхой тодорхойлох;</li> <li>ii. Зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн жин бүрт тавих торгуулийг тодорхойлох техникийн өгөгдөл цуглуулах;</li> <li>iii. Торгуулийн саналын төслийг бэлтгэх;</li> </ul>	2022-2023	ЗТХЯ ЗТХТ
------	---------------------------------	---	--	-----------	--------------

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвлөмж	Авах арга хэмжээ буюу үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага
			iv. Семинар дээр удирдлагуудад саналын төслөө танилцуулж хэлэлцэх; v. Саналаа эцэслэн, батлуулахаар оруулах; vi. ЗТХЯ шинэчилсэн журам, хууль гаргах;		
Хоёр	Ачаа тээврийн замнал, коридоруудыг тодорхойлох			2021-2023	ЗТХЯ ЗТХТ
2.1	Шинээр байгуулах Даац хэтрэлтийг хянах цэгүүдийг эрэмбэлэх шалгуур үзүүлэлт	Төлөвлөж буй газарт хүнд даацын тээврийн хөдөлгөөний судалгаа явуулах, анхны хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал, үйл ажиллагааны зардал, замын эвдрэлийн хэмнэлт зэргийг тооцсон замын ашиглалтын үеийн зардлын дүн шинжилгээнд үндэслэн эрэмбэлэх.	i. Замын коридоруудыг тодорхойлох; ii. Даац хэтрэлтийн судалгааг зохион байгуулах төсөв зохиох; iii. Даац хэтрэлтийн судалгаа хийх багийн зохион байгуулах. iv. Ашиглалтын хугацааны зардал болон бусад зардлын өгөгдөл цуглуулах. v. Төлөвлөж буй бүх цэгүүдийн ашиглалтын хугацааны зардлыг тодорхойлох. vi. Зардал, ашиг орлогын харьцаанд үндэслэн эрэмбэлэх.	2022-2023	ЗТХЯ ЗТХТ
Гурав	Дэд бүтцийн төлөвлөлт, тоноглолын сонголт			2021-2022	ЗТХЯ ЗТХТ

3.1	Шинээр байгуулах даац хэмжих цэгийн ерөнхий төлөвлөлт /Layout plan/	Одоогийн автопүү нь хүнд даацын тээврийн хэрэгслийг хянах зохих бүх төхөөрөмжөөр бүрэн тоноглогдоогүй байна. Иймд тэнхлэгийн ачаалал хэмждэг орчин үеийн технологид суурилсан явуут	i. Барилга угсралтын ажил эхлэх үед санал болгож буй хоёр даац хэмжих цэгийн	2022-2023	ЗТХЯ ЗТХТ
-----	---	---	--	-----------	--------------

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвлөмж	Авах арга хэмжээ буюу үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага
		дунд нь хэмждэг тоног төхөөрөмжөөр тоноглохыг зөвлөж байна.	<ul style="list-style-type: none"> <li>ерөнхий төлөвлөлт /план/-ийг хийх;</li> <li>ii. Ерөнхий төлөвлөлийг хянаж, зөвлөмж өгөх;</li> <li>iii. Семинар дээр хэлэлцэж, санал зөвлөмжийн дагуу өөрчлөлт хийхийг зөвлөж байна.</li> </ul>		
	Автопүү бүхий цэгийн үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт	ЗТХТ нэг ахлах мэргэжилтнээр удирдуулсан Даац хэтрэлтийг хянах алба/хэлтэс байгуулан ажиллуулах, энэ албан тушаалтан үндсэн чиг үүргийг удирдах үүрэгтэй байна.	<ul style="list-style-type: none"> <li>i. Ажлын байрны тодорхойлолт бэлтгэх.</li> <li>ii. Богино жагсаалтыг гаргаж, нэр дэвшигчийг сонгох.</li> <li>iii. Урьдчилан батлуулахаар ирүүлэх;</li> <li>iv. Нэр дэвшигчийг томилох.</li> </ul>	2022-2023	ЗТХЯ ЗТХТ
3.2	Даац хянах цэг байгуулах ажлыг урт хугацааны үр дүнд суурилсан автозамын засвар шинэчлэлтийн гэрээний нэг хэсэг болгох.	ЗТХЯ УБ - Арвайхээр чиглэлийн авто замын гэрээ байгуулах ажлыг АХБ-ны дэмжлэгтэйгээр хийхээр төлөвлөж байгаа тул шинээр байгуулах автопүүг автозам барих / шинэчлэх гэрээний нэг хэсэг гэж үзэхийг зөвлөж байна. Энэ нь Монгол Улсын тэнхлэгийн ачааллын стратегийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжихэд чиглэсэн авто замын салбарын бодлогын зорилттой нийцэх болно.	<ul style="list-style-type: none"> <li>i. Даац хэтрэлт хянах цэгүүдийн техникийн шаардлагын төслийн бэлтгэх;</li> <li>ii. Төсөв боловсруулах.</li> <li>iii. Гүйцэтгэлд суурилсан гэрээнд шаардлагатай концепцийн загварыг бэлтгэх;</li> <li>iv. Хүлээн авсан тендерүүдийг хянаж үзэх.</li> <li>v. Тэнхлэг ачааллын төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах зэрэг гэрээг байгуулах.</li> </ul>	2022-2024	ЗТХЯ ЗТХТ
Дөрөв	Хүний нөөцийг бэлтгэх, сургах			2022-2023	ЗТХЯ ЗТХТ

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвлөмж	Авах арга хэмжээ буюу үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага
4.1	Сургалт явуулах хөтөлбөр	Даац хэтрүүлэлтийг хянах сургалтын хөтөлбөр боловсруулах		2021	ЗТХЯ ЗТХТ Автозамчдын холбоо
4.2.	Сургалт хийх	Хөтөлбөрийн дагуу сургалт явуулах		2021 оноос жил бүр	ЗТХЯ ЗТХТ Автозамчдын холбоо
Тав	Санхүүжилтийн асуудлыг шийдэх				ЗТХЯ ЗТХТ
5.1	Тэнхлэгийн ачааллыг хянах санхүүжитийг бий болгох	Ирэх таван жилд тэнхлэгийн ачааллын хяналтын цэгийг төлөвлөх, зураг төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, ерөнхий менежмент хийхэд шаардагдах санхүүжилтийн иж бүрэн санал боловсруулж хэрэгжүүлэх		2021-2023	ЗТХЯ ЗТХТ
Зургаа	Үйл ажиллагаа явуулах			2022-2023	ЗТХЯ ЗТХТ
6.1	Төрийн болон хувийн оролцогч талуудын зохицуулалт хоорондох	Тэнхлэгийн ачааллын стратегийг үр дүнтэй, зардал багатай хэрэгжүүлэхийн тулд ЗТХЯ, ЗТХТ, Хууль зүйн яам, Сангийн яам, Хүнс, Хөдөө аж ахуйн яам, Уул уурхайн яам, тээвэр жуучлалын байгууллагууд болон тээвэрлэгч зэрэг бүх оролцогч талуудын хооронд зөв зохицуулалт хийх нь чухал юм. Бусад орнуудын практикт үндэслэн ЗТХЯ "Тээврийн хэрэгслийн даацын асуудал эрхэлдэг Зөвлөх хороо" байгуулах хэрэгтэй.	<ul style="list-style-type: none"> <li>i. "Тээврийн хэрэгслийн даацын асуудал эрхэлдэг Зөвлөх хороо" байгуулах санал боловсруулах.</li> <li>ii. Хорооны гишүүд бүрийн ажил үүргийн тодорхойлолт гаргах; Оролцогчид талуудад танилцуулах, хэлэлцэх.</li> <li>iii. Саналын төслийг эцэслэн бэлтгэх;</li> <li>iv. "Тээврийн хэрэгслийн даацын асуудал эрхэлдэг Зөвлөх хороо" –д томилох протокол гаргах</li> </ul>	2022-2023	ЗТХЯ ЗТХТ
Долоо	Хяналт			2022-2023	ЗТХЯ ЗТХТ

<i>Д/д</i>	<i>Шийдвэрлэх асуудал</i>	<i>Зөвлөмж</i>	<i>Авах арга хэмжээ буюу үйл ажиллагаа</i>	<i>Хугацаа</i>	<i>Хариуцах байгууллага</i>
7.1	Хүнд даацын тээврийн хэрэгслийн тэнхлэгийн даац хэтрэлтийг хяналтанд мониторинг хийх		Тэнхлэгийн даац хэмжих цэгүүдийн үйл ажиллагаанд мониторинг хийж, торгууль ногдуулалтанд хяналт тавих	2023	ЗТХЯ ЗТХТ

## 6-р хүснэгт: Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлтүүд	Хүрэх түвшин		
		2021	2025	2030
1	Улсын чанартай хатуу хучилттай автозамд тэнхлэгийн ачаалал хянах хувь, %	70	80	100
2	Хүнд даацын тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг хянах хувь, %	30	70	100
3	Тэнхлэгийн ачаалал хянах цэгийн тоо	6	23	30

*Санхүүжилтийн эх үүсвэрүүд*

Тэнхлэгийн ачаалал хянах стратегийг хэрэгжүүлэхэд дотоод, гадаадын эх үүсвэрээс хангалттай санхүүжилтийг хангах нь чухал асуудал юм. 2019 оны байдлаар 19 төлбөр хураах цэгээс ердөө 7 их наяд төгрөг орж ирэн замын санд цугларч байгаа бол улсын чанартай бүх автозамын засвар арчлалтанд 55 их наяд төгрөг шаардагдаж байна. Үүнээс гадна тэнхлэгийн ачаалал хэмжих тоног төхөөрөмж суурилуулахад нэмэлт санхүүжилт шаардагдана. Ихэвчлэн дараахь хоёр санхүүжилтийн хувилбар байдаг. (а) Дотоод эх үүсвэрээс санхүүжүүлэх хувилбар; (б) хандивлагч байгууллагуудын санхүүжилт гэх мэт гадаад эх үүсвэрээс санхүүжүүлэх хувилбар. Эдгээр хувилбаруудыг дараах байдлаар товч тайлбарлав.

*Дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлэх хувилбар:*

Дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэх хувилбарт улсын төсвөөс эсвэл замын сангаас санхүүжих хувилбар байж болно. Төслийн дунд шатны тайлангийн (44, 45-р хуудас) хэсэгт тусгасан ЗТХЯ-ны сайдын 2018 оны 12-р сарын 11-ний өдрийн 282 тоот тушаалаар Замын Зөвлөлийн (ЗЗ) ажиллах журмыг үзнэ үү. Энэхүү журамд ЗЗ-ийн чиг үүрэг, гишүүнчлэлийг заасан байдаг. Үндсэн чиг үүргийг дараах байдлаар нэгтгэн харуулав.

Замын Зөвлөл нь замын бэлэн байдал, аюулгүй байдлыг хариуцна.

- Автозамын засварын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг хянаж, зөвлөмж гаргах;
- Замын засварын ажлын явцыг хянах, зөвлөмж өгөх;
- Олон улсын болон улсын чанартай авто замуудад үйлчилгээний түвшинг хангах талаар зөвлөмж гаргах;

Замын Зөвлөл нь Замын сангийн орлого, зарлагын байдалд олон нийтийн хяналт тавина.


- Замын сангийн орлогын зорилт, хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хяналт тавьж, зөвлөмж гаргах бөгөөд энд тэнхлэгийн ачааллыг хянахад шаардагдах санхүүжилт багтах эсэх тодорхойгүй байна.
- Авто замын засвар арчлалтын санхүүгийн гүйцэтгэлийн талаар санал дүгнэлт өгөх.

Замын Зөвлөлийн гишүүнчлэл нь дараахь зүйлийг багтаана.

- ЗТХЯ-ны Засвар арчлалтын хэлтсийн дарга;
- ЗТХЯ-ы Замын сан хариуцсан мэргэжилтэн;
- ЗТХТ-ийн захирал;
- Зам ашиглагч / олон нийтийн төлөөлөл болох 3 гишүүн байна. Үүнд: Замын засвар арчлалтын компанийн 1 төлөөлөл, замын төрийн бус байгууллага, холбоодын 2 төлөөлөл байна.

Засгийн газрын журамд заасан орлогын эх үүсвэр, хөрөнгийн урсгал, тайланг дараах байдлаар харуулав.





7- р зураг: Замын сангийн эх үүсвэр ба сангийн

зарцуулалт Гадаадын эх үүсвэрээр санхүүжүүлэх

хувилбар:

Гадаадын санхүүжүүлэгчид олон улсын байгууллагууд эсвэл хандивлагч байгууллагууд байх бөгөөд тэд ЗТХЯ-нд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд: (i) тэнхлэгийн ачааллыг хянах бодлого боловсруулах; (ii) тэнхлэгийн ачааллыг хянах стратеги боловсруулах; (iii) тэнхлэгийн ачааллын бодлого, тэнхлэгийн ачааллын стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах..

2021 онд шаардагдах төсөв.

2019 оны 9-р сарын 23-ны өдрийн UB Post сонинд мэдээлснээр 2020 оны төсвийн тодотголд ЗТХЯ-ны тооцоолсон 95.8 тэрбум төгрөгийн шаардлагаас 55 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн болно. ЗТХТ нь Монгол дахь тэнхлэгийн ачааллын хяналтын цэгийг удирдахад шаардагдах мэдээллийг цуглуулж, ирэх таван жилийн хугацаанд тэнхлэгийн ачааллын хяналтын цэгийг төлөвлөх, зураг төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, ерөнхий менежмент хийхэд шаардагдах санхүүжилтийн иж бүрэн саналыг гаргах болно. Одоо байгаа даац хэтрэлтийн хяналтын жин ажиллуулах, эсвэл Монгол улсын үндэсний хурдны зам дээр тэнхлэгийн ачааллын хяналтын жин суурилуулах ажилд хичнээн хэмжээний төсөв зарцуулах нь одоогоор тодорхой болоогүй байна.

## 2.5 ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫГ ХЯНАХ СТРАТЕГИЙН БАЙРШЛУУД

*Жин хэмжих цэгийн үйл ажиллагаа*

2014 оноос өнөөг хүртэл жин хэмжих суурин авто пүүг ажиллуулж байна. Суурин автопүү улсын чанартай гол замуудын 4 цэг дээр ТХЦ-г ажиллуулж, тээврийн хэрэгслийн даац хэтрэлтийг хянаж байна. Энэхүү суурин автопүүны операторчид зөвхөн зөрчлийг илрүүлж, бүртгэл хөтлөх үүрэгтэйгээр ажиллаж байгаа ба даац хэтэрсэн тээврийн хэрэгсэл хөдөлгөөнөө үргэлжлүүлж байна. Үүний зэрэгцээ тээвэрлэгчид ТХЦ болон жин хэмжих цэгийг тойрон бусад хувилбарт замуудаар явах хөдөлгөөн хэвээр байна.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, Хөдөлгөөнт эргүүлийн баг, Зам тээврийн хөгжлийн яамны гэрээт цагдаагийн хэлтэс, орон нутгийн замын цагдаагийн алба, Авто тээврийн үндэсний төвийн


ТӨҮГ-ын тээврийн улсын байцаагч, "Төв АЗЗА" ТӨХК, "Багануур АЗЗА" ТӨХК, "Борхойн зам"

ХХК, “Даш зам” ХХК, “Авто замын машин механизм” ХХК тус тус хамтран 2019 оны 4-р сарын 12-30-ны хугацаанд улсын чанартай дараах 5 чиглэлийн авто замд тээврийн хэрэгслийн жин хэмжих шуурхай ажлыг зохион байгуулсан байна.

1. Улаанбаатар-Даланзадгад чиглэлийн зам
2. Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн зам
3. Замын-Үүд-Зуунмод-Улаанбаатар чиглэлийн зам
4. Улаанбаатар-Багануур чиглэлийн зам
5. Улаанбаатар-Даланзадгад чиглэлийн зам

Даац хэтрэлт хянах ажиллагаанд зөөврийн тэнхлэгийн ачаалал хэмжигч багажийг ашигласан байна. Тус ажлын хүрээнд Монгол Улсын стандарт MNS 4598:2011-г баримтлан ажиллаж, тухайн стандартад Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлагын 5.8.2-г “Нэг хөтлөгч тэнхлэг дээрх хамгийн их ачаалал 11.5тн хөтлөгдөх тэнхлэг дээрх хамгийн ачаалал 10тн- оос тус тус ихгүй байна”, мөн 5.8.1.1-д “Авто тээврийн хэрэгслийн бүх жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээний дагуу байна” гэж заалтуудын хэрэгжилтийг газар дээр шалгажээ. Нийт 5 чиглэлд нийт 187 хүнд даацын тээврийн хэрэгслийн ачаалалд хяналт тавьж ажиллахад 81% буюу 151 тээврийн хэрэгслийн нэг тэнхлэг дээрх болон нийт буюу бодит жин стандартад зааснаас хэтэрч, зөвхөн 36 тээврийн хэрэгсэл (буюу зөвхөн 19% нь) хэвийн тээвэрлэлт гүйцэтгэж байгаа нь сэтгэл түгшээсэн нөхцөл байгаа бөгөөд яаралтай арга хэмжээ авах шаардлагатайг илтгэж байна.

8-р зураг: Автопүүний байрлал




Эх сурвалж: ЗТХЯ

Тээврийн хэрэгслийн нийт жин 44 тонн байхаар хязгаарласан байдаг ба дөрвөн ТХЦ дээр ажиллаж буй авто пүү нь зөвхөн тээврийн хэрэгслийн нийт жинг хэмжин бүртгэж, даац хэтэрсэн тохиолдолд тээврийн байцаагч торгон явуулж байна.



9-р зураг. Суурин (Гүүрэн) авто пүүгээр тээврийн хэрэгслийн нийт жинг хэмжиж байгаа нь



10-р зураг . Суурин авто пүүний хэмжилтийн бүртгэл, хяналтын ажиллагаа

Суурин авто пүүнүүдийн хэмжилт, бүртгэл мэдээлэл хамгаалалт муутай, бүртгэлийн мэдээллийг засаж, өөрчлөх боломжтой, бүртгэлийн үйл ажиллагаанд байнгын хяналт байхгүй байна

ЗТХЯ-наас төлбөр хураах цэгийн үйл ажиллагааг өргөтгөх төлөвлөж байгаа ба энэ асуудлаар тус Зам тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 4-р сарын 22-ны өдрийн 120 тоот тушаал гарсан. Уг тушаал ёсоор дараах хүснэгтэд харуулсан 2019 онд 6 цэг, 2020 онд 8 цэг шинээр нэмж байгуулахаар төлөвлөсөн. Мөн 2 цэгийг шилжүүлэн барихаар төлөвлөж, хэрэгжүүлсэн.

7-р хүснэгт: Төлөвлөж байгаа төлбөр хураах цэгийн байршил


No.	Авто замын дугаар	Авто замын чиглэлийн нэр	Төлбөр хураах цэгийн нэр	Төлбөр хураах цэгийн байршил	Төлбөртэй авто замын эхлэл, төгсгөлийн цэг		Замын урт, км
					Эхлэл цэг	Төгсгөл цэг	
Нэг. 2019 онд шинээр баригдах ТАЦ							
1	A0301	УБ-Арвайхээр	Эрдэнэсант ТАЦ	Эрдэнэсант сум орчимд	УБ-аас 19 км	Арвайхээр хот	412.6
2	A0902	Булган-Мөрөн	Мөрөнгийн ТАЦ	Мөрөн хот орчимд	Булган хот	Мөрөн хот	343.6
3	A0304	Алтай-Ховд	Ховд, Манхан ТАЦ	Манхан сумын 3 замын уулзвар	Алтай хот	Ховд хот	438.9
4	A0305	Ховд-Өлгий	Өлгий ТАЦ	Өлгий хотгорчимд	Ховд хот	Өлгий хот	225.2
5	A0202	Мандалговь-Даланзадгад	Цогт-Овоо ТАЦ	Цогт-Овоо сум орчимд	Мандалговь хот	Даланзадгад хот	305.1

No.	Авто замын дугаар	Авто замын чиглэлийн нэр	Төлбөр хураах цэгийн нэр	Төлбөр хураах цэгийн байршил	Төлбөртэй авто замын эхлэл, төгсгөлийн цэг		Замын урт, км
					Эхлэл цэг	Төгсгөл цэг	
6	A0501	Улаанбаатар-Өндөрхаан	Өндөрхааны ТАЦ	Өндөрхаан хот очимд	Багануур, Хэрлэнгийн гүүр	Өндөрхаан хот	196.0
Хоёр. 2020 онд шинээр баригдах ТАЦ							
1	A0901	Дашинчилэн-Булган	Баяннуурын ТАЦ	Баяннуур сум орчимд	Лүнгийн 3 замын уулзвар	Булган хот	220.5
2	A0303	Баянхонгор-Алтай	Байдрагийн гүүр ТАЦ	Байдрагийн гүүр орчимд	Баянхонгор хот	Алтай хот	395.9
3	A0303	Баянхонгор Алтай	Алтай ТАЦ	Алтай хот орчимд	Баянхонгор хот	Алтай хот	395.9
4	A0502	Өндөрхаан-Чойбалсан	Чойбалсангийн ТАЦ	Чойбалсан хотын орчимд	Өндөрхаан хот	Чойбалсан хот	330.2
5	A0102	Чойр-Сайншанд	Сайншанд ТАЦ	Сайншанд хотын орчимд	Чойр хот	Сайншанд хот	221.4
6	A0603	Цэцэрлэг-Тосонцэнгэл-Нөмрөг	Их-Уул ТАЦ	Их Уул сум орчимд	Цэцэрлэг хот	Нөмрөг сум	462.3
7	A18	Нөмрөг-Сонгино - Наранбулаг-Улаангом	Сонгино ТАЦ	Сонгино сумын орчимд	Нөмрөг сум	Улаангом хот	358.2
8	A18	Нөмрөг-Сонгино - Наранбулаг-Улаангом	Улаангомьн ТАЦ	Улаангом хотын орчимд	Нөмрөг сум	Улаангом хот	358.2
Гурав. Шилжүүлэн барих ТАЦ							
1	A0201	Улаанбаатар-Мандалговь	Түргэний гүүрийн ТАЦ	Өлзийт ТАЦ-ыг шилжүүлж, улсын чанартай замын эхлэл Түргэний гүүр орчимд байршуулна.	Улаанбаатар хот	Мандалговь хот	271,5
2	A0101	Улаанбаатар-Чойр	Чойр ТАЦ	Айраг суманд байрлах ТАЦ-ийг шилжүүлж, Чойр хотын орчимд байрлуулна.	Улаанбаатар хот	Чойр хот	224,5

Эх сурвалж: ЗТХЯ

11-р зураг: Төлбөр хураах цэгийн одоогийн болон төлөвлөж буй байршил

## ШИНЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АВТО ЗАМЫН ТӨЛБӨР АВАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ



Эх сурвалж: ЗТХЯ

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын төлбөр хураах, хяналтын механизмыг бүрдүүлэх...” гэж тусгагдсаны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 онд А/59 дүгээр тушаал гарч олон улс, улсын чанартай авто зам ашигласны хураамж авах төлбөр авах цэг /ТАЦ/-ийн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг эхлүүлсэн байна.

Тушаалд нийт Төлбөр авах 28 цэгийн үйл ажиллагааг 2 үе шаттайгаар цахимжуулахаар тусгасан. 2021 оны байдлаар эхний үе шат буюу Улаанбаатар орчмын Налайх-Тэрэлж, Эмээлт, Хоолт гэсэн ТАЦ-ийг цахимжуулаад байгаа бол үлдсэн 25 ТАЦ-ийг ойрын жилд багтаан цахимжуулахаар төлөвлөж байгаа ажээ.

2022 оны байдлаар улсын хэмжээнд нийт 31 төлбөр авах цэгт тээврийн хэрэгслийн даацын хяналт хийж байна. Түүнчлэн эдгээр цэгүүдэд олон улсын болон улсын чанартай авто зам ашигласны төлбөр авч, авто замын санд төвлөрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна.

УБ хотын орчим байрлах Налайх-Тэрэлж, Хоол, Эмээлтийн төлбөр авах цэгүүдэд авто зам ашигласны төлбөр, хураамжийг цахим хэлбэрээр авах ажлыг үе шаттайгаар туршин ажиллаж байна.



Эх сурвалж: ЗТХТөө

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд уул уурхай, хүнд үйлдвэрийг хөгжүүлэхээр тусгасан бөгөөд энэ зорилтын хүрээнд зам харилцааг хөгжүүлэхийг нэн тэргүүний зорилтын нэг болгосон байна. Тухайлбал Алсын Хараа -2050 хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан холбогдох заалтуудыг дурдвал:

4.2.14. Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж, байгуулна. Үүнд:

Уул уурхайн ордууд:

- Таван толгойн нүүрсний орд;
- Оюутолгойн далд уурхай;
- Дорноговийн цахиурын орд;
- Цагаан суваргын орд;
- Хармагтайн орд;
- Литийн орд;
- Газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлнэ.

Хүнд үйлдвэр:

- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр;
- Нефть-хими, кокс-хими, металлургийн үйлдвэр;
- Нүүрс угаах үйлдвэр;
- Нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк;
- Ган төмөрлөгийн үйлдвэр;
- Жонш баяжуулах үйлдвэр;
- Алт цэвэршүүлэх үйлдвэрийг тус тус барьж байгуулна.

4.2.15. Говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулна.

4.2.16. Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна.

4.4.3. Эдийн засгийн коридорын хүрээнд “Талын зам” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх байгалийн хийн хоолойг барих асуудлыг гурван талт хэлэлцээрийн үр дүнд шийднэ.

4.4.4. Эдийн засгийн коридор бий болгох гурван талт хэлэлцээрийг боловсронгуй болгож, Монгол Улс тээвэр, логистик, хот байгуулалт, хил дамнасан худалдаа, аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлнэ.

4.4.5. Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулж, тус бүсэд бага овортой, өртөг өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.

4.4.6. Олон улсын агаарын карго тээврийн логистикийн төв байгуулж, ачааны төвлөрөл бий болгоно.

4.4.7. Нисэх буудлыг түшиглэсэн олон худалдааны төв байгуулж, худалдааны аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

8-р хүснэгт: "АЛСЫН ХАРАА-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин



№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээллийн эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
				2025	2030	2050					
32	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	хувь	7.2	6	6	6		Үндэсний статистикийн хороо	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Засгийн газар
68	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт	км	-	6616	8055	8831	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Жич: Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Статистик мэдээ	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

Эх сурвалж: “Алсын хараа 2050” хөгжлийн бодлого

12-р зураг: Уул уурхайн томоохон төслүүд



Эх сурвалж: Өмнийн говийн хөгжил төсөл

Хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн одоогийн байдал болон төсөөлөл, уул уурхайн томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх бодлого, олон улсын авто тээврийн коридор хөгжүүлэх зорилт зэрэгт үндэслэн дараах чиглэлийн авто зам дээр даац хэтрүүлэлтийг хянах нь шаардлагатай байгаа болно.

9- р хүснэгт: Авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал, бүрэн жинг хянах авто замууд

№	Авто замын код	Авто замын чиглэлийн нэр	Тайлбар
1	A0101	Улаанбаатар-Чойр	Пүү байгаа /Хоолтын ТАЦ болон Чойрын ТАЦ/
2	A0102	Чойр- Сайншанд	Пүү байгаа /Чойрын ТАЦ болон Сайншандын ТАЦ/
3	A0103	Сайншанд-Замын-Үүд	Пүү байгаа /Сайншандын ТАЦ Замын-Үүдийн ТАЦ/
4	A25	Улаанбаатар-Зуунмод	Пүү байгаа/Түргэний голын ТАЦ/
5	A0201	Улаанбаатар-Мандалговь	Пүү байгаа /Түргэний голын ТАЦ болон Мандалговь ТАЦ/
6	A0202	Мандалговь-Даланзадгад	Пүү байгаа /Цогт-Овоо ТАЦ/
7	A0203	Цогтцэций-Гашуунсухайт	Нүүрсний компаниуд дээр пүү байгаа
8	A0301	Улаанбаатар-Арвайхээр	Пүү байгаа /Эрдэнэсантын ТАЦ /
9	A0302	Арвайхээр-Баянхонгор	Пүү байгаа /Эрдэнэсантын ТАЦ/
10	A0403	Алтанбулаг-Сүхбаатар	Пүү байгаа /Алтанбулагт/
11	A0402	Сүхбаатар-Дархан	Шинэчилсэн /Дулаанхааны ТАЦ/
12	A0401	Дархан-Улаанбаатар	Дарханы замын төслийн хүрээнд шинээр баригдана.
13	A1001	Дархан-Эрдэнэт	Шинээр барих
14	A0501	Улаанбаатар-Өндөрхаан	Пүү байгаа /Хэрлэнгийн гүүрийн ТАЦ болон Өндөрхааны ТАЦ/
15	A2001	Өндөрхаан-Баруун-Урт	Пүү байгаа /Өндөрхааны ТАЦ/
16	A2002	Баруун-Урт-Бичигт	Шинэ барьсан /Бичигтийн боомтод барих/
17	A0306	Цагааннуур-Өлгий	Шинэ барьсан /Өлгийн ТАЦ/
18	A0305	Өлгий-Ховд	Шинээр барих /Өлгийн ТАЦ/
19	A0304	Ховд-Алтай	Шинээр барих /Ховд, Манхан сумын ТАЦ/
20	A16	Цагааннуур-Улаангом	Шинээр барих /Цагааннуур боомт дээр барих/
21	A0901	Дашинчилэн-Булган	Булганы Баяннуурын ТАЦ /Хэрэгцээ бага тул шаардлагагүй/
22	A0303	Баянхонгор -Алтай	Байдрагийн гүүрийн ТАЦ болон Алтайн ТАЦ
23	A0502	Өндөрхаан-Чойбалсан	Өндөрхааны ТАЦ болон Чойбалсангийн ТАЦ
24	A0603	Цэцэрлэг-Тосонцэнгэл-Нөмрөг	Завханы Их-Уулын ТАЦ
25	A0603	Цэцэрлэг-Тосонцэнгэл	Тариатын ТАЦ
26	A18	Нөмрөг-Сонгино-Наранбулаг-Улаангом	Сонгино ТАЦ болон Улаангомын ТАЦ
27	A0902	Булган-Мөрөн	Мөрөнгийн ТАЦ
28		Налайх-Тэрэлж	Шинээр барьсан /Налайхын ТАЦ//
29	A0301	Улаанбаатар - Лүн	Шинээр барьсан /Эмээлтийн ТАЦ/

Эх сурвалж: Зөвлөх

Иймд тэнхлэгийн ачаалал хэмжих тоноглолын хувьд:

1. Дээрх 6-р хүснэгтэнд харуулсан байршилд суурин пүү буюу одоо Түргэний голын ТАЦ-д суурилуулсан хэмжих хэрэгсэлтэй ижил тоноглол бүхий суурин пүү ашиглахыг санал болгож байна. Ингэх нь цаашид засвар, үйлчилгээ, тохируулгын хувьд хялбар байх болно. Олон янзын пүү, хэмжих хэрэгслийг ашиглахаас зайлсхийх нь зүйтэй.
2. Улсын чанартай авто замын бусад чиглэлд зөөврийн пүүгээр хяналт хийх боломжтой гэж харж байна.

Ачааны автомашины пүүг шалгах

Пүүний оператор нь жинлэлтийн гүүр буюу пүүг зөв ажиллуулах ёстой бөгөөд ачааны автомашины пүүг ханган нийлүүлэгч, эсвэл техникчдэд үүссэн асуудлыг байнга тэмдэглэж байх ёстой.

Оператор дараах зүйлийг хийнэ:

- Ээлж бүрийн эхэнд ачааны автомашины пүүний техникийн байдлыг шалгаж ажиллаж байгаа эсэхийг нүдээр харж шалгах
- Пүүний нарийвчлалыг тогтмол шалгаж байх /тогтоосон хугацаанд пүүний ажиллагаанд тохиролын баталгаажуулалт хийлгэж байх/
- Ачааны автомашины пүүний ажиллагаанд хяналт

тавих Ачааны бодит жинг тодорхойлох үндсэн журам

1. Жингийн гүүр буюу пүүнд аажмаар дөхөж, бага хурдаар тавцан дээр гарч тээврийн хэрэгслийг байрлуулахыг жолоочид мэдэгдэх.
2. Тээврийн хэрэгслийг тавцан дээр байрлуулсны дараа хэмжилтийг зөв хийхийн тулд тээврийн хэрэгсэл хэмжих багажнаас өөр зүйлтэй холбогдсон эсэхийг шалгаж, холбогдоогүй тохиолдолд хэмжилтийг хийж эхэлнэ.
3. Тээврийн хэрэгслийн өөрийн жинг жолооч болон зорчигчийг оруулахгүйгээр тодорхойлно (Тээврийн хэрэгслийн жолооч, эсвэл ижил зорчигч өөрчлөгдөж болно). Энэ нь журмыг арилжааны зориулалттай ачааны тээвэрлэлт хийхэд ашиглана.
4. Тээврийн хэрэгслийг жинлэнэ (ачиж, буулгасан). Жинлэж дуусаад, хэмжилтийг бүртгэх хуудас дээр тэмдэглэн авч баталгаажуулна.
5. Тээврийн хэрэгслийг хэмжилтийн цэгт буцаж ирсний дараа тээврийн хэрэгслийг дахин жинлэнэ (ачааг ачиж, эсвэл буулгасны дараа).

Ачааны жинг тодорхойлохдоо ачаатай үеийн бодит жингээс ачаагүй үеийн бодит жинг хасна. Бүртгэх хуудсан дээр ачааны жинг тэмдэглэнэ.

“Өөрийн жин” гэдэг нь жолооч болон зорчигчгүй тээврийн хэрэгслийн тухайн үеийн жинг хэлнэ. Тээврийн хэрэгслийг ачаалаагүй байх үеийн жин нь “өөрийн жин” болох бөгөөд түлшний сав 10 литр хүртэлх хэмжээний шатахуунтай, харин бусад төрлийн шингэн зөвшөөрөгдөх хамгийн их хэмжээтэй байна.

## **2.6 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛАЛ ХЭМЖИХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЗААВАР**


### 2.6.1 Үндэслэл

Төслийн даалгаварт заасан “Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг талбай дээр хэмжих, ... заавар боловсруулах” ажлын хүрээнд судалгаа хийж, хэмжилтийн арга, багаж хэрэгсэл, салбарын туршлага, өнөөгийн байдлыг судалж, 3 аргачилсан зааврыг боловсрууллаа.

Тээврийн хэрэгслийн бүх жин болон тэнхлэгийн ачааллыг статик ба динамик аргаар хэмжиж тодорхойлдог. Статик аргаар хэмждэг багаж төхөөрөмжид гүүрэн автопүү, зөөврийн автопүү хамрагдана. Монгол орны хувьд, улсын чанартай гол замуудад гүүрэн автопүүгээр тээврийн хэрэгслийн бүх жинг хэмжиж хяналт хийж ирсэн бөгөөд гүүрэн автопүү /weighbridge/-г ашиглах мэдлэг туршлага хангалттай хуримтлагдсан байна. Иймд гүүрэн автопүүгээр хэмжилт хийх заавар, аргачлал шаардлагагүй гэж үзлээ. Харин зөөврийн автопүүг цөөн тооны төсөл, хөтөлбөрт ашиглаж байсан ба сургалт танилцуулгад цөөн тооны мэргэжилтнүүд хамрагдаж байжээ.

Орчин үеийн багаж төхөөрөмжтэй харьцуулахад гүүрэн автопүү нь тээврийн хөдөлгөөний хяналтыг (тэнхлэгийн ачаалал, тэнхлэгийн тоо, тэнхлэг хоорондын зай, хөдөлгөөний хурд, хөдөлгөөний эрчмийн тооллого гэх мэт) иж бүрнээр нь, тогтмол хийх боломж хязгаарлагдмал, хэмжилтэнд хугацаа нилээд зарцуулагддаг, хүний оролцоо их шаарддаг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тасралтгүй байдлыг алдагдуулдаг, хүлээлт үүсгэдэг, хэмжилтийн үр дүнг авто замын байгууламжийн ашиглалтын судалгаа, төлөвлөлтөнд ашиглах боломжгүй зэрэг сул талуудтай байдаг.

Гадаад орнуудад тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалалд хяналт тавихад статик ба динамик хоёр аргууд дээр тулгуурласан олон төрлийн багаж хэрэгсэл ашиглаж байна. Эдгээр багаж төхөөрөмжийн үндсэн ангиллыг дорх схемээр харуулав.



12-р зураг. Статик ба динамик аргуудын багаж төхөөрөмжийн ангилал

Судалгаагаар Европын Холбооны улсуудад дундажаар, гурван хүнд даацын тээврийн хэрэгсэл тутмын нэг нь зөвшөөрөгдөх хэмжээнээс 10-20%-иар хэтрүүлсэн даацтай явж байсан бол автозамын сүлжээнд тодорхой тооны WIM систем суурилуулснаар нийт тээврийн хэрэгслийн зөвхөн 10% орчим хувь нь даац хэтрэлттэй явдаг болсон байна (жишээлбэл Франц улс) (V.Cerezo, 2015). Гэхдээ харьцангуй цөөн тооны WIM систем суурилснаар даац хэтрүүлсэн зорчилтын хувь буурахад нөлөөлөхгүй байгааг зарим улс орны туршлага харуулж байгаа ажээ (V.Dolcemascolo, 2019). Тухайлбал автозамын сүлжээнд цөөн тооны WIM систем суурилуулсан улс оронд тээврийн хэрэгслийн 60% хүртэлх хувь нь даац хэтрэлттэй зорчсоор байна (N.Markovic, 2014).

Монгол орны хувьд, улсын чанартай авто замын сүлжээнд статик аргын багаж төхөөрөмжөөс гадна 2020 оноос тээврийн хэрэгслийн бүх жингээс гадна тэнхлэгийн ачаалал, тэнхлэгийн тоо зэргийг хэмждэг, динамик аргад суурилсан, автомат ажиллагаатай орчин үеийн жин хэмжигч төхөөрөмжөөр тоноглогдсон хяналтын цэгүүдийг байгуулж байна /Уг тайлангийн 2.5 Тэнхлэгийн ачааллыг хянах стратегийн байршил бүлгээс үзнэ үү/. Иймд цаашид энэ төрлийн динамик аргад суурилсан тоног төхөөрөмжүүдийн онцлогийг мэдэх, хэмжилт хийх, үр дүн боловсруулах чадвартай боловсон хүчинг бэлдэх, аргачлал заавраар хангах шаардлага гарч байна.

Ийм учраас Төслийн хүрээнд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг хэмжих чиглэлээр дараах хоёр заавар боловсруулан санал болгож байна. Үүнд:

- I. Статик арга: Зөөврийн автопүүгээр тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал, бүх жинг хэмжих заавар;
- II. Динамик арга: Хөдөлгөөн дунд жинлэх аргаар тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал, бүх жинг хэмжих заавар;

### 2.6.2 Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг зөөврийн автопүүгээр хэмжих арга

Өмнө дурдсанчлан гадаад оронд статик аргаар хэмждэг хоёр төрлийн багажийг (Зураг 17.) өргөн хэрэглэж байна. Зөөврийн автопүүгээр хэмжих арга нь зөөврийн автопүү дээр авто тээврийн хэрэгслийг тэнхлэг тус бүрээр нь ээлжлэн зогсоож, статик ачааллыг хэмждэг.



Суурин буюу гүүрэн автопүү  
13-р зураг. Статик аргын багаж төхөөрөмж



Зөөврийн автопүү

Статик арга буюу Зөөврийн автопүүгээр тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал, бүх жинг хэмжих аргачлалын онцлогийг тодорхойлох зорилгоор уг аргын давуу, сул талуудыг тодорхойлж, харьцуулалт хийлээ.

9-р хүснэгт. Зөөврийн автопүүгээр хэмжих аргын SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>● Замын дурын хэсэгт хэмжилт явуулах боломжтой.</li> <li>● Энэ төрлийн багаж хэрэгсэл энгийн, хялбар ажиллагаатай.</li> <li>● Тэнхлэгийн ачааллыг өндөр нарийвчлал, найдвартай хэмжиж тодорхойлно.</li> <li>● Багаж хэрэгслийн өртөг харьцангуй хямд.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Ашиглалтын явцад амархан гэмтэж эвдэрдэг /хэврэг/.</li> <li>● Хэмжилтэнд хугацаа их зарцуулагддаг.</li> <li>● Замын хөдөлгөөнд оролцож буй бүх ачааны автомашины хэмжилт, судалгааг байнга, тогтмол хийх боломжгүй.</li> <li>● Хэмжилт хийх, өгөгдөл цуглуулах ажиллагаа автоматжлагдаагүй.</li> <li>● Хэмжилт явуулахад хөдөлгөөн зохион байгуулалтын нэмэлт арга хэмжээ шаардагддаг.</li> </ul>
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>● Авто замын онцлог хэсгүүдэд судалгаа, шинжилгээний зориулалтаар хэрэглэх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Хэмжилтийн үр дүнд хүний оролцоо /нөлөө/ орох боломжтой.</li> </ul>

Дээрх SWOT шинжилгээнээс дүгнэхэд зөөврийн автопүүг замын тодорхой хэсгүүдэд тухайлсан зорилгоор хэмжилт, ажиглалт хийх, судалгаа шинжилгээний зорилгоор ашиглахад илүү тохиромжтой юм. Энэ зорилгоор 2019 онд ЗТХТ-өөс Ажлын хэсэг ажиллуулан, улсын чанартай авто замуудын онцлог цэгүүд дээр 1-3 хоногийн хэмжилт, хяналтын үйл ажиллагааг Зөөврийн автопүүгээр явуулсан байдаг. Энэ хяналтын үйл ажиллагааг 2020 оны хаврын улиралд мөн явуулсан байна.

10-р хүснэгт. Даац хэтэрсэн тээврийн хэрэгслийн эзлэх хувь

№	Төлбөр Хураах Цэг	Тээврийн хэрэгслийн тоо	Даац хэтэрсэн тээврийн хэрэгслийн	
			тоо	эзлэх хувь
1	Хоолтын даваа	796	113	14%
2	Өлзийт хороолол	2451	351	14%
3	Багануур - Хэрлэнгийн гүүр	146	63	43%
4	Замын Үүд	3412	98	3%

Эх сурвалж: ЗТХТ-өвийн тайлан. 2019.5 сар



3 голтой тээврийн хэрэгсэл /Тоосго /  
/Элс/



6 голтой тээврийн хэрэгсэл /Цемент/

14-р зураг. Зөөврийн автопүүгээр тээврийн хэрэгсэлд шалгалт, хяналт явуулж байгаа нь

Гадаад орны туршлагаас үзэхэд Зөөврийн автопүүг 2-4 эгнээтэй авто замд туршилт шинжилгээ, судалгааны зорилгоор өргөн ашигладаг байна<sup>6</sup>.

Олон улсын аргачлал, заавруудыг ашиглан Зөөврийн авто пүүгээр тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэмжих зааврыг дорх хүснэгтэд үзүүлсэн бүтэц, агуулгатай боловсрууллаа.

<sup>6</sup>Assessment of Axle Load Control Operations in Greater Mekong Subregion Countries.

<https://www.adb.org/sites/default/files/project-documents/49150/49150-001-tacr-en.pdf>

Heavy-Duty Vehicle Weight Restrictions in the EU. [https://www.acea.auto/files/SAG\\_23\\_Heavy-Duty\\_Vehicle\\_Weight\\_Restrictions\\_in\\_the\\_EU.pdf](https://www.acea.auto/files/SAG_23_Heavy-Duty_Vehicle_Weight_Restrictions_in_the_EU.pdf)





**Зөөврийн автопүүгээр тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал, бүх жинг хэмжих зааврын агуулга**

1. Хэмжилтийн аргын нарийвчлалын үзүүлэлт.....
2. Хэмжилтийн хэрэгсэл .....
3. Хэмжих арга.....
4. Аюулгүй ажиллагааны шаардлага.....
5. Хэмжилтийн операторчинд тавигдах шаардлага .....
6. Хэмжилт явуулах нөхцөл .....
7. Бэлтгэл ажил .....
8. Хэмжилтийн ажил .....
9. Хэмжилтийн үр дүнгийн боловсруулалт .....
10. Үр дүнг тайлагнах .....
11. Хэмжилтийн үр дүнгийн нарийвчлал хийх хяналт шалгалт .....

Энэхүү зааврын бүрэн эхийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

**2.6.3 Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг явуут дунд нь хэмжих арга**

Динамик аргаар тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэмжих, хянах арга нь олон улсад Weighing in Motion буюу Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг явуут дунд нь жинлэх арга гэж нэршсэн байна.

АНУ, Европын Холбооны улс, Япон, Солонгос болон бусад хөгжингүй улс оронд орчин үеийн хэмжилтийн арга болох Weighing in Motion (WIM) буюу Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг явуут дунд нь жинлэдэг технологийг түгээмэл хэрэглэж байна.

Энэ технологи нь автозамын тухайн огтлолоор явж өнгөрөх тээврийн хэрэгслийн тэнхлэг тус бүрийн болон тэнхлэгийн хослолын ачаалал (бүх жин), тэнхлэгийн тоо, тэнхлэг хоорондын зай, тээврийн хэрэгслийн хурд, явж өнгөрсөн огноо, цаг зэргийг тухайн тээврийн хэрэгслийг зогсоохгүйгээр хэмждэг байна.

Энэ технологид суурилсан WIM төхөөрөмжийг АНУ-д анх 1950 онд хэрэглэсэн байна. Өнөө үед энэ төхөөрөмж хэд хэдэн нэмэлт мэдрэгч болон орчин үеийн технологиор сайржуулан тоноглогдсон байна. Жишээлбэл: тээврийн хэрэгслийн төрөл ангиллыг таних систем (Automated Vehicle Identification systems AVI), улсын дугаар танигч автомат систем (Automatic detection of the plate number), мэдээлэл дамжуулах автомат систем, дугуйн хийн даралтыг мэдрэх IR камер<sup>7</sup> гэх мэт.

7 IR camera - An infrared camera is a measurement device, which can capture temperature distributions on object surfaces without touching the object.

Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн тоо, тэнхлэгийн хослол, тэнхлэгийн хоорондын зай зэрэг үзүүлэлтэнд үндэслэн тухайн тээврийн хэрэгслийн төрөл, маркийг тогтоон, видео камерт бүртгэгдсэн Улсын Дугаар (plate number)-аар нь бүртгэл, мэдээлэл хөтөлдөг байна<sup>8</sup>.


Тээврийн хэрэгслийн явуул дунд жинлэх ажиллагааг хөдөлгөөний хурдаас хамаарч суурин хэлбэрээр болон тээврийн хэрэгсэлд суурилуулсан хэлбэрээр явуулж байна /20-р зурагт үзүүлсэн схем/.



15-р зураг. Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг явуул дунд нь жинлэх аргын төрөл

WIM буюу ТХ-ийн Явуул дунд жинлэх ажиллагааг гурван төрөлд ангилж, авто зам, гүүрэн байгууламж болон тээврийн хэрэгсэлд суурилуулсан төхөөрөмжөөр хэмждэг ба дараах схемд заасан мэдрэгч болон системтэй байгаа ажээ.

<sup>8</sup> [https://www.is-wim.net/wp-content/uploads/2020/07/ISWIM\\_Guide-for-users\\_press.pdf](https://www.is-wim.net/wp-content/uploads/2020/07/ISWIM_Guide-for-users_press.pdf)




16- р зураг. WIM системийн

төрөл Суурин WIM системийн

онцлог

Автозамын хучилтанд суурилуулдаг WIM систем нь 1) пецо-цахилгаан эсвэл пецо-полимер саваа; 2) пецо-кварц; 3) хотойлтын хавтан гэсэн үндсэн 3 төрлийн мэдрэгчийн технологи дээр тулгуурлан зохион бүтээгдсэн байдаг.




17- р зураг. Авто замын хучилтанд суурилуулдаг ХДЖ системийн мэдрэгчийн төрөл. а) пецо-цахилгаан эсвэл пецо-полимер мэдрэгч, б) пецо-кварц мэдрэгч, в) хотойлтын хавтан хэлбэрийн мэдрэгч

WIM системийн нарийвчлалд орчны нөхцөл, хүчин зүйлс нөлөөлдөг. Эдгээрээс хучилтын температур бүх төрлийн мэдрэгчид ихээхэн нөлөөлдөг хүчин зүйл байдаг. Иймд мэдрэгчийн хэмжилтийн үр дүнд температурын нөлөөллийг тооцсон засварлалтыг /тохиргоо/ хийх шаардлагатай болдог. Давхиж буй тээврийн хэрэгслийн динамик ачааллын хэлбэлзэл, ганхалт, доргилт зэрэг нь тээврийн хэрэгслийн бодит ачааллыг үнэлэхэд мөн ихээхэн нөлөөлж, зөрүү үүсгэдэг байна. WIM

системийг автозамын хучилтанд суурилуулсан тохиолдолд тухайн хучилтын ашиглалтын нөхцөл тодорхой хэмжээгээр үр дүнд нөлөөлдөг тул лаборатори ба талбайд WIM системийн тохиргоог заавал хийх шаардлагатай байна. Тохиргоог ASTM E 1318-09 Standard Specification for Highway Weigh-In-Motion (WIM) Systems with User Requirements and Test Methods стандартын дагуу хийх ба энэ тохиргоонд нилээд өртөг зардал, цаг хугацаа зарцуулагддаг байна. Европын Холбооны Улсуудын хувьд, COST 323 European Specification of WIM стандартын дагуу системийн нарийвчлал, тохиргоог хийж байна.

Эрдэмтдийн судалснаар WIM байрлуулсан замын хучилтын хийц, ашиглалтын нөхцөл WIM системийн мэдрэгчийн үзүүлэлтэнд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэгш бус гадаргуутай хучилтанд байрлуулсан тохиолдолд хэмжилтийн алдаа /зөрүү/ их болдог байна. Хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үйлчлэлд бетон хучилт нь асфальтбетон хучилтыг бодвол гадаргуун тэгш байдлаа харьцангуй удаан хугацаанд хадгалдаг. Ийм шалтгаанаар WIM системийн суурилуулах хэсэгт мэдрэгчээс хоёр талдаа 50м-ээс багагүй урттай бетон хучилт дэвсэхийг зөвлөдөг байна (K.D.Sekula, 2011).

## Weigh-In-Motion Sensor Technologies



18-р зураг. WIM системийн мэдрэгчийн технологийн төрөл

WIM систем ихэвчлэн хос магнитан утсан холбоос (тээврийн хэрэгслийн хурд хэмжих), хүчний мэдрэгч (WIM мэдрэгч) хоёроос тогтсон байдаг. Эдгээр мэдрэгч системийг бетон хучилтанд суурилуулдаг. Суурилуулсны дараа талбай дээр тохиргоо хийхийн тулд хөдөлгөөний нэг долоо хоног хаах шаардлагатай.

WIM системийн мэдрэгчийг геометр хэмжээсээр нь хоёр групп хуваадаг. Үүнд: хавтан хэлбэрийн мэдрэгч, туузан /утсан/ хэлбэрийн мэдрэгчтэй.

Хавтан мэдрэгч нь босоо хүчийг мэдрэгч нэг ба түүнээс олон датчиктай, хатуу рамд бэхлэгдсэн хөшүүн хавтангаас тогтдог. Хавтангийн өргөн 300м-ээс багагүй, гэхдээ тэнхлэг хоорондын хамгийн бага зайнаас ихгүй /800мм-ээс ихгүй/ байна.

Туузан мэдрэгч нь дугуйн мөрний хэсэгт байрлуулсан байх ба туузанд мэдрэгдэх дугуй ачааллыг хугацаанаас хамаарсан дохио болгон шилжүүлдэг байна. Туузан мэдрэгч нь хавтан мэдрэгчтэй харьцуулахад нарийвчлал багатай буюу хэмжилтийн алдаа өндөр байдаг. 1970-иад онд Европд туузан мэдрэгчийг хавтан мэдрэгчийн нэг хувилбар болгон гарж хөгжүүлсэн байна.

*Хавтан тавцан хэлбэрийн WIM мэдрэгчийн талаар товч танилцуулья.*

Анхны хавтан хэлбэрийн WIM систем АНУ-д 1950-иад онд гарсан. Хавтан хэлбэрийн WIM нь хөшүүн рам дээр суурилуулсан харимхайн ган хавтангаас бүтсэн ба энэ ган хавтан 1,8м урт, 0,5м өргөн, 25,4мм зузаантай. Энэ төхөөрөмжөөр тээврийн хэрэгслийн баруун, зүүн талын дугуйн ачааллыг хэмждэг. Ган хавтанд тоногдсон цахилгаан хүчдэлийн индикатороор ган хавтангийн хотойлтыг хэмжих зарчимаар хэмжилт хийдэг (40кН ачаалалд 1мм хотойно).

Figure 13 Wheels over a plate and a strip sensor



19-р зураг. Хавтан хэлбэрийн WIM системийн төрөл

Динамик аргын нэг болох хавтан хэлбэрийн мэдрэгч бүхий WIM системийн онцлогийг тодорхойлох зорилгоор уг системийн давуу, сул талуудыг тодорхойлж дараах хүснэгтэд нэгтэн үзүүллээ.

15-р хүснэгт. Хавтан хэлбэрийн WIM системийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>Нарийвчлал өндөр, хэмжилтийн зөрүү маш бага;</li> <li>Ашиглалтын хугацаа дундаж;</li> <li>Температурын нөлөөлөлд өртдөггүй;</li> <li>WIM системийн бусад төрлүүд шиг дохио хувиргах шаардлагагүй;</li> <li>1-2 жил тутамд арчлалт, засвар хийнэ;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зөвхөн бетон хучилтанд суурилуулна;</li> <li>Замын зорчих хэсгийн хангалттай өргөн хэсэгт суурилуулдаг;</li> <li>Өртөг дундажаас өндөр хүртэл олон хувилбартай;</li> <li>Тээврийн хэрэгсэл мэдрэгч хавтангаар явж өнгөрөхөд дуу чимээ гаргадаг;</li> </ul>
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>Энэ төрлийн WIM систем харьцангуй урт ашиглалтын хугацаатай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төхөөрөмжийн дээд талын хавтанг авсан тохиолдолд мэдрэгч аюултай;</li> </ul>

*Ачааллын элемент бүхий мэдрэгч*

Ачааллын элементэн мэдрэгч бүхий төхөөрөмж бол хамгийн эртний /анхны/ WIM системийн нэг юм. Энэ систем нь хөшүүн, ган хавтан бүхий тавцан, түүний хотойлтыг механикаар эсвэл гидродинамикаар дамжуулан төхөөрөмжийн төвд байрлах цахилгаан индикатораар хэмждэг зарчимаар ажилладаг. Энэ тавцан болон мэдрэгчийг бетон элемент, эсвэл хучилтын үнд суурилуулдаг.

16-р хүснэгт. Ачааллын элемент төрлийн WIM системийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>Хамгийн өндөр нарийвчлалтай WIM мэдрэгч;</li> <li>Ашиглалтын хугацаа урт;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хүнд, нүсэр хийцтэй;</li> <li>Эхний хөрөнгө оруулалтын зардал өндөр;</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>• Температурын нөлөөлөлд өртдөггүй;</li> <li>• WIM системийн бусад төрлүүд шиг дохио хувиргах шаардлагагүй;</li> <li>• 24 сард нэг удаа тохиргоо хийнэ;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Суурилуулалтанд кран, бетоны ажил хийгдэх шаардлагатай;</li> <li>• Зөвхөн бетон хучилтанд суурилуулна;</li> </ul>
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>• Ашиглалтын хугацаа урт.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэмтсэн тохиолдолд засварын зардал өндөр;</li> </ul>

Туузан /утсан/ хэлбэрийн WIM мэдрэгчийн талаар товч танилцуулья.

Бүх төрлийн WIM мэдрэгчүүдээс орчин үед өргөн хэрэглэж буй гурван төрлийн мэдрэгчийг товч танилцуулья.

Пезо-цахилгаан (piezoelectric sensor) мэдрэгч нь үйлчилж буй хүчтэй пропорциональ цахилгаан хүчдэл үүсгэх зарчимаар ажилладаг. Энэ төрлийн мэдрэгчийн материалаар кристалл (кварц г.м.), керамик (хар тугалга цирконжуулсан титанит г.м.), пезо-полимер зэргийг хэрэглэж байна. Пезо-кварц мэдрэгч нь 51мм өргөн, 51мм зураан, 1.5-2м урттай тууз байх ба суурилуулахад хялбар. Кварц температурын нөлөөлөлд мэдрэг бус буюу -10<sup>0</sup>С -аас +30<sup>0</sup>С хэлбэлзлэлд 7%-ийн мэдрэг шинж чанартай тул температурын хэлбэлзлэлд хэмжилтийн алдаа бага байдаг (D. Cornu, 2014). Пезо-утсан, пезо-керамик, пезо-полимер мэдрэгчүүд температурын нөлөөлөлд мэдрэг тул температураас хамаарч хэмжилтийн алдаа /нарийвчлал бага/ гардаг байна. Иймд энэ төрлийн мэдрэгчүүдийн тохиргоо бага давтамжтай, олон хийх шаардлагатай байдаг байна. Пезо-полимер мэдрэгч нь харьцангуй хямд, ашиглалтын үеийн зардал багатай, гэхдээ температурын үйлчлэлд мэдрэг, нарийвчлал багатай, давтамжит тохиргоо шаардлагатай. Ер нь пезо-керамик, пезо-полимер мэдрэгчдийг тээврийн хөдөлгөөний судалгаа /хөдөлгөөний эрчим, бүрэлдэхүүн г.м./ -ны өгөгдөл цулгуулахад ашиглах нь илүү тохиромжтой, харин тэнхлэгийн ачааллын хэмжилтэнд оновчгүй болохыг мэргэжилтнүүд тогтоосон байна (Burnos, 2016).

Динамик аргынбас нэг төрөл болох пезо-цахилгаан мэдрэгч бүхий WIM системийн онцлогийг тодорхойлох зорилгоор уг системийн давуу, сул талуудыг тодорхойлж дараах хүснэгтэд нэгтэн үзүүлээ.

17-р хүснэгт. Пезо-цахилгаан мэдрэгч бүхий WIM системийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>• Динамик шинж чанар сайтай;</li> <li>• Гаралтын дохио /output signal/-д цахилгаан эх үүсвэр шаардахгүй;</li> <li>• Пезо-кварц мэдрэгч температурын нөлөөлөлд тогтвортой /мэдрэг бус/;</li> <li>• Пезо-цахилгаан мэдрэгчид шууд хүчтэй цахилгаан дохио гардаг;</li> <li>• Хучилтанд байрлуулах мэдрэгч систем нь харьцангуй жижиг хөндлөн огтлолтой;</li> <li>• Суурилуулах хялбар, зардал бага;</li> <li>• Өрсөлдөхүйц өртөгтэй;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Статик ачааллын хэмжилтэнд ашиглах боломжгүй;</li> <li>• Температурын бага хэлбэлзэлд ажиллана;</li> <li>• Пезо-керамик мэдрэгчид температурын тохиргоог ойрхон давтамжтай хийж байх шаардлагатай;</li> <li>• Пезо-полимер мэдрэгч температурын нөлөөлөлд өндөр мэдрэг шинж чанартай;</li> <li>• Пезо-кварц, пезо-керамик мэдрэгчид хэврэг, нимгэн хавтгай хавтан хэлбэртэй;</li> <li>• Хүчний дохио /үйлчлэл/-г хувиргаж дамжуулдаг;</li> <li>• Пезо-кварц мэдрэгчийн хэмжилтийн үр дүн замын тэгш байдлаас ихээхэн</li> </ul>

	хамаардаг тул 12-18 сар тутамд тохиргоо хийдэг.
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>• Авто замын хөдөлгөөний эрчмийн судалгааг тасралтгүй хийхэд хэрэглэх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тохиргоо хоцрогдох, эсвэл хийгдээгүй тохиолдолд хэмжилтийн үр дүн үнэн зөв гарахгүй.</li> </ul>

*Зөөврийн WIM систем*

Туузан /утсан/ хэлбэрийн WIM мэдрэгчийг зөөврийн буюу түр хугацаанд замд суурилуулан замын хөдөлгөөний эрчим болон ачааллын судалгаанд ашигладаг. Пезо-цахилгаан (piezoelectric sensor) мэдрэгч бүхий системийг энэ маягаар ашигласан жишээг дорх товч үзүүлэв.


Утсан хэлбэртэй пезо-цахилгаан мэдрэгчийг замын хучилтын гадаргууд наан тогтоож, дохио хүлээн авах зориулалтын системд холбон хэмжилт явуулдаг /20-р зураг/.



**Figure 2.2** Measurement Specialties Roadtrax BL piezoelectric sensor



**Figure 3.4** Pocket tape insertion using fishing wire and lubricant



**Figure 3.5** The fixture affixing

*20-р зураг. Зөөврийн WIM систем*

Пезо-цахилгаан мэдрэгч бүхий зөөврийн WIM системийг замын ашиглалтын түвшинд үнэлгээ хийхэд өгөгдөл цуглуулах, ачааллын хэмжилтанд хяналт явуулах болон бусад чиглэлийн судалгаа шинжилгээний зорилгоор автозамын хучилтанд 3-7 хоногийн хугацаатай байрлуулан хэмжилт хийдэг байна. Пезо-цахилгаан мэдрэгч бүхий зөөврийн WIM системийн бүрдэл, хэмжилтийн өгөгдөл дамжуулах онцлогийн дараах зурагт үзүүлэв<sup>9</sup>.

<sup>9</sup> [https://www.researchgate.net/publication/347970977\\_Weigh-in-motion\\_sensors\\_and\\_traffic\\_monitoring\\_systems\\_-\\_State\\_of\\_the\\_art\\_and\\_development\\_trends](https://www.researchgate.net/publication/347970977_Weigh-in-motion_sensors_and_traffic_monitoring_systems_-_State_of_the_art_and_development_trends)




Figure 2.1 Portable WIM system architecture

21-р зураг. Зөөврийн WIM системийн бүрэлдэхүүн

Тээврийн хэрэгсэлд суурилуулдаг WIM системийн онцлог

Тээврийн хэрэгсэлд суурилуулсан WIM систем (On-board weighing - OBW) нь харьцангуй шинэлэг технологи хэдий ч үүнийг хөгжингүй орнуудад хэрэглэдэг болоод нилээд удаж байна. Ийм системийн анхны хувилбар нь тээврийн хэрэгсэлд суурилуулсан төхөөрөмжийн өгөгдөл мэдээллийг тээврийн хэрэгслийг зогсож байх үед буюу статик төлөвт байхад авдаг /хэмждэг/ байсан байна. Иймд Австрал зэрэг оронд ачааны тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг зогсоол, амрах талбай, гэрлэн дохион дээр зогсоход нь жинлэдэгээр зохион байгуулдаг байна<sup>10</sup>.



22-р зураг. Тээврийн хэрэгсэлд суурилуулсан WIM систем

OBW нь одоогоор хамгийн найдвартай систем бөгөөд OBW системээс өгсөн өгөгдөл нь 2% нарийвчлалтай, эсвэл  $\pm 500$  кг алдаатай байдаг. Энэ системийн хэмжилтийн заалтын үнэн зөвийг



баталгаажуулахын тулд OBW системийг жилд хоёр удаа суурин жинлэх төхөөрөмж дээр тохиргоо, шалгалт хийж, гэрчилгээ өгдөг байна.

Орчин үед OBW технологийг сайжруулан тээврийн хэрэгслийг явуут дунд нь жинлэдэг динамик OBW системийг ашиглаж эхлээд байна. Динамик OBW системд тээврийн хэрэгслийн жинг тодорхой давтамжаар тасралтгүй хянадаг бөгөөд бусад WIM системийн нэгэн адил "бодит" статик жингийн утгыг нарийн тусгай алгоритмуудыг ашиглан тооцдог.

Зарчмын хувьд динамик OBW системд ачааллын элемент, хүчдэл хэмжигч, хийн ба гидравлик даралт хувиргагч гэх мэт ямар ч төрлийн мэдрэгчийг хэрэглэж болохоос гадна хурдатгал хэмжигч, шилжилт мэдрэгч зэрэг бусад мэдрэгчийг ашиглаж болно.

Мэдрэгчийн технологиос хамааран хэмжилтийн ердийн алдаа  $\pm 1-3\%$  байна. Тухайн хүнд даацын тээврийн хэрэгслийн тээвэрлэлт болон автозамын сүлжээний шаардлагыг дагаж мөрдөж буй эсэхийг хянахад OBW системийг Австрали улс ашиглаж байна.

Тээврийн хэрэгслийн ачааллыг хянах OBW систем нь тээврийн хэрэгслийн бүх жинг хэмжих, тэнхлэгийн ачааллыг хэмжих гэсэн үндсэн хоёр төрөл байдаг<sup>11</sup>.

Тээврийн хэрэгслийн бүх жинг хэмжих OBW системд араа (солих) шилжүүлэх үеийн хүч ба хурдатгал хэмжих, эсвэл хурдатгалын өөрчлөлтийг хэмжих аргад суурилсан технологиудыг ашигласан байна.

Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг хэмжих OBW системд гурван үндсэн мэдрэгч технологийг ашигладаг. Үүнд:

- Ачааллын элемент /ган эд ангийн уян холбоос дээр байрлуулна/;
- Хийн даралтын датчик;
- Хүчдэл хэмжигч;

Figure 22 Examples of OBW sensors



Figure 23 Air Pressure (left) and Load Cell axle load OBW sensor (right)



23-р зураг. Тээврийн хэрэгсэлд суурилуулдаг OBW системийн төрөл

Тэнхлэгийн ачааллын OBW системийг одоогоор уг технологийг уул уурхайн хүнд даацын тээврийн хэрэгсэлд болон хог хаягдлын үйлдвэрт ашигладаг бөгөөд зөвхөн онцгой тохиолдолд болон хүсэлтийн дагуу хүнд даацын машинд ашиглаж байна. Үүний шалтгаан нь үйлдвэрлэл, суурилуулалт, тохиргооны үйл ажиллагаа өндөр өртөгтэй юм. Олон тооны суурилуулалт хийсэн цорын ганц улс бол Австрали улс бөгөөд тэнд тэнхлэгийн ачааллын OBW системтэй тээврийн хэрэгсэл тодорхой чиглэлд илүү их тээвэрлэлт хийх эрхтэй байдаг (Koniditsiotis, Coleman, & Cai, 2012).

<sup>11</sup>Heavy-Duty Vehicle Weight Restrictions in the EU., 2015


Динамик арга буюу Тээврийн хэрэгсэлд суурилуулсан жинлэх OBW системийн онцлогийг тодорхойлох зорилгоор уг аргын давуу, сул талуудыг тодорхойлж, харьцуулалт хийлээ.

19-р хүснэгт. Тээврийн хэрэгсэлд суурилуулсан жинлэх (OBW) системийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>Тээврийн хөдөлгөөний зогсоохгүй хэмждэг.</li> <li>Тэнхлэгийн ачааллыг ямар цаг үед, олон тооны давтамжтай хэмжих боломжтой.</li> <li>Тэнхлэгийн ачааллыг өндөр нарийвчлал, найдвартай хэмжиж тодорхойлно.</li> <li>Хэмжилтэнд хугацаа маш бага зарцуулдаг.</li> <li>Хэмжилт хийх, өгөгдөл цуглуулах ажиллагаа автоматжлагдсан.</li> <li>Хэмжилт явуулахад хөдөлгөөн зохион байгуулалтын нэмэлт арга хэмжээ шаардагддаггүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үйлдэрлэх, суурилуулах, тохиргоо хийх өртөг өндөр;</li> <li>Тохиргоог жилд 2 удаа хийх шаардлагатай;</li> </ul>
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>Машин үйлдвэрлэлд энэ технологийг бүрэн нэвтрүүлснээр хүнд даацын тээврийн хэрэгсэл тэнхлэгийн ачааллын бүрэн хяналттай болох боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Өртөг өндөр тул практикт нэвтрүүлэх ажиллагаа удаашрах магадлалтай.</li> </ul>

Суурин WIM системийг суурилуулах цэгийн ерөнхий схем

Олон улсын туршлагад үндэслэн суурин WIM системээр тэнхлэгийн ачааллын хяналт явуулах цэгийн ерөнхий схемийн 2 жишээг дор үзүүлэв.



Эх сурвалж: <https://www.mosas.com.tr/sinyalizasyon/solutions/wim/>

24-р зураг. Суурин WIM системийг суурилуулах цэгийн ерөнхий схемийн жишээ

Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг явуул дунд нь жинлэх системүүд нь орчин үеийн олон арга, технологи дээр үндэслэсэн байдаг. Иймд эдгээрийн ажиллах /хэмжилт хийх/ арга ажиллагааны ихэнх нь орчин үеийн электрон, цахилгааны онолыг ашигласан, бүрэн автоматжлагдсан, суурилуулалт, тохиргоог мэргэжлийн нарийн ажиллагаа шаарддаг ба харин тухайн системийн ажиллагаа нь бүрэн автоматжлагдсан байна.

Энэ бүх системд тавигддаг үндсэн шаардлага нь хэмжилтийн нарийвчлал, хэмжилтийн зөрүүнд тавигдах хязгаар /хэлбэлзэлийн хэмжээ/ юм. Энэ чиглэлээр 2002онд ASTM E 1318-02-02 Standard Specification for Highway Weigh – In – Motion (WIN) system with User Requirements and Test Methods<sup>12</sup> гарсан бөгөөд үүний монгол хувилбар нь 2015онд MNS E 1318-02-2015 “Автомашинь жинг хөдөлгөөн дунд хэмжих системийг турших арга ба хэрэглэгчийн шаардлага” стандарт батлагдан гарсан байна.

Дээр дурдсан тоног төхөөрөмжийн үнэ, өртөгийн тойм судалгааг хийж, Хавсралт 8-д орууллаа.

#### **2.6.4 Авто замын уян харимхайн модуль тодорхойлох заавар**

Төслийн даалгаварт заасан “Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг талбай дээр хэмжих, дүн шинжилгээ хийх заавар боловсруулах” ажлын хүрээнд авто замын салбарт хэрэглэгдэж буй программ хангамж, тооцооны арга, олон улсын төслүүдэд тавигддаг шаардлага зэргийг судалсны үндсэн дээр дараах аргачилсан заавруудыг боловсрууллаа.

Авто замын бат бэхийн үзүүлэлт тодорхойлох чиглэлээр 2 заавар:

- I. Авто замын уян харимхайн модуль тодорхойлох заавар;
- II. Уян харимхайн модулийг ESAL-д шилжүүлэх

заавар; Эдгээр заавруудыг дэлгэрэнгүйгээр дараах танилцуулж байна.

### **I. АВТО ЗАМЫН УЯН ХАРИМХАЙН МОДУЛЬ ТОДОРХОЙЛОХ ЗААВАР**

#### *Авто замын уян төрлийн хучилтын бат бэхийн үзүүлэлт*

Уян хучилттай замын бат бэхийг тодорхойлдог аргуудын нэг нь уян харимхайн модулийн арга юм. Уян төрлийн хучилттай зам автомашины дугуйн ачааллын үйлчлэлээр хотойдог. Энэ хотойлтын хэмжээ нь хучилтын бат бэхийн үндсэн үзүүлэлт болдог. Хучилтын бат бэхийн хоёр дахь үзүүлэлт нь хучилт хотойход үүсдэг хотойлтын тогооны радиус байдаг. Туршлагаас үзэхэд хотойлтын тогтоон диаметр 3-4м ба түүнээс их байдаг.

Хучилтын бат бэхийг хотойлтын үзүүлэлтээр тодорхойлдог хоёр үндсэн арга байдаг. Үүнд, статик ачааллын үйлчлэлээр үүсэх хотойлтоор бат бэхийг тодорхойлох арга, динамик ачааллын үйлчлэлээр үүсэх хотойлтоор бат бэхийг тодорхойлох арга юм.

Хотойлтын хэмжилтийг хаврын улиралд агаарын температур тогтвортой +10<sup>0</sup>C-аас дээш байдаг болсон үед хийнэ.

#### *Статик ачааллын үйлчлэлээр үүссэн хотойлт хэмжих арга*

12 Энэ стандарт нь ASTM-ийн Тээврийн хэрэгсэл ба Хучилтын систем E17 зөвлөлийн хариуцсан чиглэлд хамрагдах бөгөөд Хөдөлгөөний хяналт E17.52 дэд зөвлөлийн шууд хариуцдаг. Стандартын өнөөгийн хувилбарыг 2002.01.10-д зөвшөөрсөн. 2002 оны 2-р сард хэвлэгдсэн. Анхны хувилбар нь E1318-90 байсан. Сүүлийн хувилбар нь E1318-00 байсан.

Энэхүү арга нь авто замд тээврийн хэрэгслийн дугуйгаар статик ачаалал үйлчлүүлж, хучилтын гадаргуун хэв гажилтыг Бенкелмены багаж ашиглан талбай дээр хэмжихэд үндэслэнэ.


#### Багаж хэрэгсэл

- 1) Бенкелманы багаж
- 2) Ачаа бүхий тээврийн хэрэгсэл
- 3) Тэнхлэгийн даац хэмжигч зөөврийн жин
- 4) Хучилтын гадаргуун температур хэмжих термометр
- 5) Жижиг өрөмний багаж
- 6) 1,0 м урт төмөр шугам

#### Бэлтгэл ажил:

Тээврийн хэрэгслийг хэмжилтэд бэлдэх:

1. Энэхүү туршилтад арын тэнхлэг дээрээ давхар дугуйтай ачааны автомашиныг хэрэглэх бөгөөд давхар дугуйнуудын элэгдэл, хийн даралт адил байна. Давхар дугуйн хооронд 2-3см зайтай байхаар дугуйнуудын хийг тохируулан хийлнэ.
2. Тээврийн хэрэгслийн арын тэнхлэгийн хоёр талын дугуйнд ирэх ачаалал тэнцүү байхаар ачааг тээврийн хэрэгслийн тэвшинд жигд, тэнцүү байрлуулна.
3. Тээврийн хэрэгслийн тэнхлэг болон дугуйн ачааллыг зөөврийн жин ашиглан хэмжинэ. Зөөврийн жинд Зурагт зааснаар тэгш, хатуу гадаргуу дээр хоёр дугуйн мөрний дагуу байрлуулна. Ачаатай тээврийн хэрэгслийг зөөлөн болгоомжтойгоор зөөврийн жин дээр гаргаж зогсоон, урд тэнхлэг дээрх дугуйнуудын ачааллыг хэмжиж авна. Дараа нь ард дугуйгаар мөн зөөврийн жин дээр гарган ард тэнхлэгийн дугуйн ачааллыг хэмжинэ. Хэрэв хэмжилтээр нэг тэнхлэгийн хоёр талын дугуйн ачаалал өөр гарвал, ачааг гар аргаар эсвэл механизмаар тэгшилж тэнцүүлэн хэмжилтийг дахин хийнэ.
4. Ачаатай автомашиныг хатуу хучилттай гадаргуу дээр зогсоон, тэнхлэг хоорондын болон дугуй хоорондын зай, дугуйн өргөн, диаметрыг хэмжиж авна. Арын тэнхлэгийн дугуйн мөрийг шохойгоор тэмдэглэн, дугуйн мөрний диаметр, талбайг хэмжинэ.



25-р зураг. Зөөврийн жингээр урд тэнхлэгийн дугуйн ачаалал хэмжих



26-р зураг. Зөөврийн жин дээр тээврийн хэрэгслийг байрлуулах

Туршилтанд хэрэглэж буй тээврийн хэрэгслийн тэнхлэгийн, дугуйн геометр хэмжээс болон жин, ачааллыг гурваас цөөнгүй удаа давтан хэмжиж тэмдэглэнэ.

#### *Хэмжилт хийх газрыг сонгох*

Туршилт, хэмжилт хийж, дүгнэлт, үнэлгээ гаргах гэж буй тухайн авто замын бодит байдлыг бүрэн илэрхийлэхүйц хэсгүүдийг сонгон авах зорилготой. Иймд тухайн замын нийт уртад нүдэн үзлэг / visual inspection / хийж, эвдрэлийн хэмжээ, ашиглалтын чанар, далан, ухмалтай хэсэг зэргийг тооцон сайн, дунд, муу, эсвэл эвдрэлгүй, эвдрэл багатай, эвдрэл ихтэй, өндөр далантай, нам далантай, ухмал хэсэг гэх мэт хэсгүүдэд хуваан ангилна. Тухайлбал:


- эвдрэлгүй хэсэг;
- харьцангуй бага эвдрэлтэй хэсэг (хагарал нийт гадаргуун 15% хүртэл);
- эвдрэлтэй (хагарал нийт гадаргуун 30% хүртэл);
- харьцангуй их эвдрэлтэй эвдрэлтэй (хагарал нийт гадаргуун 50% хүртэл, нүх нийт гадаргуун 15% хүртэл);
- эвдрэл ихтэй (хагарал нийт гадаргуун 50%-иас их, нүх болон бусад төрлийн эвдрэл 15%-иас их байх);

Ангилсан хэсгүүдээс дагуу налуу нь 20 промилиос ихгүй байх, 1-3 хүртэл хэсгийг сонгон авна. Хэсгүүдийн урт өөр өөр байж болно.

Сонгосон хэсгийн хучилтын температурыг хэмжих 8-12мм-ийн диаметртэй, 40-50мм гүнтэй нүхийг хучилтад өрөмдөж гаргана.

#### *Хэмжилтийн ажил*

Бенкельман багажаар хучилтын хотойлт хэмжихэд 6-р зурагт үзүүлсэн багажийг ашигладаг. Бенкельман багаж энгийн хөшүүргийн зарчмаар ажилладаг. 2,44м урт зонд, хучилтын хөдөлгөөн мэдрэгч 0,0254мм (25μm)-ийн нарийвчлалтай индикаторын тусламжтайгаар хучилтын хотойлтыг хэмжинэ.




27-р зураг. Бенкелман багаж(1- багажны эх бие, 2-хэмжигч зонд, 3-хотойлт хэмжигч индикатор, 4-багажны хөл, 5-барил) 28-р зураг. Термометр

#### *Хэмжилт хийх дараалал:*

Сонгон авсан хэсгүүдийн тухайн нэг хэсэгт хэмжилт хийх цэгүүдийг тогтооно. Цэгүүд нь хучилтын ирмэгээс 0,3-0,5м-ийн зайд, хоорондоо 6м-ээс багагүй зайтай байхаар тогтоож, будгаар хучилт дээр тэмдэглэнэ. Хэмжилтийн цэгийн байрлал, шороон далан хучилтын ашиглалтын түвшин, эвдрэл байдлыг хэмжилтийн дэвтэрт тэмдэглэх, фото зураг авах, цэгийг байрлалыг будгаар тэмдэглэх ажлыг гүйцэтгэнэ.

Хучилтын температурыг тодорхойлохын тулд хучилтанд өрөмдөж гаргасан 12мм голчтой, 40-50мм гүнтэй нүхийг усаар дүүргэн термометрээ түүнд хийж, температур тогтворжиход үзүүлэлтийг тэмдэглэж авна.


Хучилтын температурыг хэмжсэний дараа туршилтын ачааны автомашиныг хэмжих цэгээс 1.4м-ээс багагүй зайд зогсооно. Бенкелман багажны зондыг ачааны автомашины арын тэнхлэгийн аль нэг талын хос дугуйн хооронд шургуулан, дугуй хучилттай шүргэлцсэн хэсгээс 1.37м-ээс багагүй зайд зондын үзүүр хучилтанд тулж байхаар байрлуулна. Дугуйн мөрний тэнхлэгээс 0,3м-ийн зайтайгаар 8-10 цэгийг хучилтан дээр тэмдэглэнэ. Индикаторын зүүг 0.00мм-ээс эхлэн уншихаар тохируулна.



22-р зураг. Хэмжилтийн эхлэл дэх бенкелман багажны байрлал



23-р зураг. Бенкелман багаж байрлуулсан байдал




29-р зураг. Хэмжилтийн багаж, дугуйн харилцан байршил: 3 - 4 цэгийн хооронд 0,9м; 4-5 цэгийн хооронд 2.7м; 7-6 ба 6-5 цэгийн хооронд зайн харьцаа 1:4 байна.

Ачааны автомашиныг урагш 8м зайд бага (1-2км/ц) хурдтай явуулж, индикаторын хамгийн их үзүүлэлтийг 0,0254мм-ийн нарийвчлалтай уншиж тэмдэглэнэ. Хэмжилтийн 1 цэг дээр ачааны автомашины арын тэнхлэгийн хоёр талын дугуйн дээр 3-аас цөөнгүй удаа хэмжилт хийнэ.

Хэмжилтийг гурваас цөөнгүй хүнтэй явуулна. Эхний хүн бенкелман багажны индикаторын уншилтыг хийнэ. Хоёр дах хүн ачааны автомашины дугуйн тэмдэглэсэн (8-10 цэг) цэгүүд дээр ирэхэд индикаторын уншилт хийх дохио өгнө. Гурав дахь хүн хэмжилтийн бичилт хийнэ.

Хэрэв хэмжилтийн 3 удаагийн үзүүлэлтүүдийн хооронд 25%-иас их ялгаатай байвал хэмжилтийн давтан гүйцэтгэнэ.



30-р зураг. Хотойлтын хэмжилт хийх үндсэн зарчим

Тооцоо, үр дүн боловсруулалт:

Нэгж даралт тодорхойлолт

Ачааны автомашины дугуйн мөрний талбайн хэмжилтийн үзүүлэлтээр дугуйн мөрний талбайг тодорхойлно. Автомашины арын тэнхлэгийн аль нэг талын дугуйн хучилтанд үзүүлэх нэгж даралтыг дараах томъёогоор тодорхойлно.

$$q = \frac{Q_i}{S_i};$$

Энд,  $q$  - дугуйн ачааллын нэгж даралт, мПа;  $Q_i$  – дугуйн ачаалал, тн;  $S_i$  – дугуйн мөрний талбай, см<sup>2</sup>;

Хотойлтын үзүүлэлт тодорхойлох:

Хучилтын  $t$  температуртай үеийн хотойлтыг  $\lambda$  дараах томъёогоор тодорхойлно.

$$l(t) = 2 * (l_{max} - l_i);$$

Үүнд,  $l_{max}$  - индикаторын хамгийн их уншилт, мм;


$l_i$  - индикаторын сүүлчийн уншилт, мм;

Хотойлтын хэмжээг 20<sup>0</sup>С-ийн температуртай үеийн хотойлтын угтанд шилжүүлэхдээ томъёогоор тооцно.

$$l_{20} = l(t) + \frac{20 - t}{110};$$

Энд,  $t$  – хэмжилтийн үеийн хучилтын температур, <sup>0</sup>С;

Мөн түүнчлэн 150мм хүртэл зузаантай асфальтбетон үеийн температур 4-49<sup>0</sup>С байхад хийсэн хэмжилтийн үр дүнг 9-р зурагт өгсөн графикаар засварлаж болно.



31-р зураг. Хэмжсэн хотойлтын үр дүнг температураар засварлах график

Тухайн цэгт хэмжсэн хотойлтын үзүүлэлтүүдийн дундаж утгыг  $l$  тодорхойлно.

$$l = \frac{\sum li}{n};$$

Энд,  $\sum li$  – хотойлтын хэмжилтийн үзүүлэлтүүдийн нийлбэр;  $n$  – хэмжилтийн тоо;

Уян харимхайн модуль тодорхойлох:

Хучилтын хотойлтын үзүүлэлтээр дараах томъёог ашиглан хучилтын уян харимхайн модулийг тодорхойлно.

$$E_i = \frac{\rho \cdot D}{l} (1 - \mu^2);$$

$E = \frac{\rho \cdot D}{l} (1 - \mu^2)$  Үүнд,  $\rho$  - автомашины дугуйн ачааллын нэгж даралт;

$D$ - ачаалал үзүүлж буй дугуйн мөрний талбайн диаметр;

$l$  – хучилтын хотойлт;

$\mu$  - Пуассоны коэффициент,  $\mu = 0.3$  ;

*Шороон далангийн чийгшил, уян харимхайн модуль хоорондын хамаарлыг тооцох*

Авто замын уян харимхайн модулийн үзүүлэлтэнд асфальтбетон хучилтын температур нөлөөлөхөөс гадна шороон далангийн чийгийн хэмжээ ихээхэн нөлөөлдөг. Шороон далангийн чийгийн агууламж улирлын чанартай өөрчлөгдөж байдаг ба хамгийн их чийг хуримтлагдсан үе нь хаврын гэсэлтийн үе байдаг.

Авто замын хучилтын үндсэн үүрэг зориулалт нь тээврийн хэрэгслийн дугуйгаар үйлчлэх ачааллыг даланд дамжуулах явдал байдаг. Хучилтаас доош 0,5-1,0м гүнтэй далангийн үе давхаргад тээврийн хэрэгслийн ачаалал идэвхитэй нөлөөлж, даралт үзүүлж байдаг. Далангийн энэ үе давхаргыг далангийн идэвхит үе гэж нэрлэдэг. Далангийн идэвхит үеийн чийгийн агууламжаас хамааран түүний уян харимхайн модуль өөрчлөгдөж байдаг. Үүнийг доорх хүснэгтээс дүгнэнэ.





Хөрсний төрөл	Хөрсний уян харимхайн модуль, МПа (чийгийн агууламж 0,50-0,95 байхад)									
	0,50	0,55	0,60	0,65	0,70	0,75	0,80	0,85	0,90	0,95
Элс: Том ширхэглэлтэй Дунд ширхэглэлтэй Жижиг ширхэглэлтэй Нарийн ширхэглэлтэй	130 120 100 75									
Тоосорхог элс	96	90	84	78	72	60	60	54	48	43
Элсэнцэр: Хөнгөн элсэнцэр Тоосорхог, хүнд тоосорхог элсэнцэр	70 108	60 90	56 72	53 54	49 46	45 38	43 32	42 27	41 26	40 25
Том ширхэглэлтэй, хөнгөн элсэнцэр	65									
Шавранцар: Хөнгөн шавранцар Хөнгөн тоосорхог шавранцар	108 108	90 90	72 72	50 54	41 46	34 38	29 32	25 27	24 26	23 25
Шавар	108	90	72	50	41	34	29	35	24	23

21-р хүснэгт: Шавранцар, шавар төрлийн хөрсний хэв гажилтын модулийн норматив үзүүлэлт

Шавранцар, шавар төрлийн хөрсний хэв гажилтын модулийн норматив үзүүлэлт, E, МПа												
Хөрсний төрөл ба тэдгээрийн хязгаарын үзүүлэлт $I_L$	Хөрсний урсгалтын норматив	Хөрсний хэв гажилтын модуль E, МПа (сүвшилийн коэффициент e –ийн доорх угганд)										
		0,35	0,45	0,55	0,65	0,75	0,85	0,95	1,05	1,2	1,4	1,6
Элсэнцэр	$0 < I_L \leq 0,75$	—	32	24	16	10	7	—	—	—	—	—
Шавранцар	$0 < I_L \leq 0,25$	—	34	27	22	17	14	11	—	—	—	—
	$0,25 < I_L \leq 0,5$	—	32	25	19	14	11	8	—	—	—	—
	$0,5 < I_L \leq 0,75$	—	—	—	17	12	8	6	5	—	—	—
Шавар	$0 \leq I_L \leq 0,25$	—	—	28	24	21	18	15	12	—	—	—
	$0,25 < I_L \leq 0,5$	—	—	—	21	18	15	12	9	—	—	—
	$0,5 < I_L \leq 0,75$	—	—	—	—	15	12	9	7	—	—	—
Элсэнцэр	$0 \leq I_L \leq 0,75$	—	33	24	17	11	7	—	—	—	—	—
Шавранцар	$0 \leq I_L \leq 0,25$	—	40	33	27	21	—	—	—	—	—	—
Шавранцар	$0,25 < I_L \leq 0,5$	—	35	28	22	17	14	—	—	—	—	—
	$0,5 < I_L \leq 0,75$	—	—	—	17	13	10	7	—	—	—	—

Элсэнцэр Шавранцар	$I_L \leq 0,5$	60	50	40	—	—	—	—	—	—	—	—
Шавар	$0,25 \leq I_L \leq 0$	—	—	—	—	—	—	27	25	22	—	—
	$0 < I_L \leq 0,25$	—	—	—	—	—	—	24	22	19	15	—
	$0,25 < I_L \leq 0,5$	—	—	—	—	—	—	—	—	16	12	10


Шороон далангийн чийгшлээс хамааран авто замын уян харимхайн модуль буурдаг болохыг ОХУ-д хийсэн талбайн хэмжилт судалгааны үр дүн баталж байна.

22-р хүснэгт: Талбайн хэмжилтийн үр дүн

Хэмжилтийн зам ба хучилтын бүтээц	Замын уян харимхайн модулийн хэмжилтийн үр дүн, МПа				
	0,65	0,70	0,75	0,80	0,85
Зам 1: Нягт асфальтбетон -5см; Сүвэрхэг асфальтбетон -7см; Харлуулсан дайрган үе – 20см; Дайрган суурь – 38см; Далан – хөнгөн элсэнцэр хөрс	308	276	228	206	174
Зам 2: Нягт асфальтбетон -5см; Сүвэрхэг асфальтбетон -8см; Харлуулсан дайрган үе – 18см; Дайрган суурь – 36см; Далан – тоосорхог элсэнцэр хөрс	256	224	204	192	164

Эх сурвалж: <https://research-journal.org/technical/sezonnye-izmeneniya-prochnosti-dorozhnyx-odezhd-2/>

Замын шороон далангийн чийгийн агууламж их байх тутам ачааллын үйлчлэлээр авто замд үүсэх хотойлтын хэмжээ ихэсэж, улмаар замын нийт уян харимхайн хотойлт буурдаг.



31-р зураг. Хөрсний уян харимхайн модулийн улирлын өөрчлөлт: 1 — гэсгэлэн хөрс; 2 — хөлдсөн хөрс; 3 — хаврын улиралд хэт чийглэгдсэн хөрс; Еотн — уян харимхайн модулийн харьцангуй үзүүлэлт; h — хөрсний гүн;

Дээрх судалгааны графикаас дүгнэхэд хөрсний уян харимхайн модуль улирлын хөлдөлт, гэсэлт, чийгийн агууламжаас хамааран эрс өөрчлөгдөж байна.

Хөрсний уян харимхайн модуль хаврын гэсэлтийн үед 3-р сарын сүүлчээс 5-р сарын 20 хүртэл (зам-уур амьсгалын бүсчлэлээр эхлэл, төгсгөлийн хугацаа урагш, хойш болно.) хугацаанд 10 дахин буурч байдаг. Иймд энэ хугацаанд хүнд даац тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хязгаарласнаар авто замд учруулах эвдрэл гэмтлийн ноцтой үр дагаварасс с урьдчилан сэргийлж чадах болно.

Өвлийн улиралд хөрс хөлдөхөд хөрсний уян харимхайн модуль 11-р сарын эхээс 3-р сарын 10 хүртэл хугацаанд 20 дахин нэмэгдэж, ачаалал хүлээн авах чадвар нь эрс нэмэгддэг байна. Энэ хугацаанд хүнд даац тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэхэд замд ачааллын нөлөөгөөр үүсэх эвдрэл бага байх болно.

## II. УЯН ХАРИМХАЙН МОДУЛИЙГ ESAL-Д ШИЛЖҮҮЛЭХ ЗААВАР

Авто замын салбарт хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмжөөс нэгтгэх тооцооны үзүүлэлтүүд ихэнхдээ ESAL-аар илэрхийлэгдэх тул ESAL-ийг уян харимхайн модуль руу шилжүүлэх, уян харимхайн модулийг ESAL руу шилжүүлэх практик шаардлага байгаа болно. Иймэс уян хучилтын тооцооны аргачлалаар тодорхойлсон хучилтын бүтээцийн нийт уян харимхайн модулийг ойролцоогоор ESAL-д шилжүүлэхдээ дараах дарааллаар урвуу тооцоог хийж болно. Үүнд:

1. Хучилтын үеүдийн уян харимхайн модуль, үеийн зузааныг тооцон хоёр үет эквивалент уян харимхайн модулийн аргаар хучилтын бүтээцийн нийт уян харимхайн модулийг  $E_{\text{общ}}$  тодорхойлох (ОДН 218.046-01 Проектирование нежестких дорожных одежд);
2. Хучилтын бүтээцийн нийт уян харимхайн модулиар зөвшөөрөгдөх уян харимхайн модулийг тодорхойлох;

Зөвшөөрөгдөх уян харимхайн модулийг ОДН 218.046-01 Проектирование нежестких дорожных одежд нормын 3.9-р томъёог ашиглан тодорхойлно.

$$E_{\text{общ}} \geq E_{mi} * K_{tr} ; \quad E_{mi} = \frac{E_{\text{отн}}}{K_{tr}}$$

Энд,  $E_{\text{общ}}$ - хучилтын бүтээцийн нийт уян харимхайн модуль, мПа;

$E_{\text{min}}$  - Зөвшөөрөгдөх уян харимхайн модуль, мПа;

$K_{tr}$  - найдваржилтын тооцсон шаардагдах бат бэхийн коэффициент (ОДН 218.046-01 Проектирование нежестких дорожных одежд нормын 3.6-р хавсралтын 3.1-р хүснэгт);

3. Тооцоот ашиглалтын хугацаанд үйлчлэх хөдөлгөөний эрчмийн стандарт тэнхлэгийн ачаалалд шилжүүлсэн үзүүлэлтийг (стандарт ачаалалд шилжүүлсэн тооцоот хөдөлгөөний эрчим)  $\sum N_p$  тодорхойлох;

Стандарт ачаалалд шилжүүлсэн тооцоот хөдөлгөөний эрчим  $\sum N_p$  -ийг ОДН 218.046-01 Проектирование нежестких дорожных одежд нормын 3.10-р томъёонд дараах хувиргалт хийн тодорхойлно.

$$E_{\text{min}} = 98.65 [lg(\sum N_p) - c] ; \quad lg(\sum N_p) = \frac{E_{\text{min}}}{98.65} + c ;$$

$$\sum N_p = 10^{\frac{E_{\text{min}}}{98.65}}$$

Энд,  $\sum N_p$  - Тооцоот ашиглалтын хугацаан дах стандарт ачаалалд шилжүүлсэн тооцоот хөдөлгөөний эрчим;

$C$  – эмпирик үзүүлэлт, тэнхлэгийн тооцоот ачаалал 100кН бол  $c=3.55$ , 110кН бол  $c=3.25$ , 130кН бол  $c=3.05$ ;

4. Тэнхлэгийн стандарт ачааллын харьцуулалтын коэффициентийг тодорхойлох;

AASHTO Хучилт төлөвлөлтийн аргачлалд зааснаар ESAL буюу нэг тэнхлэг дээр стандарт ачааллыг 80кН-аар тооцдог бол ОДН 218.046-01 Проектирование нежестких дорожных одежд нормд зааснаар  $Q_{ст}$  буюу нэг тэнхлэг дээр стандарт ачааллыг 100кН гэж тооцдог. Энэ тэнхлэгийн стандарт ачааллуудын ялгааг тооцохдоо харьцуулалтын коэффициентийг дараах байдлаар тооцож болно. Үүнд:

$$K_{ст.ач} = \frac{ESAL}{Q_{ст}} \quad ; \quad \text{жишээлбэл: } K_{ст.ач} = \frac{80кН}{100кН} = 0.8;$$

5. Стандарт ачаалалд шилжүүлсэн тооцоот хөдөлгөөний эрчим  $\sum N_p$  –ийг  $K_{ст.ач}$  –оор үржүүлэх замаар ESAL-д шилжүүлэх;

## ГУРАВ. ТЭНХЛЭГИЙН АЧААЛЛЫН ХЭТРЭЛТ АВТО ЗАМД УЧРУУЛАХ ХОХИРЛЫГ ТООЦОХ

### 3.1 АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛАЛ ХЭТЭРСНЭЭС АВТО ЗАМД УЧРУУЛАХ ХОХИРЛЫГ ТООЦОХ НЬ

Хүнд даацын тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтэрснээр автозамын элэгдэл хурдасч, улмаар замд эвдрэл эрт хугацаанд үүсдэг бөгөөд энэ автозамын ашиглалтын зардлыг /засварын ажлын зардлыг/ эрс нэмэгдүүлдэг байна. Бусад орны автозамуудад хийсэн судалгаа, дүгнэлтээс дурдвал: АНУ-ын Калифорни мужийн улсын чанартай замуудад WIM систем суурилан ажиглалт, судалгаа хийхэд даац хэтрэлтээс шалтгаалан ашиглалтын зардал 20-30сая доллар жил тутамд гарч байсан байна (V.Dolcemascolo P. B., 2015). Бразил улсад 2015 онд тээврийн хэрэгслийн 34% орчим хувь нь даац хэтрэлттэй зорчиж байсны улмаас автозамын засвар арчлалтын /ашиглалтын/ зардал 19-38%-иар нэмэгдэж байсныг судалгаагаар тодорхойлсон байна (G.G.Otto, 2019).

Үүнээс гадна тээврийн хэрэгслийн ачаалал хэтрэлт нь хөдөлгөөний аюулгүй байдлыг нэмэгдүүлж, зам-тээврийн ослын тоо, хүндрэлийн түвшинг ихэсгэж байгаа эрдэмтэд судалгаадаа цохон дурдсан байна (S.Hombourger, 2019) (V.Dolcemascolo B. a., 2019) (B.Jacob, 2000).

Энэхүү Төслийн хүрээнд Авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтээс авто замд учруулах хохирол тооцох хоёр аргачлал боловсруулан санал болгож байна.

**НЭГДҮГЭЭР АРГАЧЛАЛ:** Авто замд учруулах хохирлыг тээвэр ашиглалтын зардал, зам хэрэглэгчийн зардлын өсөлтөөр тооцох аргачлал

Тооцооны аргачлалыг дараах байдлаар гүйцэтгэнэ. Үүнд:

1. Ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үйлчлэлээр хучилтын тэгш байдалд гарах өөрчлөлтийг тодорхойлох.
2. Тэгш бус гадаргуутай замаар зорчсоноор үүсэх Тээвэр ашиглалтын зардлын өсөлтийг тодорхойлох;

3. Тэгш бус гадаргуутай замаар зорчсоноор үүсэх хугацаа алдагдлыг тооцож, Зам хэрэглэгчийн зардлын өсөлтийг тодорхойлох;
4. ТАЗ ба ЗХЗ-ын нийт өсөлтийг тодорхойлох;

Энэ аргачлалыг дэлгэрэнгүй дараах байдлаар тайлбарлан оруулав.

#### 1. Хучилтын гадаргуун тэгш байдлын өөрчлөлт

Дэлхийн банкнаас боловсруулсан Models for Planning and Management тайланд уян хучилтын гадаргуун тэгш байдлын өөрчлөлтийг дараах шугаман илэрхийллээр прогнозлон томъёолсон байдаг<sup>13</sup>. Үүнд:

$$R_t = R_0 + s(S) * N_t;$$

Энд,  $R_t$  – хучилтын гадаргуун тэгш байдлын  $t$  хугацаанд өөрчлөлт, м/км;

$R_0$  – хучилтын гадаргуун тэгш байдлын анхны үзүүлэлт, м/км;

$s(S)$  – хучилтын бат бэхийн функц;

$N_t$  – ашиглалтын  $t$  хугацаанд үйлчлэх хөдөлгөөний эрчмийг 80кН стандарт ачаалалд шилжүүлсэн үзүүлэлт;

#### 2. Тээвэр ашиглалтын зардал

Тэнхлэгийн ачаалал хэтрэлттэй тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас замд илт ажиглагдах эвдрэлийн нэг бол хучилтын гадаргуун тэгш байдал буурна. Энэ нь тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалт, эд ангийн элэгдлийг нэмэгдүүлдэг. Замын гадаргуун тэгш байдлын үзүүлэлт тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтад хэрхэн нөлөөлдөг талаар 2012 онд Австрали улсад зохион байгуулагдсан 25th ARRB Conference – Shaping the future олон улсын хуралд тавьсан “Review of vehicle operating costs and road roughness: past, current and future” эрдэм шинжилгээний өгүүлэлд 10 гаруй улс оронд явуулсан судалгааны үр дүнг танилцуулсан нь дунджаар IRI =1.1-5.8м/км байхад IRI-ийн үзүүлэлт нэгээр нэмэгдэх тутамд суудлын машины шатахуун зарцуулалт 0,4-0,8%-иар, ачааны автомашинд 1,1-3,8%-иар, IRI =4.0-7.7м/км үед суудлын машин 1.2-1.6%, ачааны автомашинд 3.5-5.6%-иар тус тус нэмэгдэж байсныг тогтоожээ<sup>14</sup>. (31-р хүснэгт)

*23-р хүснэгт: Тогтмол хурдтай үед замын тэгш байдал шатахуун зарцуулалтад нөлөөлөх байдал*

<sup>13</sup> Томьёо 8.2 <https://documents1.worldbank.org/curated/en/222951468765265396/pdf/multi-page.pdf>

<sup>14</sup> “REVIEW OF VEHICLE OPERATING COSTS AND ROAD ROUGHNESS: PAST, CURRENT AND FUTURE” 25th ARRB Conference – Shaping the future: Linking policy, research and outcomes, Perth, Australia 2012

Улс/ судалгаа	Аргачлал	Тэгш байдлын индекс, м/км	Тээврийн хэрэгслийн төрөл	Зүтгэх хүчний өөрчлөлт (IRI – ийн нэгж өөрчлөлтөнд нэмэгдэх хувь)	Шатахуун зарцуулалт (IRI –ийн нэгж өөрчлөлтөнд нэмэгдэх хувь)
АНУ /Роусс 1982/	IRI, Шатахуун зарцуулалт хэмжих	0,5-3,7	Суудлын автомашин		0,4
АНУ /Бестер 1984/	IRI, зүтгэх хүч	1,4-5,5	Суудлын автомашин	2,6	0,5
АНУ, Флорида / Жексон 2004/	Гилспии ба МакГрей 2007	3.1 – 3.7	Ачааны автомашин		0,13
АНУ, Невада / Епс 2002/	Гилспии ба МакГрей 2007	3.1 – 3.7	Ачааны автомашин		0,45
АНУ/Заавар ба Чагги 2010/	HDM 4 загварчлал	1,0 – 5,0	Суудлын автомашин		0,9
			Ачааны автомашин		0,4
Англи /Янг 1988	IRI, Шатахуун зарцуулалт хэмжих	1,3-4,0	Ачааны автомашин		4,1
		3,3-5,6	Суудлын автомашин		3,1
		2,3-4,4	Суудлын автомашин		3,6
		1,7-5,4	Суудлын автомашин		0,8
Франц 1990	IRI, зүтгэх хүч	1,0-6,0	Суудлын автомашин	6,0	1,2
Бельги 1990	IRI, зүтгэх хүч	0,8-7,7	Суудлын автомашин	4,0	0,8
Швед, 1990	IRI, Шатахуун зарцуулалт хэмжих	1,0-6,0	Суудлын автомашин		1,7
Австрали, 1997	Гипотик 1 км замд	1,2-5,8	Суудлын автомашин		0,9
		1,2-5,8	Ачааны автомашин ХАА-н механизм		1,4 0,9
Шинэ Зелланд, 1999	IRI	1.7-5.3	Ачааны автомашин		0.8

2013 онд Concrete Sustainability HUB байгууллагын хийсэн “Pavement roughness and fuel consumption” сэдэвт төслийн судалгаагаар замын тэгш бус байдлаас хамааран шатахуун зарцуулалтын хэмжээг тооцсон байна.

хучилтын тэгш байдал, IRI, м/км	1	5	8	10
Шатахуун зарцуулалтын өөрчлөлт, %	0	2,7	4,8	6,2

Эх сурвалж: “Pavement roughness and fuel consumption” төслийн тайлан. 2013

2014 онд University of Southern Queensland их сургуульд явуулсан “The Effect of Road Roughness on Traffic Speed and Road Safety” судалгаанд дурдсанаар замын тэгш бус байдлын үзүүлэлт өндөр байхын хэрээр тээвэр ашиглалтын зардал эрс ихэсгэдэг болохыг тодорхойлсон байдаг. Тээврийн хэрэгслийн төрлөөс хамааран 1км тутамд тээвэр ашиглалтын зардал 0,23-2,07ам.доллараар нэмэгдэж байгааг дурдсан байна. Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн улмаас замын тэгш байдал буурч, үүний нөлөөгөөр тээвэр ашиглалтын зардал нэмэгдэх хэмжээг доорх графикт үзүүлэв.




Figure 5: Percentage increase in operation costs dependant on roughness (Al-Rousan, T & Asi, I 2010, p.3)

32- р зураг: Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлт замын тэгш байдал, тээвэр ашиглалтын зардалд нөлөөлөх нь

Дээрх судалгаанд үндэслэн тээвэр ашиглалтын зардлын өсөлтийг замын тэгш байдал бууралтаас хамааруулан тооцвол:

№	Тээврийн хэрэгсэл	Тээвэр ашиглалтын зардлын өсөлт ΔVOC , төг			
		1км-т	10км-т	100км-т	
1	Ачааны автомашин /truck/	2.07USD/km	5920.2	59,202	592,020
2	Суудлын автомашин /car/	0.23USD/km	657.8	6,578	65,780
3	Автобус /bus/	1.06USD/km	3031.6	30,316	303,160

Тэгвэл хоногт 1500 тээврийн хэрэгсэл зорчдог авто замд нийт тээвэр ашиглалтын зардлыг тооцвол:



№	Тээврийн хэрэгсэл	Хөдөлгөөний эрчим, маш/хоног	Тээвэр ашиглалтын зардлын өсөлт ΔVOC , төг			
			1 тээврийн хэрэгсэл 1км-т	1км	10км	100км
1	Ачааны автомашин /truck/	300	5920.2	1,776,060	17,760,600	177,606,000
2	Суудлын автомашин /car/	1050	657.8	690,690	6,906,900	69,069,000
3	Автобус /bus/	150	3031.6	454,740	4,547,400	45,474,000
	Нийт	1,500	9,610	2,921,490	29,214,900	292,149,000

Тооцооноос үзэхэд тодорхой тооны тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн улмаас бусад тээврийн хэрэгслийн тээвэр ашиглалтын зардал 45-177сая төгрөгөөр өсөж байна.

### 3. Зам хэрэглэгчийн зардал

Зам хэрэглэгчийн зардлыг тооцоход зорчих хугацааны зардлын бууралт нь эдийн засгийн гол өгөөжийн нэг болдог. Тэгвэл тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн улмаас замын тэгш байдал буурч, хагарал, нүх үүсч, үүний нөлөөгөөр зорчих хурд буурдаг. Ингэснээр зорчих хугацаа уртсаж, зорчих хугацааны зардал нэмэгдэнэ.

2014 онд хийсэн “The Effect of Road Roughness on Traffic Speed and Road Safety” судалгаанд замын тэгш бус байдлын үзүүлэлт хөдөлгөөний хурдад хэрхэн нөлөөлдгийг тогтоосон байна. Судалгааны үр дүнгээр гаргасан графикт үзүүлснээр замын тэгш байдал муудаж IRI=7м/км болоход суудлын автомашины хурд 60км/ц-аас 45км/ц болж буурдаг байна.

Үүнд үндэслэн зорчих хугацааны уртсалт буюу хугацаа алдагдлыг тооцож үзвэл:

№	Тээврийн хэрэгсэл	IRI=2м/км үед	IRI=7м/км үед	ΔV, км/ц	Зорчих хугацааны уртсалт, цаг		
		V, км/ц	V, км/ц		1км-т	10км-т	100км-т
1	Ачааны автомашин /truck/	50	35	15	0.1	0.7	6.7
2	Суудлын автомашин /car/	60	45	15	0.1	0.7	6.7

Сүүлийн жилүүдэд Монгол улсад хэрэгжсэн тээврийн төслийн судалгаанаас үзэхэд тээврийн хэрэгслээр зорчигчдын цаг хугацааны үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Цаг хугацааны үнэ цэнэ (\$/цаг)			
Тээврийн төрөл	2011 он	2020 он	2030 он
Хувийн унаа	0.832	1.596	3.081
Нийтийн тээвэр	0.378	0.725	1.399

Эх сурвалж: УБ хотод нийтийн тээврийн төсөл хэрэгжүүлэх судалгаа. 2012

Үүн дээр үндэслэн зам хэрэглэгчийн зорчих хугцааны зардлын өсөлтийг тооцвол:

№	Тээврийн хэрэгсэл	Зам хэрэглэгчийн зардлын өсөлт ΔRUC , төг		
		1км-г	10км-г	100км-г
1	Автобус/bus/	138.2	1,382.3	13,823.3
2	Суудлын автомашин /car/	304.3	3,043.0	30,430.4

Тэгвэл хоногт 1500 хүн зорчдог авто замд Зам хэрэглэгчийн зардлыг хугацаа алдагдлын үнэ цэнээр тооцвол:

№	Тээврийн хэрэгсэл	Зорчигчдын тоо	Зам хэрэглэгчийн зардлын өсөлт ΔRUC , төг	
			10км-г	100км-г
1	Автобус/bus/	1200	<b>1,658,800</b>	<b>16,588,000</b>
2	Суудлын автомашин /car/	300	<b>912,912</b>	<b>9,129,120</b>

Тооцооноос үзэхэд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн улмаас зам хэрэглэгчийн зардлыг зөвхөн алдаж хугацааны зардалаар тооцоход 9-16 сая төгрөгөөр зардал нэмэгдэж байна.

**ХОЁРДУГААР АРГАЧЛАЛ:** Авто замын ашиглалтын хугацаанд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн нөлөөг тооцох аргачлал

Авто замын ашиглалтын хугацаанд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн нөлөөг тооцоход хучилтын AASHTO аргачлалд үндэслэсэн аргачлалаас гадна уян харимхайн модулийн аргаар тодорхойлох боломжтой юм.

Тооцооны онолын үндэслэл.

Авто замын нормт ашиглалтын хугацааны төгсгөлд замын бат бэхийн нөөц дуусч, замын бүтээцийг шинээр дахин барих буюу шинэчлэх шаардлагатай болдог. Энэ процессыг нөгөө талаас нь авч үзвэл ОХУ-ын эрдэмтэн В.В.Болотины барилгын конструкцгийн найдваржилтанд анализ хийхдээ байгууламжийн чанар, бат бэхийн үзүүлэлт буурах явц нь элэгдэл, бичил эвдрэлүүдийн хуримтлалын үр дүн болохыг нотолсон байдаг. Энэ тохиолдолд байгууламжийн чанар, бат бэхийн нэгдсэн ойлголтонд нийт эвдрэл  $\sum D$  (Damage) гэсэн нэр томъёог ашиглаж болно. Нийт эвдрэлийн үзүүлэлт шинээр барьсан замд тэгтэй тэнцүү ( $D=0$ ), ашиглалтын хугацааны төгсгөлд нэгтэй тэнцүү ( $D=1$ ) байна.

Нийт эвдрэл (D) нь тээврийн хэрэгслийн тухайн нэг тэнхлэгийн үйлчлэл бүрд нэгж гэмтэлээр ( $\alpha_i$ ) нэмэгдэх буюу нэгж гэмтэл хуримтлагдана. Үүнд үндэслэн гэмтэл хуримтлалын явцыг доорх байдлаар томъёолно.

$$D_{i+1} = D_i + \alpha_i$$

Энд,  $D_i$  - тэнхлэгийн ачааллын  $i$  удаагийн үйлчлэлээр хуримтлагдсан эвдрэл;

$\alpha_i$  –  $i$  дугаар тэнхлэгийн ачааллын үйлчлэлээр үүссэн нэгж гэмтэл;

Ашиглалтын  $t$  хугацаанд замд үүссэн нийт эвдрэл  $\Sigma D$  нь  $t$  хугацааны турш хуримтлагдах нэгж гэмтлүүдийн нийлбэртэй тэнцүү байна (эвдрэлийн кумулятив загвар) .

$$D(t) = \sum_{i=1}^{N_i} \alpha_i;$$

Нэгж гэмтэл нь нэг тэнхлэгийн ачааллын үйлчлэлээр үүсч хучилтанд хуримтлагдах хотойлтын хэмжээтэй тэнцүү [1].

$$\alpha_i = \frac{1}{N} \cdot e^{-(2.76 + 0.28 \cdot l_i)} \quad l_i = 10 \quad l_i;$$

Энд,  $N_i$ - ашиглалтын  $t$  хугацаанд үйлчлэх стандарт тэнхлэгийн тоо;

$l_i$  - нэг тэнхлэгийн ачааллын үйлчлэлээр хучилтанд үүсэх хотойлт;

$$l = 0.36 * \frac{Q_k}{E_A}$$

$E_A$

## ТООЦООНЫ АРГАЧЛАЛ.

Тооцоог дараах дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

1. Тооцоот ачааллыг тодорхойлох: Замыг хөдөлгөөний эрчмийн өгөгдлийг тооцоот ачаалал бүхий эквивалент ачааллын тоонд шилжүүлнэ. Энэ тооцоог Хучилтын тооцооны аргачлалд зааснаар шилжүүлнэ.
2. Замын баг бэхийн нийт уян харимхайн модулиар илэрхийлэн тодорхойлох: Хучилтын үеийн зузаан, материалын шинж чанарын үзүүлэлтээр Хучилтын тооцооны аргачлалаар тухайн замын нийт уян харимхайн модулийг тодорхойлно.
3. Замын уян харимхайн хотойлтыг тодорхойлох: Уян харимхайн хотойлтыг уламжлалт аргачлалын [1] томъёогоор, эсвэл 2003оны ОДН аргачлалд заасан томъёогоор тодорхойлно. Уян харимхай хотойлт:

$$l = \frac{p * D * (1 - \mu)^3}{E_{\text{нийт}}}; \quad (1)$$

энд,  $l$  – уян харимхайн хотойлтын үзүүлэлт, мм;

$p$  – нэгж даралт, мПа;

$D$  – дугуйн мөрний диаметр, см;


$\mu$  – Пуассоны коэффициент;

ОХУ-ын ОДН 218.1.052-2002 нормд заасан уян харимхай хотойлт тодорхойлох томъёо<sup>15</sup>:

$$l = 0.36 * \frac{Q_k}{E_{\text{нийт}}}; \quad (2)$$

<sup>15</sup> ОДН 218.1.052-2002 нормын (2.3)-р томъёо. <https://files.stroyinf.ru/Data1/11/11320/index.htm>





34-р зураг: Гэмтэл хуримтлал /1/


Ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хуримтлагдах эвдрэлийн хуримтлалыг 34-р зурагт үзүүлэв. Эндээс дүгнэхэд тэнхлэгийн ачаалал 15тонн байх тохиолдолд замын ашиглалтын 3жилийн дараа эвдрэлийн хуримтлал D=1 болж, замын бат бэхийн нөөц дуусч байна. Харин тэнхлэгийн ачаалал 12тонн байх тохиолдолд замын ашиглалтын 7,8жилийн дараа эвдрэлийн хуримтлал D=1 болж, замын бат бэхийн нөөц дуусч байна.

24-р хүснэгт: Тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирлын тооцоо /1/

Тооцоо 1						
150мПа бат бэхийн нөөцтэй автозамд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирол						
Тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн хувь	%	0%	2%	10%	20%	50%
Тэнхлэгийн ачаалал	тонн	10	10.2	11	12	15
Тооцоот ашиглалтын хугацаа	жилээр	15 жил				
Ашиглалтын бодит хугацаа	жилээр	15	14.2	10.8	6.8	3
Ашиглалтын хугацааны богиносолт	жилээр	0	0.8	4.2	8.2	12
	%	0%	5%	28%	55%	80%
Анхний хөрөнгө оруулалт	төг	500,000,000				
Их засварын давтамж		1	1			
Их засварын хөрөнгө оруулалт	төг	200,000,000	200,000,000			
Шинэчлэлтийн ажлын давтамж				1	2.2	5.0
Шинэчлэлтийн ажлын хөрөнгө оруулалт	төг			800,000,000	1,764,705,882	4,000,000,000
Тэнхлэгийн ачаалал хэтрэлттэй тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалт үүсэх нөлөөг мөнгөн дүнгээр илэрхийлбэл:						
1км замд үзүүлэх хохирол	төг	4,903	4,903	9,106	15,863	31,520
10км замд үзүүлэх хохирол	төг	49,031	49,031	91,057	158,628	315,197
100км замд үзүүлэх хохирол	төг	490,306	490,306	910,568	1,586,284	3,151,967

Замын байгууламж 150мПа уян харимхайн модультай байх тохиолдолд 2-50% хүртэл тэнхлэгийн ачаалал хэтрэлттэй нэг тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалтаас үүсэх хохирлыг тооцвол 1км замд 4,903 -31,520 төгрөгийн хохирол, 100км замд 460,306 - 3,151,967 төгрөгийн хохирол гарч байна.


35-р зураг: Тооцоот ачааллын давтамж ба ашиглалтын хугацааны хамаарал /2/



Тэнхлэгийн ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг стандарт ачаалалд шилжүүлэн тооцвол тооцоот ачааллын давтамж замын ашиглалтын хугацаанд өөрчлөх явцыг 35-р зурагт үзүүлээ.

Ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс  $E=160\text{MPa}$  бат бэхтэй замд хуримтлагдах эвдрэлийн хуримтлалыг 42-р зурагт үзүүлэв. Эндээс дүгнэхэд тэнхлэгийн ачаалал 12тонн байх тохиолдолд замын ашиглалтын 6,8жилийн дараа эвдрэлийн хуримтлал  $D=1$  болж, замын бат бэхийн нөөц дуусч байна.

36-р зураг: Гэмтэл хуримтлал /2/




25-р хүснэгт: Тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирлын тооцоо /2/


Тооцоо 2						
160МПа бат бэхийн нөөцтэй автозамд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирол						
Тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн хувь	%	0%	2%	10%	20%	50%
Тэнхлэгийн ачаалал,	тонн	10	10.2	11	12	15
Тооцоот ашиглалтын хугацаа	жилээр	15 жил				
Ашиглалтын бодит хугацаа	жилээр	15	14.2	10.8	6.8	3
Ашиглалтын хугацааны богиносолт	%	0	0.8	4.2	8.2	12
Анхний хөрөнгө оруулалт	төг	600,000,000				
Их засварын давтамж		1	1			
Их засварын хөрөнгө оруулалт	төг	200,000,000	200,000,000			
Шинэчлэлтийн ажлын давтамж				1	2.2	5.0
Шинэчлэлтийн ажлын хөрөнгө оруулалт	төг			800,000,000	1,764,705,882	4,000,000,000
Тэнхлэгийн ачаалал хэтрэлттэй тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалт үүсэх нөлөөг мөнгөн дүнгээр илэрхийлбэл:						
1км замд үзүүлэх хохирол	төг	5,603	5,603	9,806	16,563	32,220
10км замд үзүүлэх хохирол	төг	56,035	56,035	98,061	165,633	322,201
100км замд үзүүлэх хохирол	төг	560,350	560,350	980,612	1,656,328	3,222,011

Замын байгууламж 160МПа уян харимхайн модультай байх тохиолдолд 2-50% хүртэл тэнхлэгийн ачаалал хэтрэлттэй нэг тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалтаас үүсэх хохирлыг тооцвол 1км замд 5,603 -32,220 төгрөгийн хохирол, 100км замд 560,350 - 3,222,011 төгрөгийн хохирол гарч байна.

37-р зураг: Тооцоот ачааллын давтамж ба ашиглалтын хугацааны хамаарал /3/



38-р зураг: Гэмтэл хуримтлал /3/



Тэнхлэгийн ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг стандарт ачаалалд шилжүүлэн тооцвол тооцоот ачааллын давтамж замын ашиглалтын хугацаанд өөрчлөх явцыг 43-р зурагт үзүүллээ.

Ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс E=180МПа бат бэхтэй замд хуримтлагдах эвдрэлийн хуримтлалыг 44-р зурагт үзүүлэв. Эндээс дүгнэхэд тэнхлэгийн ачаалал 12тонн байх тохиолдолд замын ашиглалтын 6,8жилийн дараа эвдрэлийн хуримтлал D=1 болж, замын бат бэхийн нөөц дуусч байна.

26-р хүснэгт: Тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирлын тооцоо /3/

Тооцоо 3						
180МПа бат бэхийн нөөцтэй автозамд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирол						
Тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн хувь	%	0%	2%	10%	20%	50%
Тэнхлэгийн ачаалал,	тонн	10	10.2	11	12	15
Тооцоот ашиглалтын хугацаа	жилээр	15 жил				
Ашиглалтын бодит хугацаа	жилээр	15	14.2	10.8	6.8	3
Ашиглалтын хугацааны богиносолт	жилээр	0	0.8	4.2	8.2	12
	%	0%	5%	28%	55%	80%
Анхний хөрөнгө оруулалт	төг	700,000,000				
Их засварын давтамж		1	1			
Их засварын хөрөнгө оруулалт	төг	200,000,000	200,000,000			
Шинэчлэлтийн ажлын давтамж				1	2.2	5.0
Шинэчлэлтийн ажлын хөрөнгө оруулалт	төг			800,000,000	1,764,705,882	4,000,000,000
Тэнхлэгийн ачаалал хэтрэлттэй тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалт үүсэх нөлөөг мөнгөн дүнгээр илэрхийлбэл:						
1км замд үзүүлэх хохирол	төг	6,304	6,304	10,507	17,264	32,921
10км замд үзүүлэх хохирол	төг	63,039	63,039	105,066	172,637	329,205
100км замд үзүүлэх хохирол	төг	630,393	630,393	1,050,656	1,726,371	3,292,054


26-р хүснэгтэд 180МПа уян харимхайн модультай замын байгууламжинд тэнхлэгийн ачаалал 2-50% хүртэл хэтрэлттэй нэг тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалтаас үүсэх хохирлыг тооцож үзүүлэв.



Тооцооны үр дүнгээс дүгнэхэд тэнхлэгийн ачаалал хэтрэлт нь 1км замд 6,604 -32,921 төгрөгийн хохирол болж байгаа бол 100км замд 630,393 - 3,292,054 төгрөг болж байна.


Тооцооны 4-р хувилбар болох 200мПа уян харимхайн модультай авто замд тэнхлэгийн ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний учрах нөлөөг тооцож үзье. 39-р зурагт ачаалал хэтэрсэн тэнхлэгийн үйлчлэлийг стандарт ачаалалд шилжүүлэн замын ашиглалтын хугацаанд тооцоот ачааллын давтамж хэрхэн өөрчлөгдөхийг үзүүлээ.

39-р зураг: Тооцоот ачааллын давтамж ба ашиглалтын хугацааны хамаарал /4/



Ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс E=200мПа бат бэхтэй замд хуримтлагдах эвдрэлийн хуримтлалыг 40-р зурагт үзүүлэв. Эндээс дүгнэхэд тэнхлэгийн ачаалал 12тонн байх тохиолдолд замын ашиглалтын 7,8жилийн дараа эвдрэлийн хуримтлал D=1 болж, замын бат бэхийн нөөц дуусч байна.

40-р зураг: Гэмтэл хуримтлал /4/



28-р хүснэгт: Тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирлын тооцоо /4/

Тооцоо 4						
200МПа бат бэхийн нөөцтэй автозамд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирол						
Тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн хувь	%	0%	2%	10%	20%	50%
Тэнхлэгийн ачаалал,	тонн	10	10.2	11	12	15
Тооцоот ашиглалтын хугацаа	жилээр	15 жил				
Ашиглалтын бодит хугацаа	жилээр	15	14.2	10.8	6.8	3
Ашиглалтын хугацааны богиносолт	жилээр	0	0.8	4.2	8.2	12
	%	0%	5%	28%	55%	80%
Анхний хөрөнгө оруулалт	төг	800,000,000				
Их засварын давтамж		1	1			
Их засварын хөрөнгө оруулалт	төг	200,000,000	200,000,000			
Шинэчлэлтийн ажлын давтамж				1	2.2	5.0
Шинэчлэлтийн ажлын хөрөнгө оруулалт	төг			800,000,000	1,764,705,882	4,000,000,000
Тэнхлэгийн ачаалал хэтрэлттэй тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалт үүсэх нөлөөг мөнгөн дүнгээр илэрхийлбэл:						
1км замд үзүүлэх хохирол	төг	7,004	7,004	11,207	17,964	33,621
10км замд үзүүлэх хохирол	төг	70,044	70,044	112,070	179,642	336,210
100км замд үзүүлэх хохирол	төг	700,437	700,437	1,120,699	1,796,415	3,362,098

Дээрх тооцооны үр дүнгээс дүгнэхэд тэнхлэгийн ачаалал хэтрэлттэй нэг тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалтаас 1км замд 9,106 -33,621 төгрөгийн хохирол учирч байгаа бол 100км замд 910,568 - 3,362,098 төгрөгийн хохирол учирч байна.

### 3.2 АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛАЛ ХЭТЭРСНЭЭС УЛСЫН ЧАНАРТАЙ ЗАРИМ ЗАМУУДАД УЧРАХ ХОХИРЛЫН ТООЦОО

Улсын чанартай авто замуудын ачаа тээвэрлэлтэнд дүн шинжилгээ хийхэд дараах авто замууд нь ачаа тээвэрлэлтийн үндсэн коридор болж байна гэж дүгнэлээ.

1. УБ - Чойр-Замын Үүд чиглэлийн авто замууд;
2. УБ – Дархан – Алтанбулаг чиглэлийн авто зам;
3. УБ – Арвайхээр – Баянхонгор чиглэлийн авто зам;
4. УБ – Мандалговь чиглэлийн авто зам;
5. УБ – Чойбалсан – Баруун –Урт чиглэлийн авто зам;

Ачаа тээвэрлэлтийн үндсэн коридороос А0101 Налайх - Чойр, А0102 Чойр – Сайншанд, А0301 УБ – Арвайхээр, А0302 Арвайхээр – Баянхонгор чиглэлийн авто замуудыг сонгон авч, талбайн хэмжилт, туршилт ажил гүйцэтгэлээ.

Талбайн хэмжилтээр авто замын далан, суурийн даацын чадвар, замын байгууламжийн харимхай хотойлтыг сонгосон онцлог цэгүүдэд хэмжиж, далангаас шорооны дээж авч зэрэг ажил гүйцэтгэлээ.

Талбайн хэмжилтэнд Бенкельманы багажаар замын байгууламжийн харимхай хотойлтыг хэмжив. Хэмжилтийн явцыг доорх зургаар үзүүлэв.




УБ-Чойр чиглэлийн авто замд хэмжилтийн автомашины ачааллыг хэмжиж байгаа нь



Авто замд бенкелманы багажаар хotoйлт хэмжиж байгаа нь



Авто замд бенкелманы багажаар хotoйлт хэмжиж байгаа нь



Арвайхээр – Баянхонгор чиглэлийн авто замд хэмжилтийн автомашины ачааллыг хэмжиж байгаа нь



Тухайн сонгосон цэгүүд дээр хотойлтын хэмжилтээс гадна далан, суурийн ачаа даацын чадварыг DCP багажаар хэмжлээ. Хэмжилтийн явцыг фото зургаар үзүүлээ.



Арвайхээр – Баянхонгор чиглэлийн авто замд DCP багажаар хэмжиж байгаа нь



УБ-Чойр чиглэлийн авто замд DCP багажаар хэмжиж байгаа нь

Хэмжилтийн ажлын үр дүнд боловсруулалт хийн доорх хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

A0302 Арвайхээр -Баянхонгор чиглэлийн авто замын бат бөхийн хэмжилтийн үзүүлэлт

Байрлал, км	Хотойлтын дундаж утга, мм	Бодит уян харимхайн модуль, МПа
27.0	0.64	226.6
31.0	0.603	240.3
41.0	0.72	201.4
44.0	0.607	239.01
Дундаж утга	0.643	226.8
Хамгийн бага утга		201.4
Хамгийн их утга		240.3

A0101 Налайх - Чойр чиглэлийн авто замын бат бөхийн хэмжилтийн үзүүлэлт

Байрлал, км	Хотойлтын дундаж утга, мм	Бодит уян харимхайн модуль, МПа
122.2	0.41	244.1
137.7	0.41	244.2
187.8	0.459	219.77
190.5	0.642	156.98
191.5	0.751	134.21
221.0	0.499	202.09
Дундаж утга	0.529	200.2
Хамгийн бага утга		134.2
Хамгийн их утга		244.2


A0102 Чойр - Сайншанд чиглэлийн авто замын бат бөхийн хэмжилтийн үзүүлэлт

Байрлал, км	Хотойлтын дундаж утга, мм	Бодит уян харимхайн модуль, МПа
245.5	0.35	288.0
246.2	0.370	272.4
248.0	0.32	315.0
Дундаж утга	0.347	291.8
Хамгийн бага утга		272.4
Хамгийн их утга		315.0


Дээрх бодит үр дүнд үндэслэн ийм бат бөхийн үзүүлэлттэй авто замуудад тэнхлэгийн ачаалал нь зөвшөөрөгдөх үзүүлэлтээс хэтэрсэн тээврийн хэрэгсэл зорчсоноор авто замын ашиглалтын хугацааны богиносголтыг тооцон доорх графикаар үзүүллээ.



41-р зураг.. A0101 Налайх – Чойр чиглэлийн авто замын ашиглалтын хугацааны богиносолт



42-р зураг. A0302 Арвайхээр – Баянхонгор чиглэлийн авто замын ашиглалтын хугацааны богиносолт



43-р зураг. А0102 Чойр – Сайншанд чиглэлийн авто замын ашиглалтын хугацааны богиносолт

Авто замын ашиглалтын хугацаа богиноссоноор замд хийгдэх засвар, шинэчлэлтийн төрөл, давтамжийг тооцон авто замуудад тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн хувь 2, 10, 20% болоход замын ашиглалтын хэвийн нөхцөлийг хангахад шаардагдан гаргах зардлыг тодорхойллоо. Үүнд үндэслэн тэнхлэгийн ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалтаар авто замд үүсэх хохирлын үзүүлэлтийг мөнгөн дүнгээр илэрхийлэн гаргалаа. Тооцоонд засвар, шинэчлэлтийн ажлын тоо хэмжээг томсгосон үзүүлэлтээр, мөн төсөвт өртөгийг томсгосон хэлбэрээр тооцлоо.

Доорх хүснэгтүүдэд талбайн хэмжилт явуулсан ачаа тээврийн 2 коридорын хувьд тэнхлэгийн ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалтаар авто замд үүсэх хохирлын үзүүлэлтийг мөнгөн дүнгээр үзүүлэв.

**200.2 МПа -тай автозамд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирлын хэмжээ**

Тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн хувь	%	0%	2%	10%	20%
Тэнхлэгийн ачаалал	тонн	10	10.2	11	12
Тооцоот ашиглалтын хугацаа	жилээр	15 жил			
Ашиглалтын бодит хугацаа	жилээр	15	14.4	11.2	8.1
Ашиглалтын хугацааны богиносолт	жилээр	0	0.6	3.8	6.9
	%	0%	4%	25%	46%
<b>Авто замын хөрөнгө оруулалтын хэрэгцээг тооцвол:</b>					
Анхний хөрөнгө оруулалт	төг	800,000,000			
Их засварын давтамж		1	1		
Их засварын хөрөнгө оруулалт	төг	200,000,000	200,000,000		
Шинэчлэлтийн ажлын давтамж				1	1.9
Шинэчлэлтийн ажлын хөрөнгө оруулалт	төг			800,000,000	1,481,481,481
<b>Тэнхлэгийн ачаалал хэтрэлтгүй тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалт үүсэх нөлөөг мөнгөн дүнгээр илэрхийлбэл:</b>					
1км замд үзүүлэх хохирол	төг	7,004	7,004	11,207	15,980
10км замд үзүүлэх хохирол	төг	70,044	70,044	112,070	159,803
100км замд үзүүлэх хохирол	төг	700,437	700,437	1,120,699	1,598,034

**226.8 МПа -тай автозамд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирлын хэмжээ**

Тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн хувь	%	0%	2%	10%	20%
Тэнхлэгийн ачаалал	тонн	10	10.2	11	12
Тооцоот ашиглалтын хугацаа	жилээр	15 жил			
Ашиглалтын бодит хугацаа	жилээр	15	14.7	11.5	8.4
Ашиглалтын хугацааны богиносолт	жилээр	0	0.3	3.5	6.6
	%	0%	2%	23%	44%
<b>Авто замын хөрөнгө оруулалтын хэрэгцээг тооцвол:</b>					
Анхний хөрөнгө оруулалт	төг	900,000,000			
Их засварын давтамж		1	1	1	
Их засварын хөрөнгө оруулалт	төг	200,000,000	200,000,000	400,000,000	
Шинэчлэлтийн ажлын давтамж					1.8
Шинэчлэлтийн ажлын хөрөнгө оруулалт	төг				1,428,571,429
<b>Тэнхлэгийн ачаалал хэтрэлттэй тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалт үүсэх нөлөөг мөнгөн дүнгээр илэрхийлбэл:</b>					
1км замд үзүүлэх хохирол	төг	7,705	7,705	9,106	16,310
10км замд үзүүлэх хохирол	төг	77,048	77,048	91,057	163,102
100км замд үзүүлэх хохирол	төг	770,481	770,481	910,568	1,631,018

Тооцооноос дүгнэхэд авто замуудад тэнхлэгийн зөвшөөрөгдөх ачааллаас 10%-иас хэтрүүлэх нь замын ашиглалтын үеийн зардлыг нэмэгдүүлж байна. Мөн тээврийн хэрэгслийн аяллын урт эсвэл авто замын уртаас хамааран нэг тээврийн хэрэгслийн явалтын нөлөөгөөр замд үзүүлэх хохирол 100км замд 1.5 – 1.7 тэрбум төгрөг болж байна.

2021 оны 11-р сарын хэлэлцүүлгээр гаргасан санал зөвлөмжийн хүрээнд Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замд дээрх аргачлалаар тэнхлэгийн ачаалал хэтрэлтээс үүсэх хохирол, нөлөөг тооцож тайланд орууллаа.

Мандалговь – Даланзадгад чиглэлийн авто замд хийсэн талбайн хэмжилтийн үр дүнд үндэслэн тус чиглэлийн авто замын бат бэхийн үзүүлэлт тооцож, түүнд тэнхлэгийн даац хэтрэлтээс учруулах хохирлыг тодорхойл боллоо.


2021 онд “ЛАБО” ХХК-ны хийсэн хэмжилтийн үр дүнгээр замын нийт уян харимхайн модулийг тодорхойлоход 140-115мПА хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд нийт 95000 – 53000 стандарт ачааллын нөөц бат бэхтэй байна.

МАНАС		Мандалговь аймгийн - Даланзадгад аймаг хүртэлх хатуу хучилттай авто зам						LABO ЗАМ БАРИЛТЫН ЗӨВЛӨХ КОМПАНИ	
км	Хотойлт		км	Хотойлт		км	Хотойлт		
	Баруун	Зүүн		Баруун	Зүүн		Баруун	Зүүн	
14+000	-0.12	-0.11	15+000	-0.16	-0.14	16+000	-0.16	-0.17	
	-0.12	-0.15		-0.14	-0.15		-0.15	-0.15	
	-0.11	-0.12		-0.15	-0.18		0	-0.2	
	-0.12	-0.11		-0.18	-0.18		-0.2	-0.13	
Дундаж	-0.14	-0.11	Дундаж	-0.17	-0.15	Дундаж	-0.18	-0.11	
Дундаж	-0.12	-0.12	Дундаж	-0.16	-0.16	Дундаж	-0.14	-0.15	
км	Хотойлт		км	Хотойлт		км	Хотойлт		
	Баруун	Зүүн		Баруун	Зүүн		Баруун	Зүүн	
17+000	-0.14	-0.13	18+00	-0.14	-0.15	19+00	-0.13	-0.12	
	-0.12	-0.14		-0.16	-0.16		-0.16	-0.14	
	-0.15	-0.15		-0.18	0		-0.15	-0.21	
	-0.14	-0.13		-0.21	-0.24		-0.17	-0.18	
Дундаж	-0.11	-0.12	Дундаж	-0.18	-0.13	Дундаж	-0.16	-0.19	
Дундаж	-0.13	-0.13	Дундаж	-0.17	-0.14	Дундаж	-0.15	-0.17	



ХЯНАЛТ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ			
Ид	Байршил [км]	Фото зураг	Тайлбар:
1	14+000		Авто замын эгнээнд хөтөйлт тодорхойлох
2	14+000		Авто замын эгнээнд хөтөйлт тодорхойлох
3	15+000		Авто замын эгнээнд хөтөйлт тодорхойлох

Тэнхлэгийн ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд оролцсоноор түүний ашиглалтын хугацаа, их засварын хоорондын хугацаа богиносолтыг тооцож дараах хүснэгтэд үзүүлэв.



Тооцооноос үр дүнгээс дүгнэхэд Мандалговь – Даланзадгад чиглэлийн авто замаар жилд 10 мян. тооцоот ачаалал үйлчилнэ гэж үзвэл өнөөгийн байдлаар уг замын ашиглалтын хугацаа нь 5 жил орчим байна.

Тэгвэл тэнхлэгийн ачаалал хэтэрсэн хөдөлгөөн явагдснаар тухайн замын ашиглалтын хугацаа хоёр дахин богиносох буюу 2,6 жил болж буурахаар байна.

**115.6 МПа -тай автозамд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтэрснээс үүсэх хохирлын хэмжээ**

Тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн хувь	%	0%	2%	10%	20%
Тэнхлэгийн ачаалал,	тонн	10	10.2	11	12
Тооцоот ашиглалтын хугацаа	жилээр	5 жил			
Ашиглалтын бодит хугацаа	жилээр	5	4.8	3.7	2.6
Ашиглалтын хугацааны богиносолт	жилээр	10	0.2	1.3	2.4
	%	0%	4%	26%	48%
<b>Авто замын хөрөнгө оруулалтын хэрэгцээг тооцвол:</b>					
Анхний хөрөнгө оруулалт	төг	1,100,000,000			
Их засварын давтамж		1	1	1	
Их засварын хөрөнгө оруулалт	төг	200,000,000	200,000,000		
Шинэчлэлтийн ажлын давтамж					1.9
Шинэчлэлтийн ажлын хөрөнгө оруулалт	төг			769,230,769	1,538,461,538
<b>Тэнхлэгийн ачаалал хэтрэлтэй тээврийн хэрэгслийн нэг удаагийн явалт үүсэх нөлөөг мөнгөн дүнгээр илэрхийлбэл:</b>					
1км замд үзүүлэх хохирол	төг	13,684	13,684	13,093	27,773
10км замд үзүүлэх хохирол	төг	136,842	136,842	130,928	277,733
100км замд үзүүлэх хохирол	төг	1,368,421	1,368,421	1,309,279	2,777,328

Энэ замд тэнхлэгийн ачаалал хэтрэлт 10%-иар нэмэгдэхэд ашиглалтын хугацаа 3,7 жил болж багасах ба ийм ачаалал тухайн замын 1км уртад 13мян.төг, 10км урт хэсэгт 130мян. төг, 100км урттай хэсэгт 1.3сая төгрөгийн хохирол тус тус учруулахаар байна.

**ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ**

1. Даац хэтэрсэн тээвэрлэлтийг бууруулах үйл ажиллагааг “Авто замын тухай” хууль, “Авто тээврийн тухай” хууль, “Зөрчлийн тухай” хууль, “Эрүүгийн тухай” хуулиудад тусгасан байна. Эдгээр хуулиудад авто замын хохирлыг нөхөн төлүүлэхээр заасан боловч хохирлын хэмжээг тодорхойлох, нөхөн төлбөрийг ямар санд хуримтуулах, замын гэмтэл эвдрэлийг засаж сайжруулах ажлыг санхүүжүүлэх зэрэг ажлыг хариуцан хэрэгжүүлэх хуулийн эдгээдийг тодорхой заагаагүй байна. Үүний улмаас тэнхлэгийн ачаалал хэтрэлтээс үүссэн замын эвдрэлийг хариуцах, хянах, хохирлыг тодорхойлох, нөхөн төлбөр авах, хохирлыг арилгах үйл ажиллагаа орхигдож байна. Иймд тэнхлэгийн ачааллыг хянах үйл явц, дүрэм журам, торгуулийн талаарх тодорхойгүй байгаа энэ асуудалд шинжлэх ухаан, нотлох баримтын үндэслэлтэй хандах нь чухал байна.
2. Судалгаанаас дүгнэхэд хөрсний уян харимхайн модуль улирлын хөлдөлт, гэсэлт, чийгийн агууламжаас хамааран эрс өөрчлөгдөж байна. Хөрсний уян харимхайн модуль хаврын гэсэлтийн үед 3-р сарын сүүлчээс 5-р сарын 20 хүртэл (зам-уур амьсгалын бүсчлэлээр эхлэл, төгсгөлийн хугацаа урагш, хойш болно.) хугацаанд 10 дахин буурч байдаг. Иймд энэ хугацаанд хүнд даац тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хязгаарласнаар автозамд учруулах ноцтой эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлж чадах юм. Өвлийн улиралд хөрс хөлдөхөд хөрсний уян харимхайн модуль 11-р сарын эхээс 3-р сарын 10 хүртэл хугацаанд 20 дахин нэмэгдэж, ачаалал хүлээн авах чадвар нь эрс нэмэгддэг байна. Энэ хугацаанд хүнд даац тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэхэд замд ачааллын нөлөөгөөр үүсэх эвдрэл маш бага байх болно. Иймээс хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаврын улиралд хөрс гэсэлтийн цаг үеэр хязгаарлах;

Хөрс хөлдөж, ачаалал даах чадвар эрс нэмэгдсэн цаг үеэр буюу өвлийн улиралд хүнд даацын тээврийн хөдөлгөөнийг эрчимтэй явуулахаар ачаа бараа тээвэрлэлтийг зохион байгуулах, төлөвлөх;

3. Хөдөлгөөний эрчмийн тооллогын дүн, ангиллын тоо, хөдөлгөөн үүсэх, шингэх цэгийн судалгаа, тээврийн хэрэгслийн ашиглалтын мэдээлэл зэрэг үнэт бодит мэдээллийг цуглуулж, даац хэтрэлт үүсч буй цэгүүдийг тогтоох ажлыг тогтмол хугацаанд хийж байх шаардлагатай байна. Тэнхлэгийн ачаалал хянах камер бусад технологийн тоног

төхөөрөмжийг ашиглан хөдөлгөөний эрчмийн мэдээллийг цуглуулж, бодит цаг хугацаанд тулгуурлаж боловсруулсан мэдээлэлтэй байх нь илүү үр дүнтэй юм.

Төслийн хүрээнд ажлын даалгаврын дагуу дараах чиглэлээр судалгаа, шинжилгээ, туршилт, хэмжилтийн ажил гүйцэтгэж, санал зөвлөмж, заавар, аргачлал зэргийг боловсрууллаа.

4. Төслийн ажлын хүрээнд авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллын хяналтын чиглэлээр бодлогын түвшинд, удирдлага, зохион байгуулалтын түвшинд, хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны түвшин тус бүрд зөвлөмжүүд боловсруулав.
5. Даац хэтэрсэн тээвэрлэлтийг бууруулах үйл ажиллагааг зохицуулж буй “Авто замын тухай” хууль, “Авто тээврийн тухай” хууль, “Зөрчлийн тухай” хууль, “Эрүүгийн тухай” хуулиудын заалтуудад дүн шинжилгээ хийж, зохих хуулиудад нэмэлт өөрчлөлт хийх саналыг боловсруулав.
6. Авто замын асуудал хариуцдаг төрийн байгууллагаар батлах журамд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн ачаалалтай тээврийн хэрэгслийн авто замд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохыг санал боловсруулав.
7. ЗТХЯ-аас 2021 онд боловсруулсан “Авто замаар овор ихтэй, урт, ачаа тээвэрлэх зөвшөөрөл олгох журам”-ын төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулав..
8. Тэнхлэгийн ачааллыг хянах стратегийн шинэ байршлуудын хувилбарыг боловсруулав. Дээрхи 7-р хүснэгтэнд харуулсны дагуу Алтанбулаг боомт, Цагааннуур боомт, Дархан хот, Баруун турууны ТАЦ, Өлгийн ТАЦ, Бичигтийн боомт, Ховдын Манхан сумын ТАЦ, Эрдэнэтын ТАЦ зэрэг байршилд автопүүг шинээр бий болгох нь зүйтэй.
9. Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллын хяналтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх хоёр заавар боловсрууллаа. (Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг талбай дээр хэмжих, дүн шинжилгээ хийх заавар; Авто замын уян харимхайн модуль тодорхойлох заавар; )
10. Авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтээс авто замд учруулах хохирол тооцох тооцооны хоёр аргачлал боловсруулан санал болгож байна. Үүнд: Авто замд учруулах хохирлыг тээвэр ашиглалтын зардал, зам хэрэглэгчийн зардлын өсөлтөөр тооцох аргачлал; Авто замын ашиглалтын хугацаанд тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтрэлтийн нөлөөг тооцох аргачлал; )
11. Ачаа тээвэрлэлтийн үндсэн коридор болох улсын чанартай 3 авто замд /2 чиглэлд/ талбайн хэмжилт, туршилт явуулж, бодит үр дүнд үндэслэн тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал хэтэрснээс авто замд учрах хохирлыг тооцоог хийлээ.
12. Авто тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг хянах, тооцох, үнэлэх чиглэлээр боловсруулсан аргачлал, зааварт түшиглэн сургалтын материал бэлтгэв /Хавсралт 2-д оруулсан/.
13. ЗТХЯ болон АГҮТ-өөс боловсруулсан журмын төсөлд өгөх саналаа Хавсралт 3-д харуулав. Уг журмын төслийг хангалтгүй боловсруулагдсан гэж дүгнэж байна. Ялангуяа тээврийн хэрэгслийн бүх жин, тэнхлэгийн ачаалалд тавигдах заалтыг ОХУ, БНХАУ болон АНУ-ын журмуудад заасантай адил байхаар зааж өгөх, мөн бусад заалтуудыг харьцуулан авто замын байгууламжинд хохирол учруулахгүй байх нөхцөлийг хангаж байхаар боловсруулах шаардлагатай байна.
14. Журмын төсөл нь нилээд хагас дутуу, учир дутагдалтай боловсруулагдсан байна. Иймд ОХУ-ын 2019 онд боловсруулан баталсан “Порядка выдачи специального разрешения на движение по автомобильным дорогам тяжеловесного и (или) крупногабаритного транспортного средства” Монголд нутагшуулахыг зөвлөж байна. Энэ журамд ачаалал хэтэрсэн тээврийн хэрэгслийн тээвэрлэлтэд тусгай зөвшөөрөл өгөх удирдлага, зохион байгуулалт, хяналтын цогц үйл ажиллагааг шат шатанд нь нэг бүрчлэн тодорхой заасан

байна. Тус журмыг орчуулан Монголын нөхцөлд тохируулах хэрэглэх санал боловсруулан Хавсралт 8-д харуулав.

15. Автотээврийн хэрэгсэл (автомашин)-ийн төрөл, хамгийн их массын тухай стандартын (MNS 4598 стандартын) тайлбарыг зургаар харуулан Хавсралт 7-д харуулав.

**БОЛОВСРУУЛСАН :**

Зөвлөх инженер, Доктор (PhD)

Ж.БАТСАЙХАН

Профессор, Доктор (Dr.Sc)



Д.ГОТОВ

Зөвлөх инженер, Доктор (PhD)

Р.БОЛОРМАА

Дэд профессор, Доктор (PhD)

И.БАЗАРРАГЧАА



## ХАВСРАЛТ 1. СТАТИК АРГААР ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛАЛ ХЭМЖИХ ЗААВАР



### СТАТИК АРГААР ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЭНХЛЭГИЙН АЧААЛАЛ ХЭМЖИХ ЗААВАР

Хэмжилтийн аргачлал

УБ хот, 2021 он

1. Хэмжилтийн аргын нарийвчлалын үзүүлэлт

1.1 Тэнхлэгийн ачааллыг зөөврийн электрон тусгай зориулалтын жингээр хэмжилтийн шууд аргаар хэмжинэ. Тэнхлэгийн ачааллын хэмжилтийн үр дүнгийн алдааг багажны буюу жингийн алдаагаар тодорхойлох бөгөөд 5 тонн хүртэл үзүүлэлтэнд  $\pm 10\text{кг}$ , 20кг хүртэл үзүүлэлтэнд  $\pm 20\text{кг}$ -аас хэтрэхгүй байна.

1.2 Тухайн аргачлалын нийлбэр алдаа нь  $W_{\Sigma} = \pm 2\%$  байна. Нийлбэр алдаанд дараах хүчин зүйлсийн нөлөөлнө. Үүнд:

- Тээврийн хэрэгсэлд ачсан ачааны байрлал, хүндийн төвийн байрлал;
- Зөөврийн пүү байрлуулсан замын гадаргуун талбайн жигд хэвтээ байдалтай эсэх;
- Автопүүгийн хэмжилтийн алдаа;
- Тээврийн хэрэгслийн тэнхлэг дээр ачаа жигд хуваарилагдсан эсэх;

2. Хэмжилтийн хэрэгсэл

2.1 Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг статик аргачлалаар хэмждэг зөөврийн, электрон автопүүний зарим нэг төрлийг жишээ болгон дор үзүүлэв.

- 1) “BA-II” төрлийн “BA-20II” маркийн зөөврийн автопүү
- 2) INST01-80t 4 PAD төрлийн зөөврийн автопүү
- 3) “AXHD-12” маркийн зөөврийн автопүү

Эдгээр зөөврийн автопүүнүүдийн ажиллах зарим ижил бөгөөд дохиолол хүлээн авч боловсруулах компьютер нь утсан болон утасгүй холбоотой гэсэн хоёр төрөл байна.

2.2 Зөөврийн “BA-II” автопүү /электрон жин/ нь ачаалал хэмжигч хоёр хавтан, тээврийн хэрэгсэл гарч зогсох зориулалтын 2-6 ширхэг резинэн хавтан (гурваас зургаан тэнхлэг бүхий тээврийн хэрэгслийн тэнхлэг тус бүрийг хэмжихэд), автопүү рүү гарах болон буухад зориулсан налуу гадаргуутай хоёр резинэн хавтан, зориулалтын программ хангамж бүхий компьютер зэрэг эд ангиас бүрдэнэ.

Ачаалал хэмжигч хавтан нь M22 төрлийн жин хэмждэг 6 ширхэг мэдрэгчүүд дээр тулж байрласан бөгөөд эдгээр мэдрэгчүүд ачааллыг цахилгаан дохио болгон хувиргаж, жингийн хэмжилтийн нэгжид шилжүүлж, үр дүнг илэрхийлдэг.

“BA-II” төрлийн автопүүгийн техникийн үндсэн үзүүлэлтийг 1-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. “BA-II” төрлийн автопүүгийн техникийн үндсэн үзүүлэлт

Техникийн үндсэн үзүүлэлт	Үзүүлэлтийн утга
Хэмжилтийн нарийвчлалын ангилал /ГОСТ Р 53228-2008/	Дунд (III)
Хэмжих хамгийн их ачаа, кг	20000
Хэмжих хамгийн бага ачаа, кг	200
Дискретность отсчета, кг	10
Жингийн тоо, ширхэг	2



Зураг 1. “BA-20П” төрлийн автопүү

2.3 Зөөврийн INST01-80t 4 PAD төрлийн автопүүгийн техникийн үндсэн үзүүлэлтийг 2-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. “INST01-80t 4 PAD” төрлийн автопүүгийн техникийн үндсэн үзүүлэлт

Техникийн үндсэн үзүүлэлт	Үзүүлэлтийн утга
Хэмжилтийн нарийвчлалын ангилал /ГОСТ Р 53228-2008/	Статик жингийн 0,3%-ийн нарийвчлал
Хэмжих хамгийн их ачаа, кг	80000
Хэмжих хамгийн бага ачаа, кг	200
Дискретность отсчета, кг	1,0
Жингийн тоо, ширхэг	4
Дэлгэц	LCD дэлгэц





Зураг 2. “INST01-80t 4 PAD” төрлийн зөөврийн автопүү

“AXHD-12” маркийн автопүүгийн техникийн үндсэн үзүүлэлтийг 3-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. “AXHD-12” маркийн автопүүгийн техникийн үндсэн үзүүлэлт

Техникийн үндсэн үзүүлэлт	Үзүүлэлтийн утга
Хэмжилтийн нарийвчлалын ангилал	Статик байдлаар жинлэхэд 0,3%-ийн нарийвчлал
	Динамик байдлаар жинлэхэд 3% (5~10км/ц)
Хэмжих хамгийн их ачаа, кг	40000
Хэмжих хамгийн бага ачаа, кг	200
Дискретность отсчета, кг	1,0
Жингийн тоо, ширхэг	2
Дэлгэц	LCD дэлгэц



Зураг 3. “AXHD-12” маркийн автопүү

2.4 Зөөврийн электрон автопүүг 0,1-0,15мм/м-ээс ихгүй налуутай хавтгай гадаргууд байрлуулна.

### 3. Хэмжих арга

3.1 Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллыг “ВА-П” төрлийн зөөврийн электрон автопүүгээр тэнхлэг бүрээр нь статик аргаар шууд хэмжиж тодорхойлно.

3.2 Тээврийн хэрэгслийн нийт жинг болон хосолсон, гурвалсан болон бусад хэлбэрээр бүлэглэсэн тэнхлэгийн ачааллыг бүх тэнхлэгийн ачааллын нийлбэрээр тодорхойлно. Үүнд:

$$A_i$$

$$\text{Жинтх} = \sum$$

Үүнд,  $i$  - тээврийн хэрэгслийн тэнхлэгийн тоо;

$A_i$  – тээврийн хэрэгслийн  $i$  дугаар тэнхлэгийн ачаалал, кг;

### 4. Аюулгүй ажиллагааны шаардлага

4.1 Хэмжилтийн ажлыг гүйцэтгэхдээ автопүүгийн болон тээврийн хэрэгслийн техникийн паспортонд заасан ашиглалтын аюулгүй ажиллагааны шаардлагыг баримтална.

4.2 Зөөврийн автопүүг ажиллуулах, зөөвөрлөх ажлыг тухайн багаж хэрэгслийг ажиллуулах аргачлалын мэдлэг эзэмшсэн ажилтан гүйцэтгэнэ.

- 4.3 Автопүүгээр хэмжилт хийх үед аюул, осол гарахад нөлөөлөх хүчин зүйл нь жинлэх тээврийн хэрэгсэл юм.
- 4.4 Автопүүгээр хэмжилт хийх үед аюулгүй ажиллагааг бүрдүүлэхийн тулд ажилтан хөдөлмөрийн хамгааллын болон техникийн аюулгүй ажиллагааг бүрдүүлэхийн зэрэгцээ дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - Автопүүгийн гадаргууг бохирдолгүй цэвэр байлгах, түүн дээр хэмжилтэнд саад учруулах ямар нэг эд зүйл байрлуулахгүй байх;
  - Осол гэмтэл гарсан тохиолдолд гэмтэж бэртсэн хүнд анхны тусламж үзүүлэх мэдлэг чадвартай байх;
5. Хэмжилтийн операторчинд тавигдах шаардлага
  - 5.1 Хэмжилтийн ажилд автопүү ажиллуулах мэдлэг, туршлага бүхий 18-аас дээш насны хүнийг операторчинаар ажиллуулна.
  - 5.2 Ажлын байранд хөдөлмөр хамгааллын сургалтанд хамрагдаж, ажлын байран дээр дадлага хийсэн, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөрөөр суралцан, шалгалт өгч тэнцсэн хүнийг автопүү дээр бие даан хэмжилт явуулахыг зөвшөөрнө.
6. Хэмжилт явуулах нөхцөл
  - 6.1 Хэмжилтийг агаарын хэм  $-30^{\circ}\text{C}$  -аас  $+40^{\circ}\text{C}$  байхад явуулж болно.
  - 6.2 Цахилгаан эрчим хүчний хувьд,
    - 10.8-13.2В хүчдэл бүхий аккумулятор;
    - Хэрэглэх хүчин чадал - 1 ВА-аас ихгүй;
  - 6.3 Тээврийн хэрэгслийн хувьд, техникийн үзлэгт бүрэн хамрагдсан тээврийн хэрэгслийг хэмжилтэнд оруулна.
7. Бэлтгэл ажил
  - 7.1 Зөөврийн электрон автопүүгийн хэрэглэх зааварт заасны дагуу бэлтгэл ажлыг гүйцэтгэнэ.
  - 7.2 Зөөврийн автопүүг тэгш, жигд, хэвтээ гадаргуу бүхий талбай дээр байрлуулах ба талбай нь хотойж, суудаггүй, хатуу /хөшүүн/ гадаргуутай байх ёстой. Автопүүгийн өмнөх ба хойд хэсэгт тээврийн хэрэгслийн уртаас багагүй урттай шулуун замтай байхаар автопүүг байрлуулна.
  - 7.3 Автопүү байрлуулах талбайн гадаргуун тэгш байдлыг хэмжихэд 1м-ийн урттай хөшүүн төмөр шугам хэрэглэнэ. Талбайн гадаргуун тэгш байдлын хэлбэлзэл  $\pm 2\text{мм}$ -ээс ихгүй байна. Талбайн гадаргуун жигд хэвтээ байдлыг тэгш ус бүхий 1м-ийн урттай шугамаар хэмжинэ. Талбайн гадаргуун жигд хэвтээ байдлын хэлбэлзэл  $\pm 3\text{мм/м}$ -ээс ихгүй байна.
  - 7.4 Ачаа хэмжигч хавтангуудын түвшнийг 2.5м-ээс багагүй урттай, тэгш ус бүхий шугамаар хэмжих ба хоёр хавтангийн түвшний зөрүү 3мм-ээс ихгүй байна.
  - 7.5 Автопүүний ачаа хэмжигч хавтан байрлуулах хэсгийн гадаргуу чулуу шороогүй, цэвэр байна. Тухайн хэсгийн хучилтын даац даах чадвар 150-200кг/см<sup>2</sup> буюу ойролцоогоор 15- 20 мПа-аас багагүй байна. Иймд автопүүг В20 багагүй бат бэхтэй, цутгамал бетон үе, дайрган мастик төрлийн асфальтбетон эсвэл угсармал бетон хавтан зэрэг дээр байрлуулах хэрэгтэй. Агаарын температур  $30^{\circ}\text{C}$  ба түүнээс өндөр байх үед асфальтбетон хучилттай талбайд автопүү байрлуулахыг хориглоно. Учир нь асфальтбетоны уян харимхайн модуль эрс буурдаг (асфальтбетон  $40^{\circ}\text{C}$ -аас дээш хэмтэй үед уян харимхайн модуль 5-10мПа хүртэл буурдаг) тул зөвшөөрөгдөх хэмжээнээс их хотойлт өгч, хэмжилтийн явцад багаж гэмтээх аюултай.



Зураг 4. Автопүүгийн хоёр жингийн хоорондох түвшинг шалгаж, тохируулах.

Ийм нөхцөлд хучилтын хатуу, хөшүүн чанарыг сайжруулах нэмэлт арга хэмжээ /зузаан төмөр хавтан, лист тавих гэх мэт/ авна. Энэ тохиолдолд ачаа хэмжигч хавтан бүх тулгуураараа нэгэн зэрэг тулж байх ёстой бөгөөд энэхүү зааврын 7.4-р заалтын нөхцөл шаардлагыг хангаж байх хэрэгтэй.


7.6 Автопүүг байрлуулахдаа дараах нөхцөлийг тооцно. Үүнд:

- Хэмжилтийн хавтангийн голд тээврийн хэрэгслийн дугуй таарахаар хавтангуудыг байрлуулна (Зураг 5. ). Ингэснээр хэмжилтийн үр дүнгийн хэлбэлзэл багасна .
- Хэмжилтийн хавтанг жигд бус халалт, хөрөлт явагдах газарт байрлуулахыг хориглоно.



Зураг 5. Хэмжилтийн өмнө жингийн ажиллагааг туршиж шалгах.

7.7 Автопүүний мэдээлэл хүлээн авах систем нь утсан бус системтэй тохиолдолд системийн найдвартай, хэвийн ажиллагааг хангахын тулд хавтангийн антены системийн диаграммын үндсэн лепесток-ийг компьютер бүхий операторчны зүг чиглүүлэх шаардлагатай (Зураг 6).



Зураг 6. Операторчны байрлал

- 7.8 Задгай газар дохиолол дамжуулах зай 30м хүртэл байдаг боловч найдвартай байдлыг хангахын тулд операторчин аль болох ойр байрлахыг зөвлөж байна.
- 7.9 Ачаа хэмжигч хавтан, резинэн хавтан зэргийг зохих ёсоор байрлуулж хэмжихэд бэлэн болсны дараа тээврийн хэрэгслээр хяналтын буюу туршилтын явалтыг хийнэ. Тээврийн хэрэгслийг автопүүнээс буусны дараа хэмжигч хавтан, резинэн хавтангуудад ямар нэг ан цав, суулт болон бусад төрлийн гэмтэл үүссэн эсэхийг шалгана.
- АНХААР !** Зөөврийн автопүү дээр зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тэнхлэгийн ачаалал бүхий тээврийн хэрэгсэл гаргахыг хатуу хориглоно. Учир нь хэмжилтийн тензорезисторон мэдрэгчдийг гэмтээж ажиллахгүй болгох аюултай. Мөн автопүү дээр тээврийн хэрэгсэл огцом тоормослох, босоо ачааг огцом буулгах (цохилтоор үйлчлэх) зэргийг хориглоно.
- 7.10 Автопүү ажиллуулахын өмнө асаах, программыг ажиллуулахдаа багажны хэрэглэх зааврын дагуу асааж программыг идэвхжүүлнэ.
- 7.11 Тодорхой хугацаагаар ажиллуулаагүй автопүүг ашиглахын өмнө хэмжигч хавтангийн аккумуляторыг 15 минутаас багагүй хугацаагаар цэнэглэнэ.
8. Хэмжилтийн ажил
- 8.1 Тээврийн хэрэгслийг хэмжихийн өмнө программ тэнхлэгийн тоо, хослолын төрлийг оруулна. Тээврийн хэрэгслийн эхний тэнхлэгийн дугуйг хэмжигч хавтангийн голд тааруулан байрлуулна (Зураг 7).



Зураг 7. Хэмжилтийн үед тээврийн хэрэгслийн дугуйг байрлуулах байдал

## 8.2 Тээврийн хэрэгслийг өнхрөхөөс сэргийлж өөр тэнхлэгийн дугуйн дор эвээс хийнэ




Зураг 8. Тээврийн хэрэгслийн зөөврийн автопүү дээр байрлуулсны дараа дугуйнд эвээс хийж аюулгүй байдлыг хангах.

- 8.3 Тээврийн хэрэгслийн хүч дамжуулах арааг “Нейтраль” дээр тавьж, гар тоормос татсан байна. Автопүүний хэмжилтийн тоо үзүүлэлт тогтворжсоны дараа тэнхлэгийн ачааллыг программд хадгалах команд өгнө.
- 8.4 Тээврийн хэрэгслийн бусад тэнхлэг бүрд дээрх ажиллагааг давтан гүйцэтгэнэ.
- 8.5 Хэмжилтийн явцад программд хадгалагдаж буй өгөгдлийг (тэнхлэгийн дугаар, хослол, тэдгээр тус бүрийн ачаалал зэргийг) нягтлан шалгаж байх шаардлагатай.
- 8.6 Хэмжилтийн төгсгөлд тээврийн хэрэгслийн төрөл, марк, улсын дугаар зэргийг программд шивж оруулан хадгална.
- 8.7 Хэмжилтийн мэдээллийг тодорхой давтамжтайгаар (өдөр тутамд, эсвэл долоо хоног тутамд гэх мэт) зохих албанд цахимаар дамжуулна.
- 8.8 Хоёр, гурав ба түүнээс олон хосолмол тэнхлэгтэй тээврийн хэрэгслийг хэмжихдээ автопүүг резинэн хавтангуудаар уртасган, нийт тэнхлэгийн дугуйн дор 9-р зурагт үзүүлсний дагуу байрлуулна.



Зураг 9. Резинэн хавтангаар уртасгасан автопүүгээр олон тэнхлэгт тээврийн хэрэгслийг хэмжих.

8.9 Хоёр ба түүнээс олон хосолсон тэнхлэгтэй тээврийн хэрэгслийг хэмжихдээ тэнхлэг тус бүрийн ээлж дараалан автопүү дээр байрлуулан хэмжинэ.



Зураг 10. Олон тэнхлэгт тээврийн хэрэгслийг хэмжих.

## 9. Хэмжилтийн үр дүнгийн боловсруулалт

9.1 Тээврийн хэрэгслийн бүх жин болон тэнхлэгийн ачаалал хэмжих, хэмжилтийн өгөгдлийг боловсруулах, хадгалах ажиллагааг операторчин хариуцан гүйцэтгэн. Хэмжилтийн өгөгдлийг мэдээллийн санд хадгалсаны дараа холбогдох газарт дамжуулах, тайлагнах ажлыг хийнэ.

## 10. Үр дүнг тайлагнах

10.1 Хяналтын ажлын явцад энэхүү аргачлалаар хэмжсэн мэдээлэл бүхий тайлан нь хяналтын ажлын баримт нотолгоо болно.

## 11. Хэмжилтийн үр дүнгийн нарийвчлал хийх хяналт шалгалт



- 11.1 Автопүүний электрон жинг жилд нэг удаа холбогдох дүрэм журмын дагуу хэмжил тохирлын хяналтанд өгч шалгуулна.
- 11.2 Тээврийн хэрэгслийн бүх жингийн хэмжилт үнэн зөв эсэхэд жилд нэг удаа, эсвэл хэмжилтийн үр дүнд эргэлзээ гарсан тохиолдолд хэмжилтийн үр дүнг суурин автопүүний үзүүлэлттэй харьцуулан шалгана. Харьцуулсан үр дүнгийн зөрүү  $\pm 2\%$ -иас ихгүй байна.
- 11.3 Хэмжилтийн үр дүнгийн нарийвчлал хангалтгүй байх тохиолдолд:
- Шалтгааныг тодорхой болгож зөрүүг арилгах хүртэл тухайн зөөврийн автопүүг замын хяналтанд ашиглахгүй;
  - Энэхүү зааврын 11.2-р заалтын ажиллагааг бусад хэд хэдэн суурин автопүү дээр хийж, харьцуулан, үр дүнд дүн шинжилгээ хийнэ.

<https://www.owenhodge.com.au/commercial-litigation/truck-overloading/>

Many people tend to overload their trucks in an attempt to save costs. Loading a truck beyond its capacity can have disastrous consequences. Beyond immediate dangers to safety, overloaded trucks also damage roadways by exposing them to loads beyond their design tolerances.

In Australia, the National Transport Commission proposed certain penalties whereby a truck driver and/or a truck operator may face fines and suspension of vehicle registration for overloading trucks besides national penalties including requirement to off-load excess weight, on-the-spot-fines and a Court power to remove transport companies from the industry for any persistent offence.

## Legislation Relating to Truck Overloading Offence in New South Wales (NSW)

In NSW, the main legislation regulating offences related to truck overloading is the Road Transport (General) Act 2005 (the Act). The Act provides for 3 levels of mass breaches:

**Minor Risk Breaches (less than 5%):** Any overload up to 5% over the allowable weight is categorised as a minor risk breach. An individual or a body corporate committing minor risk breach is liable to pay a maximum fine of \$1,100 and \$5,500 respectively for the first offence and a maximum fine of \$2,200 and \$11,000 respectively for a second or a subsequent offence.

**Substantial Risk Breaches (greater than 5% but less than 20%):** Overload between 5% and 20% over the allowable weight is categorised as a "substantial risk breach". An individual committing substantial risk breach is liable to pay a maximum fine of \$ 2,200 for the first offence and \$11,000 for the second or subsequent offence. Whereas, a body corporate is liable to pay a maximum fine amounting to \$4,400 and \$22,000 respectively for the first and second or a subsequent offence

**Severe Risk Breaches (20% or more):** Any overload which is 20% or more over the allowable weight is categorised as a "severe risk breach". An individual committing a severe risk breach is liable to a maximum penalty of \$5,500 plus \$550 for every additional 1% that the overload exceeds 20% of the allowable weight for the first offence and \$11,000 plus \$1,100 for every additional 1% that the overload exceeds 20% of the allowable weight for a second or subsequent offence. Whereas, for a body corporate the maximum penalty is \$27,500 plus \$2,750 for every additional 1% that the overload exceeds 20% of the allowable weight for the first offence and \$55,000 plus \$5,500 for every additional 1% that the overload exceeds 20% of the allowable weight for the second or a subsequent offence.

## Matters to be Taken into Account by the Court

According to Section 60(2) of the Act, a Court may take into consideration various matters while dealing with an offence under this Act. In determining the penalty (ies) to be imposed for breach of mass, dimension or load restraint requirements, the Court takes into account the classification of the breach and certain matters with regard to that classification such as an appreciable or substantial or severe risk of:

Accelerated road wear or

Unfair commercial advantage or

Damage to road infrastructure or

Increased traffic congestion or

Diminished public amenity or

Harm to public safety or the environment.

<https://www.solentscales.co.uk/blog/vehicle-overloading-penalties-explained-archive>

All commercial vehicles in the UK are fitted with a manufacturers plate, this clearly indicates each axle point's maximum gross weight. Exceeding any axle point's maximum weight is classed as overloading.

Overloading penalties can range in severity depending on the the excess weight of your vehicle.

If a vehicle is suspected to be overweight, the DVSA or police have full authority to pull your vehicle over and conduct their own inspection.

It's important to note that any weighings prior to the journey shall not be accepted, you must satisfy the DVSA or police officer's inspection - this shall be conducted by their own [portable axle weighing pads](#).

Firstly the vehicle is measured on it's maximum gross weight. Below are the range of fines depending on the exceeded weight:

Vehicle overweight by:	Penalty
0-9%	£100
10-14	£200
+15%	+£300
+30%	Court Summons

<https://www.weekinchina.com/2019/10/problems-with-their-weight/>

Witnesses told Caixin Weekly that a truck carrying six industrial-sized steel rolls was crossing the overpass just before it collapsed. One of the steel rolls in question weighed nearly 30,000 kilograms, the magazine said, and the six rolls would have weighed nearly 180 metric tonnes. The legal load for trucks of that size is 49 tonnes and the maximum load that section of flyover was designed for was 64 tonnes, government regulations show.

China has long struggled with the problem of overloaded trucks. Between 2006 and 2016 they were the cause of 69 bridge collapses, according to the Ministry of Transport. In 2015, prior to a nationwide crackdown, there were 750,000 traffic accidents involving the so-called "overweight killers".

Part of the problem is that up to 78% of China's freight is still transported by road. The number of trucks has dropped in recent years because older, more polluting vehicles are being phased out but the amounts of goods being carried are rising.

Fines range between Rmb200 (\$28.2) and Rmb2,000 depending on the type of road the truck is travelling on and the degree to which it is overloaded.

<https://rallystore.ru/en/rossiya-izmeneniya-v-vesovyh-nagruzkah-peregruz-avtomobilya-kontrol-za.html>

Both procedures allow you to accurately set the pressure on the axis. If it exceeds the received Russian standard, the driver discharges a fine. Fine gradation depends on whose TC and how much the weight limit is exceeded. If the norm is exceeded by 2-10%, a fine of 10,000-15 000 rubles. Receives an official, and the legal entity pays 10 times more. If the cost of cargo is exceeded by 50%, the penalty grows up to 45,000- 50,000 rubles. Official face, and legal rises to 400,000-500,000 rubles. Therefore, before deliberately violate the rules of transport, see if you benefit from this.

<https://www.air-weigh.com/the-cost-of-overweight-fines-by-state/>

<p>3</p>	<p>Таван голтой,                  А: 1-р тэнхлэг 2                  дугуйтай, 2-р тэнхлэг 4                  дугуйтай, 3-р тэнхлэг 4                  дугуйтай, 4-р тэнхлэг 4                  дугуйтай, 5-р тэнхлэг 4                  дугуйтай                  Б: 1-р тэнхлэг 2                  дугуйтай, 2-р тэнхлэг 4                  дугуйтай, 3-р тэнхлэг 4                  дугуйтай, 4-р тэнхлэг 4                  дугуйтай, 5-р тэнхлэг 4                  дугуйтай                  В: 1-р тэнхлэг 2                  дугуйтай, 2-р тэнхлэг 2                  дугуйтай, 3-р тэнхлэг 4                  дугуйтай, 4-р тэнхлэг 4                  дугуйтай, 5-р тэнхлэг 4                  дугуйтай</p>	<p>40                  А: 8+8+24*                  Б:                  8+8+8+8+8                  В:                  8+8+8+16*</p>	
<p>3</p>	<p>Зургаан голтой,                  А: 1-р тэнхлэг 2                  дугуйтай, 2-р тэнхлэг 4                  дугуйтай, 3-р тэнхлэг 4                  дугуйтай, 4-р тэнхлэг 4                  дугуйтай, 5-р тэнхлэг 4                  дугуйтай, 6-р тэнхлэг 4                  дугуйтай                  Б: 1-р тэнхлэг 2                  дугуйтай, 2-р тэнхлэг 2                  дугуйтай, 3-р тэнхлэг 4                  дугуйтай, 4-р тэнхлэг 4                  дугуйтай, 5-р тэнхлэг 4                  дугуйтай, 6-р тэнхлэг 4                  дугуйтай                  В: 1-р тэнхлэг 2                  дугуйтай, 2-р тэнхлэг 4                  дугуйтай, 3-р тэнхлэг 4                  дугуйтай, 4-р тэнхлэг 4                  дугуйтай, 5-р тэнхлэг 4                  дугуйтай, 6-р тэнхлэг 4                  дугуйтай</p>	<p>44                  А:                  7+8+15*+7+7                  Б: 7+7+7+23*                  В:                  7+7+8+8+7+7</p>	

Тайлбар: \* Хоёр тэнхлэгийг холбосон гүүшингийн хийцээс нь хамааруулж тусдаа тэнхлэгтэй, тэргэнцэртэй гэж ангилна. Тэргэнцэрийн ачаалал нь тэнхлэг бүрд харгалзах ачааллын нийлбэртэй тэнцүү байна.

№	Нам аралтай чиргүүлийн төрөл, тэнхлэгийн тоогоор	Жишээ
---	--	-------

1	Цуваа байрлах хоёр тэнхлэгтэй	
2	Цуваа байрлах гурван тэнхлэгтэй	
3	Цуваа байрлах дөрвөн тэнхлэгтэй, сунадаг	

**ХАВСРАЛТ 7: MNS 4598:2020 “АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН БАЙДАЛД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” СТАНДАРТЫН ЗАРИМ ЗААЛТЫН ТАЙЛБАР, ЗӨВЛӨМЖ**

MNS 4598 стандартын 14.1 заалтыг дараах байдлаар ойлгоно (стандартын заалтыг тод хараар тэмдэглэв). Үүнд:

1. тэнхлэгийн даац 10 т-оос хэтрэхгүй байх – Нам аралтай чиргүүлийн нэг тэнхлэг дээрх даацыг чиргүүлийн техникийн тодорхойлолтоор тогтоосон “даац”ын хэмжээнээс үл хамаарч 10 т- оос хэтрүүлэхгүйгээр байхаар ачаална.
2. автоугсрааны зөвшөөрөгдөх бүх жин 115 т-оос хэтрэхгүй нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн тоормосны идэвхжил доод тал нь 45% байх – нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн тоормосны идэвхжил нь 45%-аас их буюу тоормосны хүчний хэмжээ жингийн 45%-аас их байна. Жишээ нь: Зөвшөөрөгдөх хамгийн их масс нь 115 т буюу бүх жин нь 115000 Н чиргүүлийн тоормосны идэвхижил 45%-аас их буюу 51750 Н-оос их байна.
3. тэнхлэг бүр нумтай байх – нам аралтай чиргүүлийн тэнхлэг бүр заавал зөөллөх элемент буюу нумтай байна. Автомашины гүүшин нь чиглүүлэх, зөөллөх, унтраах гэсэн 3 элементээс бүрдэх бөгөөд зөөллөх элемент нь зөвхөн хуудсан, эсвэл хийн нумтай байна.
4. тэнхлэгт ноогдох ачаалал 10 т-оос хэтэрвэл хийн нумтай байх – Нэг тэнхлэгт ноогдох ачааллын хэмжээ их тохиолдолд шахсан хийгээр ажилладаг хийн нумыг ашиглана.

MNS 4598 стандартын 14.2 заалтыг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

1. Автоугсрааны аль ч тэнхлэгт ноогдох ачаалал нэг дугуй нь өргөгдсөн тохиолдолд 10 т-оос, 2 дугуй нь өргөгдсөн тохиолдолд 12 т-оос хэтрэхгүй байх– Нам аралтай чиргүүлийн нэг тэнхлэг дээрх даацыг чиргүүлийн техникийн тодорхойлолтоор тогтоосон “даац”ын хэмжээнээс үл хамаарч 10 т-оос, дугуйгаа “өргөж, сойж” хөдөлгөөнд оролцдог чиргүүлийн нэг тэнхлэг дээрх ачааллыг 12 т-оос хэтрүүлэхгүйгээр байхаар тус тус ачаална.
2. автоугсрааны зөвшөөрөгдөх бүх жин 115 т-оос хэтрэхгүй байх – Нам аралтай чиргүүлийн зөвшөөрөгдөх хамгийн их масс нь 115 т буюу бүх жин нь 115000 Н байна.
3. нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн тоормосны идэвхжил доод тал нь 45% байх – Нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн тоормосны идэвхжил нь 45%-аас их буюу тоормосны хүчний хэмжээ жингийн 45%-аас их байна. Жишээ нь: Зөвшөөрөгдөх хамгийн их масс нь 115 т буюу бүх жин нь 115000 Н чиргүүлийн тоормосны идэвхижил 45%-аас их буюу 51750 Н- оос их байна.
4. тэнхлэг бүр нумтай байх – нам аралтай чиргүүлийн тэнхлэг бүр заавал зөөллөх элемент буюу нумтай байна. Автомашины гүүшин нь чиглүүлэх, зөөллөх, унтраах гэсэн 3 элементээс бүрдэх бөгөөд зөөллөх элемент нь зөвхөн хуудсан, эсвэл хийн нумтай байна.
5. нэг болон хэд хэдэн тэнхлэгт ноогдох ачаалал 10 т-оос хэтэрвэл хийн нумтай байх. – Нэг тэнхлэгт ноогдох ачааллын хэмжээ их тохиолдолд шахсан хийгээр ажилладаг хийн нумыг ашиглана.

MNS 4598 стандартын 14.3 заалтыг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

1. Автоугсрааны аль ч тэнхлэгт ноогдох ачаалал нэг дугуй нь өргөгдсөн тохиолдолд 10 т-оос, 2 дугуй нь өргөгдсөн тохиолдолд 12 т-оос хэтрэхгүй байх– Нам аралтай чиргүүлийн нэг тэнхлэг дээрх даацыг чиргүүлийн техникийн тодорхойлолтоор тогтоосон “даац”ын хэмжээнээс үл хамаарч 10 т-оос, дугуйгаа “өргөж, сойж” хөдөлгөөнд оролцдог чиргүүлийн нэг тэнхлэг дээрх ачааллыг 12 т-оос хэтрүүлэхгүйгээр байхаар тус тус ачаална.
2. автоугсрааны зөвшөөрөгдөх бүх жин 115 т-оос хэтрэхгүй байх – Нам аралтай чиргүүлийн зөвшөөрөгдөх хамгийн их масс нь 115 т буюу бүх жин нь 115000 Н байна.
3. нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн тоормосны идэвхжил доод тал нь 30% байх – Нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн тоормосны идэвхжил нь 30%-аас их буюу тоормосны хүчний хэмжээ жингийн 30%-аас их байна. Жишээ нь: Зөвшөөрөгдөх хамгийн их масс нь 50 т буюу бүх жин нь 50000 Н чиргүүлийн тоормосны идэвхижил 30%-аас их буюу 15000 Н-оос их байна.

4. тэнхлэг бүр нумтай байх – нам аралтай чиргүүлийн тэнхлэг бүр заавал зөөллөх элемент буюу нумтай байна. Автомашины гүүшин нь чиглүүлэх, зөөллөх, унтраах гэсэн 3 элементээс бүрдэх бөгөөд зөөллөх элемент нь зөвхөн хуудсан, эсвэл хийн нумтай байна.
5. нэг болон хэд хэдэн тэнхлэгт ноогдох ачаалал 10 т-оос хэтэрвэл хийн нумтай байх. – Нэг тэнхлэгт ноогдох ачааллын хэмжээ их тохиолдолд шахсан хийгээр ажилладаг хийн нумыг ашиглана.

MNS 4598 стандартын 14.2, 14.3 заалтыг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

Бусад тохиолдолд ачаа бүхий нам аралтай чиргүүл, хагас чиргүүлийн зөвшөөрөгдөх дээд хурд 15 км/цаг байна. Тоормосны идэвхжил доод тал нь 18 % байна – Энэ төрлийн чиргүүлийг чирж хөдөлгөөнд оролцох зөвшөөрөгдөх дээд хурд 15 км/цаг, тоормосны идэвхижил нь 15%-аас их буюу тоормосны хүчний хэмжээ жингийн 15%-аас их байна. Жишээ нь: Зөвшөөрөгдөх хамгийн их масс нь 100 т буюу бүх жин нь 100000 Н чиргүүлийн тоормосны идэвхижил 15%-аас их буюу 15000 Н-оос их байна.

## **ЗӨВЛӨМЖ**

**Тэнхлэгийн ачаалал.** Автотээврийн хэрэгслийн дугуй нь авто замтай харьцалтын талбайгаар харьцаж түүнийг дарж хотойлгох нөлөөг үзүүлдэг. Өөрөөр хэлбэл тэнхлэг бүрийн доор авто зам хотойлгонд ордог бөгөөд явсны дараа буцаж хэвэндээ ордог. Тэнхлэг хоорондын зай ойр болон хол байхаас хамаараад авто замын хотойсон хэсгүүд хоорондоо нийлэх, эсвэл зайтай байрлана. Мөн эхний тэнхлэгийн нөлөөгөөр хотойсон замын хэсэг буцаж хэвэндээ орж амжаагүй байхад дараагийн тэнхлэгийн нөлөөгөөр дахин хотойдог байна. Иймээс MNS 4598 стандартын 5.8-д “Автотээврийн хэрэгслийн тэнхлэг дээрх зөвшөөрөгдөх хамгийн их ачаалал”-ыг тогтоож өгсөн. Тэнхлэг хоорондын зай хол тохиолдолд тэнхлэг дээрх зөвшөөрөгдөх хамгийн их ачаалал ихсэж, тэнхлэг хоорондын зай ойр тохиолдолд зөвшөөрөгдөх хамгийн их ачаалал багасана. Иймээс тээврийн хэрэгслийн тэнхлэг хоорондын зайнаас хамааруулж тэнхлэг дээрх ачааллын зөвшөөрөгдөх хэмжээ хязгаарлагдана.

**Бүх жин, овор.** Тэнхлэг бүрийн ачааллын нийлбэр нь автотээврийн хэрэгслийн бүх жингийн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрэхийг хориглоно. Бүх жингийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс ихсэх тохиолдолд тэнхлэгийн нөлөөгөөр хотойсон зам буцаж хэвэндээ оролгүй эвдэрнэ. MNS 4598 стандартын 5.8-д автотээврийн хэрэгслийн “Бүх жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”, “Оворын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”-ний хязгаарлалтыг тогтоож өгсөн бөгөөд энэ нь Монгол улсад ашиглагдаж байгаа авто замыг эвдэхгүйгээр хөдөлгөөнд оролцож болох Авто тээврийн хэрэгслийн хамгийн массыг болон авто замаар багтаж хөдөлгөөнд оролцох (аюулгүйгээр баруун, зүүн, буцаж эргэх гэх мэт) боломжит хамгийн их уртыг тогтоож өгсөн. Авто зам дээр дугуйн мөрөөр ховил үүсэж эвдэрдэг шалтгаан нь бүх жингийн хэмжээ болон тэнхлэгийн ачаалал зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэх юм.

Автотээврийн хэрэгсэл дээр ачааг ачиж тээвэрлэхэд дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Ачааг ачихад автотээврийн хэрэгслийн тухайн үеийн масс нь MNS 4598 : 2020 стандартын 5.8-д заасан бүх жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэхгүй байгаа эсэхийг тогтооно. Автомашины өөрийн масс дээр ачааны массыг нэмж тухайн үеийн масс гарна. Мөн пүүгээр хэмжиж стандартын шаардлагад нийцсэн эсэхийг шалгана.
2. Цул, эсвэл өрдөг ачааг ачихдаа түүний хүндийн төв автотээврийн хэрэгсэл болон чиргүүлийн гол хэсэгт байхаар байрлуулна. Нурмаг ачааны овоолгын оройг автотээврийн хэрэгсэл болон чиргүүлийн гол хэсэгт байхаар ачна.
3. Ачааг ачсанаар тэнхлэг бүрийн ачаалал нь MNS 4598 : 2020 стандартын 5.8-д заасан тэнхлэг дээрх зөвшөөрөгдөх хамгийн их ачааллын хэмжээнээс хэмтрэхгүй байгаа эсэхийг тогтооно. Ингэхдээ ачааны массыг автотээврийн хэрэгслийн ачаа байрлах хэсгийн тэнхлэгийн тоонд

хуваагаад, гарсан хэмжээг тэнхлэг бүрийн ачаалал дээр нэмнэ. Ачааллыг тооцохдоо дараах аргыг ашиглаад, заавал пүүгээр хэмжиж баталгаажуулсны дараа авто замаар хөдөлгөөнд оролцох нь зүйтэй. Үүнд:

- Хоёр, гурван тэнхлэгтэй дан тээврийн хэрэгслийн хувьд ачааны массын 2/3 нь хойд тэнхлэгт, 1/3 нь урд буюу жолоочийн бүхээгний доорх тэнхлэг дээр ачааллана.
  - Дөрөв, тав болон түүнээс олон тэнхлэгтэй автотээврийн хэрэгслийн хувьд жолоочийн бүхээгний доор байрлах тэнхлэгийг хасаад бусад тэнхлэгүүдэд ачааны массыг жигд хуваарилана
  - Эмээлт автоугсраа болон чиргүүлтэй тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн бүхээгний доор байрлах тэнхлэгийг хасаад бусад тэнхлэгүүдэд ачааны массыг жигд хуваарилана.
4. Давхар дугуйтай тэнхлэгийн нэг дугуйн хий гарсан, эсвэл нэг дугуй нь байхгүй, эсвэл үйлдвэрлэгчээс тогтоосон хэмжээнээс нарийн дугуй тавьсан тохиолдолд ачаа ачиж тээвэрлэхийг хориглоно.
  5. Нам аралтай чиргүүлээр тээвэрлэх дугуйтай болон гинжит машин механизмыг чиргүүлийг голуулж байрлуулна. Хоёр болон түүнээс олон машин, механизмыг ачих тохиолдолд тэдгээрийг чиргүүлийг голлож байхаар цувруулан зогсооно.
  6. Нам аралтай чиргүүлээр дугуйгаар тоноглоогүй ачааг тээвэрлэхдээ чиргүүлийг голлож байхаар ачаална. Нам аралтай чиргүүлээр шингэн, нурмаг болон нэг бүрийг нь бэхлэх боломжгүй ширхэгийн ачаа тээвэрлэхийг хориглоно.
  7. Нам аралтай чиргүүлээр ачаа тээвэрлэх үеийн ачааллыг тооцохдоо чиргүүлийн бүх тэнхлэг, чирэгчийн жолоочийн бүхээгний доорх тэнхлэгээс бусад тэнхлэгүүдэд ачааны жин жигд хуваарилагдана гэж тооцох бөгөөд пүүгээр жинлэж шалгах үед тэнхлэгийн ачаалал MNS 4598:2020 стандартын 14-т заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй байна.
  8. Нам аралтай чиргүүлийн тоормосны идэвхжил MNS 4598:2020 стандартын 14-т заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс багагүй байна. Тоормосны идэвхижлийг тооцохдоо бүх дугуйны тоормосны хүчний нийлбэр, автотээврийн хэрэгслийн тухайн үеийн жин хоёрын харьцаагаар тодорхойлно. Ж нь: Идэвхижил 50% гэдэг нь бүх дугуйны тоормосны хүчний нийлбэр нь автотээврийн хэрэгслийн тухайн үеийн жингийн 50 хувьтай тэнцүү гэж ойлгоно. Өөрөөр хэлбэл Автотээврийн хэрэгслийн тухайн үеийн жин 100кН бол тоормосны хүчний нийлбэр 50кН байна.
  9. Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэхийг хориглоно. Учир нь хөдөлгөөнд орж буй автотээврийн хэрэгслээс авто замд үзүүлэх нөлөө динамик шинж чанартай болох учир авто замыг эвдэх, кинетик энерги хурдны квадрат хэмжээнээс шууд хамаардаг тул тоормосны зам уртасах зэрэг эрсдэл үүснэ.

MNS 4598:2020 стандартад бүх жин, тэнхлэгийн ачаалал, нам аралтай чиргүүлтэй холбоотой дараах дутагдалтай зүйл байгаа тул уг стандартыг дахин хянан үзэх шаардлагатай байна. Үүнд:

- Стандартад жин, масс гэсэн ойлголтыг хольж хэрэглэсэн байдаг. Жишээ нь: Бүх жин гэсэн ойлголт нь үнэндээ жингийн хязгаарлалт биш массын хязгаарлалт юм.
- Стандартад хэрэглэдэг нэр томъёо, тодорхойлолт MNS ISO 1176:2001 стандарттай нийцэхгүй байна.
- Стандартаар зөвшөөрсөн бүх жинтэй дан автотээврийн хэрэгслээр стандартаар зөвшөөрсөн бүх жинтэй чиргүүлийг чирэх үед стандартын шаардлагад нийцэхгүй болдог.
- Тэнхлэгийн ачааллын зөвшөөрөгдөх хэмжээнд нийцсэн автотээврийн хэрэгслийн бүх жингийн зөвшөөрөгдөх хэмжээнд нийцэхгүй байх. Бүх жингийн зөвшөөрөгдөх хэмжээнд нийцсэн автотээврийн хэрэгсэл тэнхлэгийн ачааллын зөвшөөрөгдөх хэмжээнд нийцэхгүй байх.
- Нам аралтай чиргүүлийн зөвшөөрөгдөх бүх жин, уг стандартын зөвшөөрөгдөх бүх жинд тавигдах шаардлагатай уялдаагүй
- Нам аралтай чиргүүлийн овор хэмжээг зохицуулсан зохицуулалт байхгүй зэрэг багтана.





## **ХАВСРАЛТ 8. ХҮНД ЖИНТЭЙ БА (ЭСВЭЛ) ТОМ ОВРЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АВТО ЗАМААР ЗОРЧИХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ ЖУРМЫН ТӨСӨЛ (ОХУ-Д МӨРДӨЖ БУЙ ЖУРМЫН ОРЧУУЛГА)**

### **I. Ерөнхий зүйл**

1. Хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн авто замаар зорчих тусгай зөвшөөрөл олгох журам нь (цаашид Журам гэх), нь хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн авто замын хөдөлгөөнд оролцох тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрөл хүсэх өргөдөл хүлээн авах, танилцах, зөвшөөрөх, тусгай зөвшөөрөл олгох (олгохоос татгалзах) бүртгэлийн журмыг тодорхойлно.
2. Хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн авто замын хөдөлгөөнд тусгай зөвшөөрлийг (цаашид тусгай зөвшөөрөл гэх) эрх бүхий байгууллага олгоно.
3. Тусгай зөвшөөрөл нь эрх бүхий байгууллагаас баталсан загвар бүхий маягт дээр бичигдэж, тээврийн хэрэгслийн эзэмшигч буюу эрх бүхий этгээдэд олгогдоно.

Тусгай зөвшөөрлийг Монгол хэлээр бичиж (ачааны төрөл, тээврийн хэрэгслийн марк, загварын нэр, тэдгээрийн улсын бүртгэлийн дугаарыг багтаасан байна) гаргана. Тусгай зөвшөөрөлд "Хөдөлгөөний онцгой нөхцөл", "Дагалдах зүйлийн төрөл" гэсэн зүйлээс бусад зүйлд засвар оруулахыг хориглоно. Заасан төрлүүдэд хүнд ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн маршрутыг замын хяналтын улсын байцаагчийн зөвшөөрөл, тухайн хэлтсийн эрх бүхий улсын байцаагч гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан тохиолдолд өөрчлөлт оруулж болно.

4. Тусгай зөвшөөрөл нь тодорхой чиглэлд ачаатай ба ачаагүй зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд 3 хүртэл сарын хугацаатай олгогдоно.

Хөдөө аж ахуй, барилга замын өөрөө явагч машин механизмаар 3 сараас 11 сар хүртэл нэг суурин газрын хүрээнд ажиллахаар бол энэ техникийн хөдөлгөөнд тодорхой маршрутын дагуу 9 сар хүртэл хугацаатай тусгай зөвшөөрөл олгогдоно. Автозам дээр төлөвлөгөөт бус ажил /эсвэл/ түүнтэй огтлолцсон инженерийн байгууламж, шугам сүлжээнд төлөвлөгөөт бус ажлыг тогтсон чиглэлийн дагуу гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд тэрхүү өөрөө явагч машин механизмын том оврын техникийн хөдөлгөөнд олгосон тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болно. Тухайн автозам эзэмшигч (автозамын хэсгийн) нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас хуанлийн 14 хоногийн өмнө энэ тухай хөдөө аж ахуйн том оврын техникийн эзэмшигч, эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч энэхүү Журмын 8 дугаар зүйлд заасан зөвшөөрөл олгодог итгэмжлэгдсэн байгууллагын зөвшөөрсөн аргаар мэдэгдэнэ.

Тусгай зөвшөөрлийг электрон хэлбэрээр олгох тохиолдолд тусгай зөвшөөрөл нь нэг удаагийн тээвэрт нэг хүртэлх сарын хугацаатай олгогдоно.

Хэрвээ хүнд жинтэй тээврийн хэрэгслийн тэнхлэг дээрх ачаалал тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх ачааллаас 2 хувиас илүү, гэхдээ 10 хувиас ихгүй бол тогтоосон эсвэл байнгын чиглэлийн дагуу тэрхүү тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд олгох тусгай зөвшөөрөл, түүний дотор электрон хэлбэрээр өгөх бол хялбаршуулсан журмаар олгож болно.

5. Тусгай зөвшөөрлийн бланкууд нь хэвлэмэл бүтээгдэхүүний хамгаалалтын "В" төвшний шаардлагад тохирч байх ёстой.

## II. Тусгай зөвшөөрөл авах өргөдөл өгөх

6. Тусгай зөвшөөрөл авах өргөдлийг (цаашид- өргөдөл гэх) эрх бүхий байгууллагад дараах дарааллаар өгнө. Үүнд:

- тухайн тээврийн хэрэгслийн авто замын маршрут, маршрутын хэсэг нь улсын чанартай автозамаар, эсвэл түүний хэсгээр дамжин өнгөрч байгаа бол хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн автозамын хөдөлгөөнд оролцох зөвшөөрөл авах өргөдлөө авто замын асуудал хариуцсан агентлаг эсвэл тэдгээрийн эрх бүхий харьяа байгууллагуудад өгнө.
- Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнд оролцохоор өргөдөл өгөхдөө тухайн маршрут болон маршрутын хэсэг бүс нутгийн болон хот хоорондын чанартай автозамаар өнгөрөх, эсвэл 2 ба түүнээс дээш хот орчмын газар нутаг дээрх орон нутгийн чанартай автозамын хэсгээр өнгөрөх (хотын дүүрэг, хот орчмын), дараах нөхцөлд, тухайн тээврийн хэрэгслийн маршрут нь, маршрутын хэсэг нь улсын чанартай автозамаар өнгөрөхгүй бол, Монгол улсын улсын эрх бүхий байгууллага, эсвэл тэдгээрийн итгэмжлэгдсэн байгууллагад өгнө.

Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн автозамын хөдөлгөөнд оролцох өргөдлийг

- хэрвээ маршрут, маршрутын хэсэг хотын дүүргийн орон нутгийн чанартай автозамаар, хоёр ба түүнээс дээш хотын дүүргийн газар нутаг дээрх орон нутгийн чанартай автозамаар өнгөрч, харин Улсын болон хот хоорондын чанартай, тийм автозамын хэсгээр өнгөрөхгүй байвал - хотын дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага эсвэл түүний харьяа эрх бүхий байгууллагуудад;
- хэрэв маршрут, тухайн тээврийн хэрэгслийн маршрутын хэсэг нь хот суурин газрын орон нутгийн чанартай автозамаар, дараах нөхцөлд, тухайлбал, тухайн тээврийн хэрэгслийн маршрут нь тийм хот суурин газрын хил орчмоор явж, заасан маршрут, түүний хэсэг нь улсын болон орон нутгийн чанартай хот дүүргийн замаар өнгөрөхгүй бол- хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн автозамын хөдөлгөөнд оролцох өргөдлийг орон нутгийн захиргааны өөрөө удирдах байгууллага эсвэл түүний харьяа эрх бүхий байгууллагуудад;
- хэрэв маршрут, тухайн тээврийн хэрэгслийн маршрутын хэсэг нь хөдөө тосгоны орон нутгийн замаар явж, дараах нөхцөлд, тухайлбал, тийм тээврийн хэрэгслийн маршрут хөдөө орон нутгийн, тосгоны хөдөөгийн суурингийн хил орчмоор өнгөрч, мөн заасан маршрут, түүний хэсэг нь холбооны, бүс нутгийн эсвэл хот хоорондын, хотын дүүргийн чанартай, тийм автозамын хэсгүүдээр дамжихгүй байвал- хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн автозамын хөдөлгөөнд оролцох өргөдлийг хөдөөгийн суурингийн орон нутгийн өөрөө удирдах засаг захиргаа эсвэл түүний харьяа эрх бүхий байгууллагад, эсвэл Монгол улсын хуулиар ийм автозамын үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлыг хөдөө тосгонд шийдвэрлэхээр заасан тохиолдолд харьяа байгууллагуудад;
- хэрэв маршрут, тухайн тээврийн хэрэгслийн маршрутын хэсэг нь хот дүүргийн орон нутгийн чанартай замаар өнгөрч, улсын болон орон нутгийн чанартай, тийм замын хэсгээр өнгөрөхгүй бол- хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн автозамаар хөдөлгөөнд оролцох өргөдлөө хотын дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага эсвэл түүний харьяа эрх бүхий байгууллагад;
- хэрэв тээврийн хэрэгслийн маршрут нь хувийн эзэмшлийн автозамаар явж өнгөрч байвал- хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн оролцох өргөдлийг автозамын эзэмшигчид тус тус гаргана.

7. Өргөдлийг энэ журмын 6 дугаар зүйлд заасан тээврийн чиглэл эхэлж байгаа газар нутгийн үйлчилгээний бүсийн байгууллагад өгнө. (цаашид - эрх бүхий байгууллага, харьяа байгууллага гэх)

Энэхүү журмын 6-р зүйлд заасан эрх бүхий байгууллагууд, түүнчлэн харьяа байгууллагууд (байгууллага) -ын үйлчлэх нутаг дэвсгэр, түүнчлэн тэдэнд олгосон зам, үйлчилгээний нутаг дэвсгэрийн талаарх мэдээллийг Улсын автозамын албан ёсны вэбсайтад байрлуулна. Мөн Мэдээлэл, харилцаа холбооны "Интернет" сүлжээний агентлаг, түүнчлэн Монгол улсын байгууллагуудын гүйцэтгэх засаглалын албан ёсны вэбсайтууд дээр мэдээллийг байрлуулна.

Хэрэв энэ журмын 9-д заасны дагуу өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авах ажлыг харьяа байгууллага (байгууллага) гүйцэтгэж байгаа бол өргөдлийг хянан хэлэлцэж, батлах ажлыг холбогдох харьяа байгууллага (байгууллага)-ууд энэ Журмаар тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.

Тусгай зөвшөөрлийн улсын хураамжийг цахим хэлбэрээр өргөдөл ирүүлсэн бол өргөдөл гаргахаас өмнө, өргөдөл гаргасны дараа, гэхдээ харин хянан хэлэлцэхээс өмнө төлсөн байх ёстой.

#### 8. Өргөдөлд:

- тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргагчийн мэдээлэл (цаашид- өргөдөл гаргагч гэх) – тээврийн хэрэгсэл эзэмшигчийн болон эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл: компанийн нэр, оршин байгаа газрын хаяг (хуулийн этгээдийн хувьд), овог нэр, оршин суугаа хаяг (хувь хүн, хувиараа бизнес эрхлэгчийн хувьд), утасны дугаар, цахим шуудангийн хаяг /байгаа бол/
- өргөдлийн дугаар, өргөдөл өгсөн огноо;
- эрх бүхий байгууллагын нэр;
- тээврийн хэрэгслийн эзэмшигчийн мэдээлэл:
- компанийн нэр, байгууллага-эрх зүйн маягт, улсын бүртгэлийн гэрчилгээ, оршин байгаа газрын хаяг, утасны дугаар
- хуулийн этгээдийн хувьд: овог нэр, оршин суух газрын бүртгэлийн хаяг, утасны дугаар – хувь хүн, хувиараа бизнес эрхлэгч (хувиараа бизнес эрхлэгчийн байдлыг илэрхийлсэн)
- татвар төлөгчийн гэрчилгээ (цаашид - ТТГ) ба улсын бүртгэлийн регистрийн үндсэн дугаар (цаашид - УБД эсвэл) –Монгол-ын нутаг дэвсгэрт бүртгэлтэй хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдэд;
- хөдөлгөөний чиглэл (хөдлөх цэг – хүрэх газрын нэр, хаяг, хэрэв маршрут нь суурин газруудын гудамж-замын сүлжээгээр дамжин өнгөрөх бол завсрын цэгүүдийг заахгүйгээр очих цэг)
- тээвэрлэлтийн төрөл (Монголын нутаг дэвсгэрээр);
- тээвэрлэлтийг гүйцэтгэх хугацаа;
- тээвэрлэлтийн тоо (хүнд жинтэй тээврийн хэрэгслийн хувьд); ачааны шинж чанар (ачаатай бол) нэр төрөл, овор хэмжээ (урт, өргөн, өндөр), жин, хуваагдах чанар
- Тээврийн хэрэгслийн тухай мэдээлэл: марк, загвар, улсын бүртгэлийн дугаар;
- тээврийн хэрэгслийн таних дугаар (энэ журмын VII бүлэгт заасны дагуу өргөдөл гаргахад);
- тээврийн хэрэгслийн овор хэмжээ (авто чирэгчийн): жин, тэнхлэг хоорондын зай, тэнхлэг дээрх ачаалал, тэнхлэг бүр дэх дугуйн тоо болон нумны төрөл (хийн нумтай эсэх), овор хэмжээс (урт, өргөн, өндөр), машины урд талаас дугуйн тэнхлэг хүртэлх зай (байгаа бол), ачаатай байх үеийн хамгийн бага эргэлтийн радиус,
- холбогдох арга: утсаар, цахим шуудангаар, бусад.

Том оврын Хөдөө аж ахуй, барилга замын өөрөө явагч машин механизмаар 3 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл нэг суурин газарт өөрөө очиж ажиллаж байгаа тохиолдолд өргөдөлд явах болон очих цэг, хөдөө аж ахуйн ажил хийгдэх газар руу орох орц, гарцыг зааж өгнө.

Аялал эхлэх хугацаа нь өргөдөл өгсөн хугацаанаас эхлэн 45 хоногоос хэтрэхгүй байна.

Өргөдөл нь Монгол хэл дээр бичгийн машины бичвэрээр бичигдсэн байна /ачааны нэр, тээврийн хэрэгслийн марк, загвар, тэдгээрийн улсын бүртгэлийн дугаарыг латин цагаан толгойн үсгээр бичихийг зөвшөөрнө/

9. Өргөдөлд дараах зүйлийг хавсаргана:

1) Хүнд жинтэй болон /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн схем зургийг ачаа ачсан байдлаар /ачаатай бол/ санал болгож буй схем зураг. Схем зураг дээр тээвэрлэлтэд оролцуулахаар төлөвлөж буй тээврийн хэрэгслийг дүрсэлж зурах бөгөөд түүний хэмжээсүүдийг ачаатай (ачаа байгаа бол), тэнхлэгүүдийн болон түүн дээрх дугуйнуудын тоо, тэнхлэг болон дугуйнуудын харилцан байрлал, тэнхлэгүүд дээр ачааллын хуваарилалт, түүнчлэн ачаатай үеийн – ачааны хэмжээсүүд, тээврийн хэрэгсэл дээр ачааны байрлал, ачих өндөр, машины урд хэсгээс урд дугуйн тэнхлэг хүртэлх зай (хэрэв байгаа бол) (хажуугаас болон араас харсан байдал)

2) Тээвэрт ашиглахаар төлөвлөж буй тээврийн хэрэгсэл бүрийн бичиг баримтын хуулбар (тээврийн хэрэгслийн паспорт, эсвэл тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээ, өөрөө явагч машины паспорт),

3) Хэрэв ашиг сонирхлынх нь төлөө тусгай зөвшөөрөл олгосон этгээдийн төлөөлөгч өргөдөл гаргасан бол түүний бүрэн эрхийг баталгаажуулсан баримт бичгийн хуулбарыг өргөдөлд хавсаргана.

10. Өргөдөл, хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн (авто чирэгч) схем зураг, түүнчлэн бичиг баримтын Энэхүү Журмын зүйл 9, дэд зүйл 2-г заасны дагуу хавсралтууд дээр өргөдөл гаргагч гарын үсэг зурж, тамга /хэрвээ байгаа бол/ дарсан байна.

11. Өргөдөл болон түүнд хавсаргасан бичиг баримтуудыг эрх бүхий байгууллагад шууд өгөх хэрэгтэй, мөн эрх бүхий байгууллагын хаягаар шуудангаар явуулах, факсаар илгээх, эсвэл улсын мэдээллийн нэгдсэн портал руу цахим хэлбэрээр "Төрийн болон хотын үйлчилгээний нэгдсэн портал (үүрэг)" (цаашид Портал гэх) явуулж болно.

Баримт бичгийг эрх бүхий байгууллагын хаягаар факсаар илгээсэн тохиолдолд өргөдөл гаргагч нь тусгай зөвшөөрлийн маягт хүлээн авахаар хандахдаа тэдгээр материалуудын эх хувийг энэхүү Журмын 10 дугаар зүйлд заасны дагуу авчирна.

Энэхүү Журмын VII бүлэгт заасны дагуу өргөдөл нь тээвэрлэгчийн хувийн кабинетаар дамжуулан өгөгдсөн бол нэвтрэх эрх нь "Интернет" мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ (цаашид – хувийн кабинет) эрх бүхий байгууллагын албан ёсны вэбсайтаар дамжуулан хийгдэнэ.

12. Эрх бүхий байгууллага (харьяа байгууллага) дараах нөхцөлд өргөдлийг бүртгэж авахаас татгалзана, хэрвээ:

- 1) Эрх бүхий байгууллага нь энэ Журмын 6 дугаар зүйлд заасанчлан өргөдөл гаргасан чиглэлд тусгай зөвшөөрөл олгох эрхгүй бол;
- 2) Энэ өргөдөлд гарын үсэг зурах эрхгүй хүн гарын үсэг зурсан бол;
- 3) Өргөдөл нь Журмын 8 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг агуулаагүй, эсвэл энэ шаардлагыг хангаагүй;

Энэхүү Журмын 9 дүгээр зүйлд заасан бичиг баримтууд өргөдөлд хавсрагдаагүй эсвэл өргөдөлд хавсаргасан материалууд энэ Журмын 9, 10 дугаар зүйлийн шаардлага хангаагүй.

Өргөдлийг бүртгэж авахаас татгалзсан шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага (харьяа байгууллага) (байгууллага) нь өргөдөл болон хавсралт материалыг өгсөн өргөдөл гаргагчид өргөдлийг хүлээн

авсан хугацаанаас ажлын нэг өдрийн дотор тухайн өргөдөл гаргагчийн сонгосон харилцаа холбооны аргаар энэ шийдвэрийг гаргах үндэслэлийг заасан шийдвэрийн талаар мэдэгдэх үүрэгтэй.

13. Эрх бүхий байгууллагын албан тушаалтан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын нэг өдрийн дотор бүртгэж авна.

### III. Өргөдлийг судалж шалгах

14. Эрх бүхий байгууллага нь өргөдлийг бүртгэж авсан өдрөөс ажлын дөрөв хоногийн хугацаанд бичиг баримтад дараах шалгалтыг хийнэ:

1) хувиараа бизнес эрхлэгч болон хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн мэдээлэл /дотоодын тээвэрлэгчийн тухайд/

2) хуваагдах ачааг тээвэрлэхэд тавигдах шаардлага хангаж байгаа тухай мэдээлэл

14.1 Өргөдөл гаргагчийн хүсэлтээр өргөдлийг судалж, шалгаж байгаа Эрх бүхий байгууллага нь өргөдлийг өгсөн огноо, түүний бүртгэлийн дугаарын тухай мэдээлэл өгнө. Өргөдөл гаргагчийн санаачлагаар тусгай зөвшөөрлийг гарахаас өмнө эрх бүхий байгууллагад өргөдөл бичиж чөлөөт хэлбэрээр илгээсэн хүсэлтийн дагуу өргөдлийг буцаан татаж авч болно.

### IV. Хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийг зөвшилцөх

15. Хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийг эрх бүхий байгууллага тухайн маршрут явж буй автозамын эзэмшигчтэй хамтарч батална (цаашид- автозам эзэмшигч гэх)

Эрх бүхий байгууллага нь хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийг Авто замын улсын хяналтын байцаагчтай дараах тохиолдлуудад зөвшилцөж тогтооно:

1) Тээврийн хэрэгслийн ачааны овор хэмжээ Монгол улсын Засгийн газраас тогтоосон зөвшөөрөх хэмжээнээс 2-хувиас илүү тохиолдолд;

2) тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд дараах зүйлүүд шаардлагатай бол:

a. автозамын тусгайлсан хэсгүүдийг хамгаалах, бэхэлгээ хийх,

b. тээврийн хэрэгслийн чиглэлийн хүрээнд автозамын инженерийн шугам сүлжээ, тэдгээрийн байгууламжтай огтлолцох тохиолдолд тусгай арга хэмжээг авах

Тээврийн хэрэгслийн маршрутыг тохиролцлын /зөвшилцлийн/ бичгийн хуулбарыг цахим шуудан (дараа нь эх хувийг ирүүлэхээр), факс, цахим гарын үсэг ашиглан харилцах, түүнчлэн хэлтэс хоорондын цахим харилцан үйлчлэлийн нэгдсэн системийг ашиглан илгээх боломжтой.

16. Энэхүү Журмын 6 дугаар зүйлийн 2-д заасанчлан эрх бүхий байгууллагад өргөдлөө өгсөн бол тээврийн хэрэгслийн маршрутын зөвшилцөл цахим гарын үсгийг ашиглан харилцан хийгдэж болно.

16.1 Эрх бүхий байгууллага өргөдлийг бүртгэж авснаас хойш ажлын 4 хоногийн хугацаанд:

1) өргөдөл гаргасан маршрутын дагуу замыг тогтооно;

2) тээврийн хэрэгслийн замын дагуух автозамын болон энэхүү Журмын зүйл 18.4 -ээр тодорхойлогдсон нийтийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн бус төмөр замын тээврийн дэд бүтцийн эзэмшигчийг тодорхой болгох;

энэ зүйлийн дэд зүйлд зүйлээр тодорхойлогдсон эзэмшигчдийн хаягаар хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийн хэлэлцээ /зөвшилцөл/ хийх хүсэлт илгээнэ.

Хэлцэлд дараах зүйлийг заана:

- хэлцэл хийх хүсэлт гаргасан байгууллагын нэр
- хэлцэл хийх хүсэлтийн дугаар, огноо

- хөдөлгөөний маршрут (маршрутын хэсэг)
- тээврийн хэрэгслийн марк, загвар, улсын бүртгэлийн дугаар;
- санал болгож буй аяллын хугацаа, тоо /хүнд жинтэй тээврийн хэрэгслийн тухайд/
- тээврийн хэрэгслийн хэмжээсүүд:
- жин, тэнхлэгүүдийн хоорондох зай, тэнхлэг дээрх ачаалал, тэнхлэг бүр дээрх дугуйн тоо болон дугуйн эгнээний тоо, хийн нум байгаа эсэх, овор хэмжээ (урт, өргөн, өндөр, автомашины урд талаас урд дугуйн тэнхлэг хүртэлх зай /байгаа бол/), ачаатай үеийн хамгийн бага радиус;
- өргөдөл гаргагчийн тухай болон түүнтэй холбогдох арга хэрэгслүүдийн талаарх мэдээлэл;
- албан тушаалтны гарын үсэг (эрх бүхий байгууллагын цахим гарын үсэг)

Энэхүү Журмын 15 дугаар зүйлд заасан, хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн маршрутыг энэхүү зүйлийн дэд зүйлд заасны дагуу бүх эзэмшигч нартай энэхүү дэд зүйлийн 2-г заасан, тохиролцсоны дараа эрх бүхий байгууллага ажлын нэг өдрийн дотор хүнд ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн маршрутыг зөвшилцөх хүсэлтийг эрх бүхий байгууллагын байрлах хаягийн дагуу улсын авто тээврийн хяналтын хэлтэст гаргана.

Замын хяналтын улсын байцаагчид хүсэлт гаргахдаа энэхүү Журмын 9 дүгээр зүйлийн 1 ба 2 дахь дэд зүйлд заасанчлан бичиг баримтын хуулбар хувийг тээврийн хэрэгслийн маршрутыг тохиролцсон зөвшөөрлийн хамт, хөдөлгөөн зохион байгуулалтын зураг төсөл, эсвэл автозам, тэдгээрийн хэсгүүдийг хамгаалах, бэхэлгээ хийх, автозамыг огтлох инженерийн байгууламжууд, шугам сүлжээг хамгаалах арга хэмжээг зөвшөөрсөн тухай, тухайн автозам, түүний хэсгүүдээр хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгсэл аюулгүй зорчих нөхцөлийг хангасан (цаашид-тусгай төсөл гэх) материалыг хавсаргасан (шаардлагатай тохиолдолд) тусгай зөвшөөрлийг цаасан хэлбэрээр олгох тохиолдолд мөн тусгай зөвшөөрлийн бланкийн хавсралттай хувийг илгээнэ.

17. Энэхүү Журмын 17 дугаар зүйлийн 3 дахь дэд зүйлд заасан хүсэлтийг түүний орж ирсэн хугацаанаас ажлын нэг өдрийн дотор бүртгэнэ.

Хөдөлгөөний чиглэл /маршрут/, түүний хэсэг автозам эзэмшигчийн замтай давхцахгүй бол тухайн замын эзэмшигч нь энэ тухай хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын нэг өдрийн дотор эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

17.1 Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийн зөвшилцлийг /маршрут/ автозам эзэмшигч болон Улсын авто замын хяналтын байцаагч нар эрх бүхий байгууллагаас ирсэн хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлыг дөрөв өдрийн хугацаанд гүйцэтгэнэ. Энэхүү Журмын 17 дугаар зүйлийн 3 дахь дэд зүйлд Автотээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцож буй этгээд хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн маршрутыг зөвшилцөхөд тухайн өргөдөл гаргасан маршрутын дагуух автозамын болон хиймэл байгууламжийн нөхцөл байдлын мэдээлэл, мөн автозамын техникийн нөхцөл байдал, хиймэл байгууламжийн нэмэлт шалгалтын дүнг үндэслэн хиймэл байгууламж, бусад инженерийн байгууламжийн ачаа даах чадвараас шалтгаалан хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хийх бололцоог тодорхойлно.

Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийн /маршрут/ зөвшөөрлийн хамт автотээврийн хэрэгсэл эзэмшигчийн хүнд жинтэй тээврийн хэрэгслээс автозамд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх төлбөрийн тооцоог эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийн /маршрут/ тогтоосноор Улсын авто замын цагдаагийн газраас тэрхүү чиглэлд тусгай зөвшөөрлийн “Дагалдах төрөл” ба “Хөдөлгөөний тусгай нөхцөл” гэсэн заалтад хөдөлгөөнд тавигдах шаардлагуудыг тогтоодог.

17.2 Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийг авто замтай огтлолцож байгаа инженерийн байгууламж, шугам сүлжээ эзэмшигчидтэй зөвшилцөх үед шаардлагатай

тохиолдолд автозам эзэмшигч нь хүсэлтийг бүртгэж авсан өдрөөс ажлын нэг өдрийн хугацаанд дээр заасан инженерийн байгууламж, шугам сүлжээ эзэмшигчид зохих хүсэлтийг илгээнэ.

Инженерийн байгууламж, шугам сүлжээний эзэмшигчидтэй хийх зөвшилцлийг дээр дурдсан хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын хоёр өдөрт багтааж гүйцэтгэнэ

17.3 Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд замын хөдөлгөөн зохион байгуулалтын зураг төсөл, тусгай зураг төсөл, боловсруулалт, автозамын судалгаа, автозамд судалгаа хийх, тэдгээрийг хамгаалах бэхэлгээ хийх эсвэл автозамын хэсгүүдэд мөн түүнчлэн автозам инженерийн байгууламж, шугам сүлжээтэй огтлолцоход хамгаалах тусгай арга хэмжээ авах шаардлагатай бол эрх бүхий байгууллага нь өргөдөл гаргагчид тухайн арга хэмжээг зохион байгуулах шаардлагатайг тогтоосон өдрөөс хойш ажлын нэг өдрийн дотор өргөдөл гаргагчийн сонгосон харилцааны аргаар энэ тухай түүнд мэдээлж, цаашид хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийн /маршрут/ зөвшилцөл Энэхүү журмын V зүйлийн дагуу хийгдэнэ.

Дараах нөхцлүүдийн аль нэг нь хангагдсан тохиолдолд дурдсан арга хэмжээнүүд явагдана:

- 1) хүнд жинтэй тээврийн хэрэгслийн жин автозамын хэсгийн эсвэл хиймэл байгууламжийн даах чадвараас хэтэрсэн тохиолдолд;
- 2) том оврын тээврийн хэрэгслийн овор хэмжээсүүд автозамын төлөвлөлт, хөндлөн огтлол дээрх радиусыг тооцсон хэмжээнд ойртож байвал;

17.4 Хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнийг зохион байгуулахад тавигдах шаардлагад эдгээр арга хэмжээг тусгасан бол Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн чиглэл /маршрут/ төмөрзамын гармаар гарч байгаа бол эрх бүхий байгууллага нь өргөдлийг хүлээн авсан өдрөөс ажлын дөрвөн өдрийн хугацаанд нийтийн эзэмшлийн төмөрзамын тээврийн эзэмшигч болон нийтийн эзэмшлийн бус төмөрзамын дэд бүтэц эзэмшигчид дараах нөхцөлүүдийн аль нэг нь хангагдсан тохиолдолд холбогдох хүсэлтийг илгээнэ:

- тээврийн хэрэгслийн өргөн ачаатай болон ачаагүй үед 5 м болон түүнээс их;
- тээврийн хэрэгслийн өндөр замын гадаргуугаас дээш 4,5м болон түүнээс их;
- автоугсрааны урт нэг чиргүүлийн хамт 22м эсвэл автопоезд нь 2 ба түүнээс дээш чиргүүлтэй бол;
- тээврийн хэрэгслийн хурд 8 км/цаг-аас бага бол.

Нийтийн эзэмшлийн төмөрзамын тээврийн болон нийтийн эзэмшлийн бус төмөрзамын тээврийн эзэмшигчдийн зөвшилцөл нь хүсэлт хүлээн авсанаас ажлын дөрөв өдрийн хугацаанд хийгдэнэ.

17.5 Том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийг зөвшилцөх явцад тухайн тээврийн хэрэгсэл нь хүнд жинтэй тээврийн хэрэгсэл болох нь тогтоогдвол автозам эзэмшигч нь хүсэлт бүртгэж авсанаас хойш ажлын нэг өдрийн хугацаанд энэхүү Журмын 17 зүйлийн 3 дахь дэд зүйлд зааснаар энэ тухай өргөдөл гаргагч болон эрх бүхий байгууллагад мэдэгдэж, мөн өргөдөл гаргагчид чиглэлийн дагуу шаардагдаж буй аяллын тооны тухай хүсэлтээ ирүүлэхийг мэдэгдэнэ.

Өргөдөл гаргагч нь хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын хоёр өдрийн дотор автозам эзэмшигчид өргөдөл өгсөн маршрутын дагуу шаардлагатай тооны аяллын талаар мэдэгдэнэ. Энэ тохиолдолд автозам эзэмшигч нь хөдөлгөөний маршрутын зөвшилцөхдөө эрх бүхий байгууллагад зөвшөөрөгдсөн аяллын тооны талаар мэдэгдэнэ. Тусгай зөвшөөрлийг олгох хугацааг энэхүү зүйлд заасан үйл ажиллагааг явуулах хугацаагаар сунгана.

17.6 Өргөдөл гаргагч нь энэхүү Энэхүү Журмын 18.5 -д заасанчлан автозам эзэмшигчид шаардагдаж байгаа аяллын тооны талаар мэдэгдээгүй бол автозам эзэмшигчид нь хүнд жинтэй ба

/эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн маршрутыг зөвшилцөхийг татгалзаж байгаагаа эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний маршрутыг татгалзах, эсвэл эхлэл ба төгсгөл нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон өөр маршрутаар өөрийн автозамаар явахыг зөвшөөрөх, хэрвээ автомашины шинж чанар, эсвэл автозамыг огтолж байгаа инженерийн байгууламж, шугам сүлжээ нь хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон чиглэлд (инженерийн шугам сүлжээний байгууллагын мэдээллээр) саад учруулахаар бол эрх бүхий байгууллагад энэ тухай мэдээлнэ.

18. Нэг тэнхлэг дээрх эсвэл тэнхлэгүүдийн бүлэг дээрх ачаалал зөвшөөрөгдөх хэмжээнээс 2 хувиас дээш, гэхдээ 10 хувиас илүүгүй ачаалал бүхий хүнд жинтэй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь хялбаршуулсан журмаар тусгай зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллагын тогтоосон эсвэл, тогтмол чиглэлд байвал өргөдлийг бүртгэн авсан өдрөөс ажлын нэг өдрийн дотор тухайн тогтоосон чиглэл, эсвэл тогтмол чиглэлээр явахад хүнд жинтэй тээврийн хэрэгслээс учруулах хор хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээний тухай лавлагааг автозам эзэмшигчид ирүүлнэ.

19. Тухайн эзэмшигчийн автозам дээр тогтсон эсвэл тогтмол маршрут бүхлээрээ байрлаж байвал тусгай зөвшөөрлийг тогтсон ба /эсвэл/ тогтмол чиглэлийн дагуу тухайн автозамын эзэмшигч эсвэл эрх бүхий байгууллага хялбаршуулсан журмаар олгох тохиолдолд өргөдлийг бүртгэж авсанаас хойш ажлын нэг өдрийн хугацаанд өргөдөлд заасан шуудангийн хаяг, цахим шуудан, утсаар өргөдөл гаргагчид хүнд жинтэй тээврийн хэрэгслээс учруулах хохирлын нөхөн төлбөрийн хэмжээний талаар мэдээлнэ.

20. Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тогтсон ба /эсвэл/ тогтмол маршрутад тусгай зөвшөөрлийг хялбаршуулсан журмаар олгох үед тухайн маршрут нь хэд хэдэн автозам эзэмшигчийн автозамаар явж байвал тэдгээр автозам эзэмшигчид хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын нэг өдрийн хугацаанд эрх бүхийн байгууллага руу авто замд хүнд жинтэй тээврийн хэрэгслээс учруулах хохирлын нөхөн төлбөрийн нэхэмжлэхийг илгээнэ. Эрх бүхий байгууллага нь өргөдлийг хүлээн авсанаас хойш ажлын хоёр өдрийн хугацаанд өргөдөл гаргагчид хүнд жинтэй тээврийн хэрэгслийн учруулах хохирлын нөхөн төлбөрийн хэмжээний талаар мэдээлнэ.

21. Нийт жин нь зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү ба /эсвэл/ нэг тэнхлэг дээрх эсвэл тэнхлэгүүдийн групп дээрх ачаалал нь зөвшөөрөгдөх ачааллаас 10 хувиас дээш их бол хүнд жинтэй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг эрх бүхий байгууллагаас тогтоосон ба /эсвэл/ тогтмол чиглэлийн дагуу тусгай зөвшөөрлийг олгож байгаа бол өргөдлийг бүртгэж авсанаас хойш ажлын дөрвөн өдрийн хугацаанд автозам эзэмшигчид тухайн тогтоосон /эсвэл/ тогтмол чиглэлийн дагуу хүнд жинтэй тээврийн хэрэгслээс учруулах хохирлын хэмжээний талаарх хүсэлтийг илгээнэ.

Энэ зүйлд заасан хүсэлтийг автозамын эзэмшигч нь хүлээн авсан өдрөөс хойш ажлын нэг өдрийн дотор бүртгэж авах бөгөөд хэлтсийн мэдээллийн системийг ашигладаг бол системд бүртгэж авах ёстой.

**V. Хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хөдөлгөөн зохион байгуулалтын болон тусгай зураг төсөл боловсруулах, автозамын техникийн нөхцөл байдлын үнэлгээ, автозам, түүний хэсгүүд, түүнчлэн инженерийн байгууламж, шугам сүлжээтэй огтлолцох үед хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай маршрутыг зөвшилцөх үеийн онцлогууд**

22. Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хөдөлгөөн зохион байгуулалтын байгууллагын зураг төсөл боловсруулах, тусгай зураг төсөл хийх, авто замын техникийн нөхцөл байдлын үнэлгээ, авто зам, тэдгээрийн хэсэгт зохицуулалт хийх, авто замыг инженерийн байгууламж, шугам сүлжээг огтлох тусгай арга хэмжээ авах эсвэл бэхэлж



сайжруулах,

шаардлагатай тохиолдолд хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн чиглэлийг зөвшилцөх хүсэлтийг бүртгэж авсан өдрөөс хойш ажлын нэг өдрийн дотор зам эзэмшигч энэ тухай эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

23. Өргөдөл гаргагчид энэхүү Журмын 18-д заасан, мэдээллийг өгсөнөөс өргөдөл гаргагч нь тэрхүү мэдээллийг хүлээж авсанаас хойш ажлын таван хоногийн хугацаанд эрх бүхий байгууллагад шаардлагатай бичиг баримтыг танилцуулах, /эсвэл/ шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэхийг зөвшөөрч байгаагаа мэдэгдэнэ.

24. Автозамтай огтлолцож буй инженерийн байгууламж, шугам сүлжээний эзэмшигчтэй зөвшилцсөн замын хөдөлгөөний зохион байгуулалтын төслийн боловсруулалт, автозамын техникийн нөхцөлийн дүгнэлт, инженерийн байгууламж, шугам сүлжээг хамгаалах тусгай арга хэмжээний талаар мэдээллээр өргөдөл гаргагчийг тэгш хангана.

Автозамын техникийн нөхцөлийн дүгнэлт, автозам инженерийн байгууламж, шугам сүлжээтэй огтлолцож байгаа хэсэгт авах тусгай арга хэмжээг авах ажлууд тэдгээрийн эзэмшигчтэй тохиролцсоны үндсэн дээр хийгдэнэ.

25. Автозамтай огтлолцож буй инженерийн байгууламж, шугам сүлжээний эзэмшигч нар замын хөдөлгөөн зохион байгуулалтын зураг төсөл, /эсвэл/ тусгай зураг төсөлтэй танилцах, түүнчлэн автозамын техникийн нөхцөлийг болон автозамын огтолж буй инженерийн байгууламж, шугам сүлжээний тусгай арга хэмжээ авах талаар зөвшилцөх асуудлыг ажлын таван хоногоос хэтрэхгүй хугацаанд гүйцэтгэнэ.

26. Автозам эсвэл түүний хэсгүүдийн техникийн нөхцөлийн дүгнэлт /эсвэл/ автозам түүний хэсгүүдийг хамгаалах /хүчитгэх/, эсвэл тэдгээрийн хэсгүүдийг тоноглох тусгай арга хэмжээ авсны дараа автозам эзэмшигч нар эрх бүхий байгууллагад хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн өргөдөлд тусгасан чиглэлийн зөвшилцлийг хүнд жинтэй тээврийн хэрэгслээс үүдэх хохирлын нөхөн төлбөрийн тооцооны хамт явуулна.

27. Автозамын болон автозамыг огтлох инженерийн байгууламж, шугам сүлжээний онцлог шинж чанарууд нь өргөдөлд заасан маршрутын дагуу хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг гүйцэтгэх нөхцөлийг хангахгүй бол автозам эзэмшигчид нь эрх бүхий байгууллага руу хүсэлтийг биелүүлэхээ татгалзаж буйгаа мэдэгдэнэ.

## **VI. Тусгай зөвшөөрлийн олголт**

28. Эрх бүхий байгууллага энэхүү Журмын дагуу хянан хэлэлцсэн зөвшилцлүүдийг хүлээн авсаны дараа өргөдөл гаргагчид хүнд жинтэй тээврийн хэрэгслээс автозамд учруулах хохирлын нөхөн төлбөрийн хэмжээний тухай мэдээлнэ.

29. Хүнд жинтэй тээврийн хэрэгслээр учруулсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээний талаарх мэдээллийн хамт эрх бүхий байгууллага өргөдөл гаргагчид энэхүү төлбөрийн нэхэмжлэхийг илгээдэг.

30. Тусгай зөвшөөрөл олгохоос өмнө ажлын нэг өдрийн дотор хүсэлт гаргагчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу тээврийн хэрэгслийн чиглэлийг Замын хөдөлгөөний улсын байцаагчтай зөвшилцөх шаардлагагүй бол өргөдөлд заасан тээврийн хэрэгслийг техникийн шинж чанар, жин, хэмжээсээрээ ижил төстэй тээврийн хэрэгслээр сольж болно.

31. Холбооны гүйцэтгэх байгууллага болон холбооны улсын байгууллагуудын бүртгэлтэй тээврийн хэрэгслийн хувьд тэдгээрт Монгол улсын хууль тогтоомжийн дагуу цэргийн алба тусгагдсан бөгөөд өөрөө явагч машин болон бусад төрлийн тоног төхөөрөмжийн техникийн байдалд хяналт тавих төрийн байгууллагууд, (тээврийн хэрэгслийн гэрчилгээ эсвэл тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээ, өөрөө явагч машины гэрчилгээ).

32. Хүнд жинтэй болон (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн тогтоосон ба (эсвэл) байнгын маршрут байгаа тохиолдолд тухайн чиглэлд тусгай зөвшөөрөл олгох хугацаа нь өргөдөл гаргагч хүнд жинтэй тээврийн хэрэгслийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх төлбөр төлсөн

болохыг баталгаажуулснаас хойш 3 цагаас илүүгүй байх ёстой, мөн түүнчлэн Замын хяналтын улсын байцаагчийн зөвшөөрөл авсан байх ёстой.

33. Эрх бүхий байгууллага нь дараах нөхцөлд тусгай зөвшөөрлийг өгөхөөс татгалзах шийдвэр гаргана:

- 1) хувиараа бизнес эрхлэгч эсвэл хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай мэдээлэл нь өргөдөлд хавсаргасан мэдээллүүдтэй зөрөөтэй байвал;
- 2) Үл хуваагдах ачааг тээвэрлэхэд тавигдах тогтоосон шаардлагыг хангаагүй;
- 3) өргөдөлд хавсаргасан баримт бичигт заасан мэдээлэл нь тээврийн хэрэгсэл, ачааны техникийн шинж чанар, түүнчлэн мэдүүлсэн тээвэрлэлтийг гүйцэтгэх техникийн боломжтой нийцэхгүй байх;
- 4) тээврийн хэрэгслийн техникийн шинж чанар, бүртгэлийн мэдээлэл нь өргөдөлд заасантай тохирохгүй байх;
- 5) чиглэлийг зөвшилцөх үед автозамын техникийн болон хиймэл инженерийн байгууламж, шугам сүлжээний техникийн нөхцөл, түүнчлэн хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагуудтай холбоотойгоор өргөдөлд заасан техникийн шинж чанарууд тухайн өргөдөлд заасан чиглэлээр хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хийх боломжгүй нь тогтоогдсон бол;
- 6) энэхүү Журмын 22.1 зүйлд заасан зүйлүүдэд өргөдөл гаргагчийн зөвшөөрөл байхгүй бол:
  - замын хөдөлгөөний зохион байгуулалтын зураг төсөл (эсвэл) тусгай зураг төсөл;
  - автозамын техникийн нөхцөл байдлын дүгнэлт гаргах;
  - автозамын техникийн нөхцөлийн байдалд хийсэн дүгнэлтээр тодорхойлогдож, хууль тогтоомжийн дагуу хийгдсэн автозамтай огтлолцсон инженерийн байгууламж, шугам сүлжээг хамгаалах тусгай арга хэмжээ авахтай;
  - автозамын техникийн нөхцөлийн байдалд хийсэн дүгнэлтээр тодорхойлогдож, хууль тогтоомжийн дагуу хийгдсэн автозамын болон тэдгээрийн хэсгийг хамгаалахтай холбогдуулан авах тусгай арга хэмжээ, автозамын хамгаалах;
- 7) Өргөдөл гаргагч нь ХҮНД ЖИНТЭЙ тээврийн хэрэгслээр замд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх төлбөрийг төлөөгүй, уг төлбөрийг баталгаажуулсан төлбөрийн баримтын хуулбарыг өгөөгүй;
- 8) 8/ эрх бүхий байгууллагад өргөдөл, бичиг баримтуудыг факсын холбоо ашиглан илгээсэн бөгөөд өргөдөл гаргагч тусгай зөвшөөрлийн маягт хүлээн авахаар ирэхдээ өргөдлийн эх хувь, хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн схем зураг, түүнчлэн тээврийн хэрэгслийн баталгаажуулсан бүртгэлийн баримт бичиг энэ журмын 9 дэх хэсгийн 2, 10 дахь хэсэгт заасны зэргийг авчраагүй;
- 9) 9) тогтоосон хугацаанд зөвшөөрөл гараагүй, эсвэл зөвшилцсөн байгууллагын болон автозам эзэмшигчийн зөвшилцөлд татгалзсан хариу ирсэн бол;
- 10) 10) өргөдөлд заасан тээвэрлэлт хийх хугацаа өнгөрсөн.

Эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэр гарсанаас ажлын нэг өдрийн хугацаанд тухайн өргөдөл гаргагчийн сонгосон холбоо мэдээллийн аргаар тухайн шийдвэрийг гаргах болсон үндэслэлийг зааж мэдэгдэнэ.

Эрх бүхий байгууллага энэ зүйлийн 1, 2 дахь дэд зүйлд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд өргөдөл гаргагчийн сонгосон холбоо мэдээллийн аргаар тухайн шийдвэрийг өргөдлийг хүлээн авсанаас хойш ажлын дөрвөн өдрийн дотор мэдээлнэ.

34. Тусгай зөвшөөрлийг зөвхөн тухай автозамын эзэмшигчийн тодорхойлсны дагуу, харгалзах зөвшилцлүүд нь хугацаандаа өгөгдсөн бол өргөдлийг бүртгэж авсан өдрөөс хойш ажлын 11 өдрөөс хэтрэхгүй хугацаанд, тээврийн хэрэгслийн маршрутыг улсын яналтын байцаагчтай зөвшилцөж олгох бол өргөдлийг бүртгэж авсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн хугацаанд, харин тусгай зөвшөөрлийг тогтоосон маршрутын дагуу /эсвэл/ тогтмол чиглэлийн дагуу хялбаршуулсан журмаар олгох бол- өргөдлийг бүртгэж авсан өдрөөс ажлын 2 өдрийн хугацаанд олгоно

35. Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд замын хөдөлгөөн зохион байгуулалтын зураг төсөл болон тусгай зураг төсөл боловсруулах, автозамын техникийн нөхцөлийн дүгнэлт гаргах, автозамын болон тэдгээрийн хэсгийг хамгаалах, бэхлэх, түүнчлэн автозамыг огтлох инженерийн байгууламж, шугам сүлжээг хамгаалах зэрэг тусгай арга хэмжээг авах шаардлагатай бол тусгай зөвшөөрлийг олгох хугацаа дээр заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хугацаагаар хойшлогдоно.

36. Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд өргөдөл өгсөн тээврийн хэрэгсэл нь онцгой нөхцөл байдлыг арилгах, мөн телевизийн суваг, радиосуваг мэдээллийн бусад хэрэгслийн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл /үндсэн болон туслах тээврийн хэрэгсэл, тэдгээрийн ачаа нь зураг авах, зураг бичлэгийг шууд дамжуулах тоног төхөөрөмж, эрчим хүний цогцолбороос бүрдсэн телевизийн хөдөлгөөнт станц/ бол эрх бүхий байгууллага өргөдлийг өгсөн өдрөөс үзэж судална.

## **VII. Тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгох**

37. Энэхүү Журмын 6 дугаар зүйлийн 2-т заасанчлан өргөдөл болон түүнд хавсаргасан бичиг баримтыг гаргахад:

- тусгай зөвшөөрөл цахим хэлбэрээр олгогдоно;

Энэхүү Журмын 17, 18.1, 18.4-д заасан хугацаа хугацаанууд нь ажлын хоёр өдөр болно. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зөвхөн улсын чанартай автозамаар явах бол тусгай зөвшөөрлийг тогтсон хугацаанд нь буюу ажлын дөрөв хоногоос хэтрэхгүй хугацаанд олгох бөгөөд шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгслийн маршрутыг улсын авто тээврийн байцаагчтай зөвшилцөх бол – ажлын зургаан өдөрт (энэ Журмын V бүлэгт заасны дагуу хүнд жинтэй ба (эсвэл) том оврын тээврийн хэрэгслийн маршрутыг зөвшилцөхөөс бусад тохиолдол) олгоно.

Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн маршрутыг бүс нутгийн, хот хоорондын, орон нутгийн чанартай болон автозам эзэмшигчидтэй зөвшилцөх болон /эсвэл/ хувийн эзэмшлийн автомашины эзэмшигчтэй зөвшилцөх бол тусгай зөвшөөрлийг олгох хугацаа энэхүү Журмын 18.1-д заасан хугацаагаар сунгагдана.

Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн маршрутыг автозамыг огтолж буй инженерийн байгууламж, шугам сүлжээ эзэмшигчидтэй зөвшилцөх бол энэхүү Журмын 18.2 -д заасан тусгай зөвшөөрлийг олгох хугацаа нь тэдгээр зөвшилцлийг хийх хугацаагаар сунгагдана.

38. Энэхүү Журмын 42 дугаар зүйлд заасанчлан өргөдөл хувийн кабинетаас /хувийн мэдээллийн сан/-аас цахим хэлбэрээр өгөгдөнө.

39. Хүнд жинтэй ба /эсвэл/ том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд Энэхүү зүйлд заасан тохиолдолд өргөдлийг цаасан хэлбэрээр өгч, тусгай зөвшөөрлийн дараагийн бичиг баримт бүрдүүлэхэд цахим хэлбэрээр өгч болно.

40. Тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр хувийн кабинетаар дамжуулан өгөхөд дараах мэдээллийг багтаах ёстой:

- матрицийн (хоёр хэмжээст) зураасан код (QR код);
  - тусгай зөвшөөрлийн дугаар;
  - тусгай зөвшөөрлийг бүрдүүлсэн огноо;
  - зөвшөөрөгдсөн аяллын тоо (хүнд жинтэй тээврийн хэрэгслийн тухайд)
  - аяллыг хийх хугацаа;
  - хөдөлгөөний маршрут;
  - тээврийн хэрэгслийн мэдээлэл: марк, загвар, улсын бүртгэлийн дугаар, таних дугаар;
  - тээврийн хэрэгсэл эзэмшигчийн мэдээлэл:
  - хуулийн этгээдийн хувьд – компанийн нэр, байршлын хаяг, утасны дугаар;
  - хувь хүн, хувиараа бизнес эрхлэгчийн хувьд- овог нэр, оршин суух газрын хаяг, утасны дугаар
  - ачааны шинж чанар (ачаа байгаа бол):
  - ачааны нэр, овор хэмжээ (урт, өргөн, өндөр, жин);
  - тээврийн хэрэгслийн хэмжээсүүд (автопоезда):
